# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

| № | Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг | Зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/ | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ.МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| Зорилт 1.Эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг дээшлүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 1.1 | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030 /цаашид “МУТХҮБ-2030” гэх/-ын 2.1 дэх заалт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /цаашид “ЗГҮАХ” гэх/-ийн 1.1, 1.2 дахь заалт | Татварын орчныг шинэчлэх замаар хөрөнгө оруулалтыг дэмжиж эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах | Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид “ДНБ” гэх/-ний бодит өсөлт, хувиар | 8.0 | | **Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 онд 5.1 хувиар өслөө.** **2019 онд хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 8.4 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмэр хоёр дахин нэмэгдэж, 1.1 нэгж хувь болжээ.** 2018-2019 оны өвөлжилт өнтэй байсантай холбоотойгоор том малын зүй бус хорогдол 50 орчим хувиар буурч, төл бойжилт өндөр байсан нь тус салбарын үйлдвэрлэл өсөхөд нөлөөлөв. **Уул уурхайн салбар 2018 оны эдийн засгийн өсөлтийн 1.35 нэгж хувийг бүрдүүлж байсан бол 2019 онд -0.12 нэгж хувь болж буурсан байна.** | 70 |
| 1.2 | МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.4 дэх заалт | Зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэж, хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх | Ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар | 64.0 | 0.979 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тодорхойлох Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа болон их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлт, ажлын байранд зуучлагдаж буй хэлбэр, хугацаа, ур чадварын нийцэл, түүнчлэн ажлын байранд тулгарч буй бэрхшээл болон ажилгүй байгаа шалтгаан зэргийг бодитойгоор илрүүлэх Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг жил бүр Хөдөлмөр, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийгмийн хамгааллын судалгааны институт хийж байна. Уг судалгааны үр дүнг их дээд сургуулиудад таниулж сурталчлахаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлтийн бодлогод баримтлан ажиллаж байна.<br>Хөдөлмөрийн зах зээлд эрэлтэд нийцсэн ажиллах хүчнийг бэлтгэх зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад сар бүр 100.0 мянган төгрөгийн тэтгэлгийг 2019 оны 01 дүгээр сараас олгож эхэлсэн. Уг тэтгэлгийг 2019 онд олгоход Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 41.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөн хэрэгжүүлсэн.<br>Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй ажил, мэргэжлийг ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр дамжуулан хүргэж байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг 2019 онд хэрэгжүүлэхэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 940.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын байдлаар 118.5 мянган иргэнд ганцаарчилсан болон бүлгээр хүргээд байна. Уг үйлчилгээний цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018-2019 оны хичээлийн жилд 24 оюутныг танхим болон зайн хэлбэрээр сургаж, тус салбарын 15 албан хаагчид нийт 30.0 сая төгрөгийн тэтгэлгийг тус тус олгосон.<br>"Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт төсөл"-ийн хүрээнд ЕБС болон Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн оюутан, залууст мэргэжлээ зөв сонгох, мэргэжлийн мэдээллийг онлайн хэлбэрээр хүргэх зорилго бүхий WWW.MERGEJIL.MN цахим хуудас, мобайл аппликэйшнийг бий болгож ажил, мэргэжлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулж, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулж байна. | |
| | | | Ажилгүйдлийн түвшин, хувиар | 7.5 | | Ажиллах хүчний түүвэр судалгааны 2019 оны 3 дугаар улирлын дүнгээр ажиллах хүчний оролцооны түвшин 60.1 хувьтай, ажилгүйдлийн түвшин 9.9 хувьтай байна. | |
| Зорилт 2.Макро эдийн засгийн эрсдэл даах чадавхыг дээшлүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангана. | | | | | | | |
| 2.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 1, | Төсвийн зарцуулалтыг оновчтой | Нэгдсэн төсвийн алдагдлын | 6.1 | | 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 627.8 тэрбум төгрөгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ЗГҮАХ-ийн 1.4 дэх заалт | болгох, зардлын менежментийг шинэтгэх замаар төсвийн алдагдлыг бууруулж, төсвийн бодлогын орон зай бий болгох | дээд хэмжээ, ДНБ-д эзлэх хувиар | | | алдагдалтай гарсан.<br>Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн нэгдсэн чуулганаар Дунд хугацааны 2020 оны төсвийн хүрээ, 2021-2022 оны төсвийн төсөөллийн хууль батлагдсан бөгөөд төсвийн алдагдлын хэмжээг 2020 онд 5.1 хувь, 2021 онд -2.8 хувь, 2022 онд -1.4 хувь байхаар баталсан нь төсвийн алдагдлыг бууруулах зорилготой нийцэж байна.<br>Мөн Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар төсвийн алдагдлын Дотоодын нийт бүтээгдэхүүн эзлэх хувийг 5.1 хувь байхаар баталсан.<br>Харин Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг Дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа 2019 оны урьдчилан гүйцэтгэлээр 57 хувь орчим байв. | |
| | | | Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн өрийн үлдэгдлийн дээд хэмжээ, ДНБ-д эзлэх хувиар | 55.3 | | | |
| 2.2 | МУТХҮБ-2030-ын 2.1 дэх заалт | Валютын орох урсгал өндөр үед гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх | Гадаад валютын нөөц, импортын сарын хэрэгцээгээр | 10.0-аас доошгүй | | Гадаад валютын албан нөөц 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 4 тэрбум ам.долларт хүрсэн нь импортын 9.1 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.<br>Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв.<br>1) Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга нарын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 03/3/А-5 тоот хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс 2.2 тэрбум ам.долларыг Монголбанк худалдан авч ажиллав.<br>2) Гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулж, өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор гадны харилцагч байгууллагын жагсаалтыг өргөжүүлэн зах зээлийн өрсөлдөөнт хүү болон үнэт цаасны үнэ авах боломжийг нэмэгдүүлсэн.<br>3) Цаашид гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, ирээдүйд төлөгдөх гадаад өрийн эргэн төлөлтөд бэлтгэх зорилгоор "Гадаад валютын нөөц" сэдэвт хэлэлцүүлгийг 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгээр гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх боломж, МУ-ын эдийн засгийн гадаад болон дотоод эрсдэл, сорилтууд, цаашид авах арга хэмжээний талаар төр, хувийн хэвшлийн холбогдох байгууллагууд санал солилцов.<br>4) Монголбанк алтны худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа" аяныг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монголбанк, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 6 сарын хугацаатай зохион байгуулав. 2019 оны Монголбанк 15.2 тонн үнэт металл худалдан авч, Гадаад валютын улсын нөөцийг 621 сая ам.доллароор нэмэгдүүлсэн байна. | |
| 2.3 | МУТХҮБ-2030-ын 2.1, ЗГҮАХ-ийн 1.6 дахь заалт | Төсөв, мөнгөний бодлогыг оновчтой хослуулах замаар инфляцийг зорилтот түвшинд байлгах | Инфляцийн түвшин, оны эцэст хувиар | 8.0-аас ихгүй | | Улсын инфляцын түвшин 2019 оны эцэст 5.2 хувьтай гарч зорилтот түвшнийг хангав. Инфляцын тус өсөлтөд хүнсний бараа, ундаа, ус; хувцас бөс бараа; боловсролын үйлчилгээ; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ тус бүрийн үнийн өсөлт голлох нөлөөг үзүүлсэн байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2019 оны 1-4 дүгээр улирлын ээлжит хурлуудаар инфляцын зорилттой уялдуулан эдийн засгийн нөхцөл байдал, ирээдүйн төлөв, гадаад дотоод эрсдэл, бодлогын хувилбаруудыг харгалзан үзэж бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэрүүдийг тус тус гаргасан болно. | 100 |
| 2.4 | МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.6 дахь заалт | Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин, дэд бүтцийг боловсронгуй болгож, бизнес эрхлэгчдэд хямд өртөгтэй санхүүжилт татах боломжийг бүрдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр", "Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хүрээнд Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхээр олон улсын байгууллага болох IOSCO-оос гаргасан зөвлөмжийн дагуу Европын сэргээн босголт хөгжлийн банк, хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллагууд, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон ҮЦК-уудтай хамтран Төлбөрийн-эсрэг-Нийлүүлэлт T+2 горимыг нэвтрүүлэх, "Арилжааны төлбөр тооцоо ҮЦК" ХХК-г дундын зуучлагч байгууллага болгохтой холбоотойгоор Сангийн сайдын тушаалаар байгуулсан Ажлын хэсэг ажиллаж байна. Уг ажлын хүрээнд 1)Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг СЗХ-той хамтран Ажлын хэсгийг 2) Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг "Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл" нэртэйгээр өөрчлөн боловсруулах Ажлын хэсэг тус тус байгуулан ажиллаж байна. Тус хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл Монголбанкнаас банк, санхүүгийн зах зээлд оролцогчдын хооронд олон улсын стандарт, мастер гэрээний дагуу эрсдэл бууруулах зорилгоор байгуулдаг санхүүгийн үүсмэл хэрэгсэл, буцаан худалдах, худалдан авах нөхцөлтэй санхүүжилтийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг сайжруулахтай холбоотой саналыг 2019 оны 3 сарын 4-ны өдрийн А-/198 дугаар албан бичгээр | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн. Түүнчлэн Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)-ны техникийн хамтын ажиллагааны төсөл "Монгол Улсын Мөнгөний болон Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх баримт бичиг боловсруулах" төслийн хүрээнд үнэт цаасны төлбөр, тооцооны Төлбөрийн эсрэг Нийлүүлэлт (Delivery versus Payment) зарчим, дараа төлбөрт тооцооны T+2 горимыг нэвтрүүлэх төсөл хэрэгжсэн бөгөөд санал, зөвлөмжүүд гарсан. 2019 онд "Монгол даатгал" хувьцаат компани хэлбэртэй болж, Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаа нээлттэй арилжаалагдсан.<br>Мөн "Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл" (SFFS)-ийн хүрээнд Монгол улсын санхүүгийн үүсмэл хэрэгслийн болон бусад ханшийн эрсдэлээс хамгаалах хэрэгслийн эрх зүйн орчныг судалж, холбогдох хууль тогтоомжид санал боловсруулах үүрэг бүхий дотоодын зөвлөхийг шалгаруулан ажиллуулж байгаа ба хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн шинэчлэлийн ажлын хэсгийг байгуулсан болно. | |
| 2.5 | МУТХҮБ-2030-ын 2.1 дэх хэсэг | Банк, санхүүгийн тогтолцооны эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох, түүнд хяналт тавих журмыг шинэчлэн батлаад байна. Уг журмаар банкнуудын 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлэх талаар өөрчлөлтийг оруулсан.<br>Банк, санхүүгийн тогтолцооны эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкнаас банкнуудад хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, аргачлал болон тавигдах шаардлагыг өөрийн орны болон Олон улсын Базелийн стандарттай нийцүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд дараах үндсэн журам, зааврыг нэмж өөрчлөх, шинэчилж найруулах ажлууд хийгдэж байна. Үүнд:<br>- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019.05.23-ны өдрийн А-138 дугаар тушаалаар Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журмыг баталсан бөгөөд журамд өөрийн хөрөнгөд тавигдах шаардлагыг чангатгах, доод шаардлагын хувь хэмжээг олон улсын стандарттай нийцүүлэн өөрчилсөн.<br>- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019.02.12-ны өдрийн А-36 дугаар тушаалаар Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмыг баталсан бөгөөд журамд банкнуудын зээл болон бусад эрсдэлтэй активын төвлөрлийн эрсдэлд | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хязгаар тогтоох, оновчтой удирдах харилцааг зохицуулсан.<br>- Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам", "Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам", "Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"-ын шинэчилсэн найруулгыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А-82 дугаар тушаалаар баталсан.<br>- Банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмыг олон улсад тавигдах стандарт болон ОУВС-ийн хөтөлбөрт тавигдах шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулсан бөгөөд Захиргааны Ерөнхий хуульд заасан процессын дагуу батлах ажлыг үргэлжлүүлж байна.<br>- ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны хяналт шалгалтын үйл ажиллагаа, аргачлалыг боловсронгуй болгох зорилгоор хэрэгжүүлж буй техник туслалцааны ажлын төлөвлөгөөнд Базел стандартын дагуу банкнууд өөрийн хөрөнгийг дотооддоо үнэлэх журам боловсруулах ажлыг 2020 оны 3 дугаар сараас эхлүүлэхээр тусгасан. Иймд журмын төслийг боловсруулах, боловсронгуй болгох, банкнуудын төлөөлөлтэй уулзалт, ярилцлага зохион байгуулж, саналыг тусгах ажлууд хийгдэж байна.<br>Хяналт шалгалтын чиг үүргийн дагуу 2019 онд нийт 9 банканд ээлжит газар дээрх иж бүрэн шалгалт болон бүх банкнуудад хэсэгчилсэн шалгалтыг хийж, банкнуудын үйл ажиллагаа, эрсдэл даах чадварт нь хяналт тавьж байна.<br>Монголбанкнаас "Хариуцлагатай харилцагч-хариуцлагатай банк" аяныг эхлүүлэн 2019 оны 6 дугаар сарын 12-д нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Аяны хүрээнд Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпорац, арилжааны банкнууд, Монголбанкны орон нутгийн салбарууд, банкнуудын салбар нэгжүүд идэвхтэй оролцож хамтран ажиллаж байна. Оролцогч байгууллагууд дотооддоо үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг батлан, биелэлтийг Монголбанкинд тодорхой давтамжтайгаар ирүүлж байна.<br>Монголбанкнаас "Банкны салбарыг чадавхжуулах дунд хугацааны хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, УИХ-аар батлуулахаар зорьж байна.<br>Үнэт цаасны мэргэжлийн оролцогчдын хувь нийлүүлсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгийн хэмжээнд тавигдах шалгуур болон төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих зохицуулалтууд "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм"-ийг Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4184 дугаарт бүртгүүлсэн.<br>"Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-д Төв ХЗХ, тогтворжилтын сан, хадгаламжийн даатгал, татан буулгах зохицуулалтуудын талаар холбогдох өөрчлөлтийг оруулсан.<br>ХЗХ-дод зайнаас эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын төслийг боловсруулж, АХБ-ны төслийн хүрээнд ОУ-ын болон үндэсний зөвлөхүүдтэй хамтран эрсдэлд суурилсан хяналт шалгалтын гарын авлага боловсруулан уг аргачлалын дагуу 2019 оны хагас жилийн байдлаар үйл ажиллагаа эрхэлж буй 275 ХЗХ-дын Хороонд ирүүлсэн 2016, 2017, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлтэд тулгуурлан эрсдэлийн үнэлгээ хийж, 5 түвшинд тодорхойлж, эрсдэлийн хандлага, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан зайны хяналтаар илрүүлсэн эрсдэлийг газар дээр нь бодитоор тогтоох, эрсдэлийн хүчин зүйлд чиглэсэн үнэлгээ өгөх, турших зорилгоор Хорооны даргын 2019 оны 346, 398, 470 дугаар тушаалуудаар баталсан удирдамжийн дагуу Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудын нэр бүхий 31 ХЗХ-дын үйл ажиллагаанд газар дээрх хэсэгчилсэн хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.<br>Санхүүгийн зохицуулах хороо Дэлхийн банкны Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөлтэй хамтран Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох хүрээнд Олон улсын зөвлөхөөс өгсөн даатгалын салбарын холбогдох журам, зааврыг сайжруулах талаар өгсөн санал дүгнэлт, зөвлөмжийг авч тус төслөөс зохион байгуулсан "Эрсдэлд суурилсан хөрөнгө буюу RBC" болон "Давхар даатгал" сэдэвт сургалтад оролцож, даатгалын компаниудын эрсдэл даах чадварыг үнэн зөвөөр тооцох, цаашид түүнийг хэрхэн сайжруулах талаар санал солилцон "Эрсдэлд суурилсан хөрөнгө" (RBC) арга аргачлалын дагуу даатгалын компаниудын төлбөрийн чадварыг тооцож, нэвтрүүлэхээр даатгалын 17 компаниас ирүүлсэн 2018 оны жилийн эцэс, 2019 оны 1, 2, 3 дугаар улирлын нийт 60 санхүүгийн болон нэмэлт тайлан, бусад мэдээлэлд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үндэслэн эрсдэлийг үнэлэн тайлангийн хариугаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажилласан.<br>Байгууллагын эрсдэлийг үнэлэх үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгосноор зайны хяналт шалгалтыг сайжруулж, байгууллагын эрсдэлийн үнэлгээг зайнаас үнэлэн, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлж эхэлсэн. 2019 оны төлөвлөгөөнд өндөр эрсдэлтэй гэж дүгнэгдсэн 225 байгууллагад "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх" (МУТСТ) чиглэлээр газар дээрх хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 113 байгууллагад газар дээрх хяналт шалгалт хийж, 112 байгууллагад бүтцийн болон бизнесийн эрсдэлд үндэслэн зайны хяналт хийж, илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн албан шаардлага (УБАШ), зөвлөмж хүргүүлж, 8 байгууллагад торгох арга хэмжээ авч ажилласан.<br>"Монголын даатгагчдын холбоо"-той хамтран даатгалын компаниудын эрсдэлийн менежер, нягтлан бодогч, актуарчтай уулзалт зохион байгуулж, даатгагчийн өөрийн эрсдэлээ тооцох аргачлал /ORSA/-тай холбоотой зөвлөгөө өгч ажилласан.<br>ОУВС-гийн зөвлөсний дагуу Монгол банк нь санхүүгийн зах зээл, эдийн засгийн хямралаас урьдчилан сэргийлэх зорилгоор арилжааны банкнуудын хэрэглээний зээлд хязгаар тогтоох бодлогыг хэрэгжүүлж байгаа ба уг бодлогыг банк бус санхүүгийн байгууллагууд дээр хэрэгжүүлэхэд өнөөгийн зээлийн нөхцөл байдлыг судлан, цаашид тэдгээрийн хэрэглээний зээлд хязгаар тогтооход үүсэж болох хүндрэл бэрхшээл болон боломжийн талаар судалгаа хийсэн. | |
| 2.6 | "Гурван тулгуурт хөгжлийн бодлого" /цаашид ГТХБ гэх/-ын 2.1.3 дахь заалт | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 0.67<br>Гадаад эх үүсвэр | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр 2019 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 22.3 дахь хэсэгт "Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө" гэж заасны дагуу Үндэсний хөгжлийн газар, Азийн хөгжлийн банктай хамтран МОН ТА-9371:"Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төсөл"-ийг Азийн хөгжлийн банкны техникийн тусламжийн тусгай сангийн 500.0 мянган ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2018 оны 3 дугаар сарын 13-аас 2019 оны 12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 6-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн.<br>- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн сангийн систем хөгжүүлэх компаниар "Ай түүлс" ХХК сонгогдож, Орон нутгийн хөгжлийн индекс /ldi.nda.gov.mn/, Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн систем /ndustry4.nda.gov.mn/, Судалгаа шинжилгээний мэдээллийн систем /development.gov.mn/, Төсөл хөтөлбөрийн мэдээллийн систем, Бодлогын баримт бичгийн мэдээллийн систем гэсэн 5 системийг холбосон Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем үүсгэн байгуулсан.<br>- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт "... мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална." гэж заасны дагуу "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам"-ыг Үндэсний хөгжлийн газрын даргын 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн А-158 дугаар тушаалаар баталсан.<br>- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн системийн үндсэн хэрэглэгчдийн чадавх бэхжүүлэх сургалтыг 2019 оны 9 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулж, системийн бүтцийг танилцуулан санал, зөвлөмж авсан. Энэхүү сургалтад салбар яамдын бодлого төлөвлөлт хариуцсан газар, хэлтсийн албан хаагчид болон 21 аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтэн зэрэг 81 албан хаагчийг хамруулж сертификат олгосон.<br>- "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх" төслийн хаалтын хэлэлцүүлгийг 2019 оны 12 дугаар сарын 6-ны өдөр Үндэсний хөгжлийн газрын BIG DATA төвд зохион байгуулж тус системийг ашиглалтад оруулсан. Ингэснээр уг системээр дамжуулан үндэсний, салбарын болон орон нутгийн түвшний бодлого боловсруулагч нарт урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулах, төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг сүүлийн үеийн мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан интернэт орчинд нэгдсэн байдлаар авах боломжоор хангасан. Системийн үндсэн хэрэглэгчээр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | яамд, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшний төрийн байгууллага бүрд 3 үндсэн хэрэглэгчийн эрхийг нээсэн бөгөөд системээр дамжуулан цаашид хөгжлийн бодлогын баримт бичгээ боловсруулах, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтээс санал авах үйл ажиллагаа явуулна. | |
| 2.7 | МУТХҮБ-2030-ын 2.1 дэх хэсэг | Зээлийн хүүг бууруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг эрчимжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Монголбанкнаас 2018 онд "Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023" баримт бичгийг баталсан бөгөөд энэ хүрээнд макро эдийн засгийг тогтворжуулах, мөнгөний бодлогын хүүгийн шилжих нөлөөг сайжруулах, банкны эрсдэлийн удирдлага, засаглалыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авсны үр дүнд 2019 оны 11 сарын байдлаар зээлийн хүү 2017 оны эцсээс 2 нэгж хувиар буураад байна.<br>Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн орчныг олон улсын жишигт нийцүүлэх замаар зах зээлийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 149 дүгээр тушаалаар "Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд DvP/T+2 буюу "Төлбөрийн эсрэг нийлүүлэлт" олон улсын зарчмыг нэвтрүүлэх" хамтарсан ажлын хэсэгт байгуулсан. Ажлын хэсэг ҮЦ ТХТ, АТТ ХХК-ийн зүгээс "Төлбөр гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэх журам", "Үнэт цаасны клирингийн журам"-уудын төслийг боловсруулж, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг хэрэгжүүлэхээр дэд бүтцийн байгууллагууд дээр тестийн ажил хийгдэж байна.<br>ББСБ-уудын зээлийн хүүгийн мэдээллийг улирал бүр нэгтгэн, олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүний талаарх мэдээллийг http://frc.gov.mn/ цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж байна. Гадаад улс орнуудын зээлийн хүүг тогтоож буй байдлаар "Зээлийн хүүгийн тааз"-ын судалгааг хийж гүйцэтгэсэн.<br>ХЗХ-ны салбарт үүсээд байгаа нөхцөл байдлын талаарх судалгааг хийж, дүгнэлт гарган ХЗХ-дын зээл олголт, төлөлтийн хэмжээ, зээлийн хүү, татан төвлөрүүлсэн, буцаан олгосон хадгаламжийн хэмжээ болон хадгаламжийн хүүгийн судалгааны нэгтгэл тайланг тус тус ФинА системд татах өргөтгөл шинээр үүсгэсэн. | 70 |
| **ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО** | | | | | | | |
| Зорилт 3.Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 2, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /цаашид ТХХААТББ гэх/-ын 4.1.13 дахь заалт, ЗГҮАХ-ийн 1.23, 2.20, 2.23, 2.48. дахь заалт, | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо /Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хууль, Хоршооны тухай хууль, Таримал ургамлын үр сортын тухай хууль/ | 3 | 0.015 Улсын төсөв | Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төслийн тандан судалгаа, үзэл баримтлалын төслийн эхний хувилбарыг ажлын хэсгээс нарийвчлан судлах шаардлагатай гэж үзэн зөвлөх үйлчилгээ авахаар шийдвэрлэж, үнийн санал ирүүлэх урилгыг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.<br>Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгаа, ажлын хэсэг болон олон нийтийн хэлэлцүүлгийг хийж гүйцэтгэн УИХ-ын гишүүн Л.Элдэв-Очир гишүүнд хүлээлгэн өгсөн. Хуулийн төслийг УИХ-ын гишүүн Л.Элдэв-Очир нарын гишүүд өргөн барихаар бэлтгэж байна.<br>Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. | 40 |
| 3.2 | ЗГҮАХ-ийн 2.25 дахь заалт | Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийх, мал аж ахуйн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, түүний техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх | Малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийх сум, дүүргийн тоо | 339 | 0.397 Улсын төсөв 108.3 Гадаад эх үүсвэр | Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлын хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэв.<br>1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын тушаалаар А-133 дугаар тушаалаар 14 аймгийн 248 сумын 536.0 мянган малд төлөв байдлыг үнэлэх, тодорхойлох ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, мал үржүүлэг технологийн хавар, намрын технологит хугацаанд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 31 нэгжийн хүрээнд 43 ажлын хэсгийн 220 мэргэжилтэн мал сүрэгт төлөв байдлын үнэлгээг хийж гүйцэтгэв.<br>2. НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын "Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэхэд дэмжлэг үзүүлэх нь" техник туслалцааны төслийн хүрээнд Хөдөө аж ахуй их сургуулийн Мал аж ахуйн биологийн сургууль, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал зүйч үржүүлэгчдийн холбоо ТББ, 21 аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар Мал үржлийн албаны дарга нарт 50 мал зүйчдэд мэргэжил, арга зүйн сургалтыг зохион байгуулав. Мөн төслийн хүрээнд мэргэшсэн шинжээч мал зүйн багтай хамтран "Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх арга зүй эзэмшүүлэх" сургалтыг 21 аймаг, нийслэлийн Мал үржлийн алба, 332 сум, 6 дүүргийн Хөдөө аж ахуйн тасаг, Мал үржүүлэг технологийн хувийн нэгжийн 420 мал зүйн мэргэжилтнийг хамруулан орон нутагт нь зохион | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллаа.<br>3. Малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ, үр дүн, тайланг мэргэшсэн шинжээчийн багийн 12 зөвлөх мал зүйчтэй хамтран гаргаж, цаашид авах арга хэмжээний саналыг 7 багц болгон нэгтгэж, үүний хүрээнд зах зээлийн эрэлтэд мал аж ахуйн салбарын бүтээмжит чадварыг нийцүүлэх, мал, малын гаралтай бүтээгдэхүүний эдийн засгийн эргэлтийг түргэсгэх арга хэмжээг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх боломж нээгдэж байна гэсэн дүгнэлтийг гаргасан болно. Мөн төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг төрийн бодлогоор тогтоож, ашиг шимийн чиглэлээр сонгон үржүүлэх, генетик нөөцийг бататган сайжруулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг Улсын Их Хуралд танилцуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна. | |
| | | | Мэдээллийн онлайн системийг бүрдүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх сум, дүүргийн тоо | 339 | 0.7 Улсын төсөв | 1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын А-163 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үржилд ашиглаж буй хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч малыг ялган тэмдэглэх, малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг 7 аймаг, нийслэлийн мал бүхий 3 дүүргийн нийт 95.7 мянган малд гүйцэтгэхээр Хүнс, хөдөө аж ахуйн газартай гэрээ байгуулж, 10.2 мянган бух, 28.2 мянган хуц, 17.2 мянган ухна, 8.1 мянган үнээ, 23.0 мянган эм хонь, 9.0 мянган эм ямаа , нийт 95.9 мянган малыг ялган тэмдэглэж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.<br>2.Мал эмнэлгийн ерөнхий газрын 2019 оны төлөвлөгөөний хүрээнд Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн гоц халдварт өвчингүй, эрүүл бүсэд хамаарах Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх дүүрэгт үржүүлж буй 35.0 мянган үхрийг ялган тэмдэглэж, мал эмнэлгийн цахим сүлжээнд бүртгэх ажлыг зохион байгуулав.<br>3.Малын удмын сангийн үндэсний төвийн харьяа орон нутгийн салбар 11 цөм сүргийн үржлийн төвийн бүртгэлд хамрагдаагүй нийт 9223 мянган малыг ялган тэмдэглэгээ хийсэн.<br>4. Францын Мал аж ахуйн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлэх "Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх" /STDF/PG/534/ туршилтын төслийн хүрээнд төсөл хэрэгжиж буй Өвөрхангай аймгийн Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга сумдын нийт 190.0 мянган малыг ялган тэмдэглэж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэлжүүлэхээр төлөвлөв. | |
| 3.3 | МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх | Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/ | 61 | 30.6 Улсын төсөв | Шүлхий өвчний эрсдэлтэй нийт 9 аймгийн 118 суманд 2 удаагийн давталттайгаар нийт 22.7 сая толгой малыг дархлаажуулалтад хамруулж, нийт 3.5 тэрбум төгрөг, Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад эрсдэл бүхий зүүн бүсийн 5 аймгийн 57 сумын нийт 5.8 сая толгой мал хамруулж, нийт 796.5 сая төгрөг, Хонины цэцгээс сэргийлэх дархлаажуулалтад зүүн бүсийн 5 аймгийн 62 сумын нийт 2.9 сая толгой хонь, хурга хамруулж, нийт 427.1 сая төгрөгийн санхүүжилтийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгоод байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар гоц халдварт өвчний хорио цээртэй аймаг, сум байхгүй ба гоц халдварт өвчний гаралтыг 2018 оны 06 дугаар сартай харьцуулахад шүлхий-90, бог малын мялзан 80 хувиар буурсан бол хонины цэцгийн гаралт буураагүй байна. Монгол улсын 21 аймаг, нийслэлд нийт 18 нэрийн халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 22.48 сая толгой мал, бруцеллёз өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 15.21 сая толгой мал хамруулсан. Халдварт, гоц халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад нийт 69 сая толгой мал хамруулсан. | 100 |
| | | | Вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулах малын тоо, мянга | 200 | | Бруцеллёз, Бог малын мялзан, Шүлхий өвчний вакцины дараах тандалтад нийт давхардсан тоогоор 22 аймгийн 72 сумын 1015 өрхийн 294.1 мянган толгой малаас дээж авч шинжилгээнд хамруулж, 85.4 хувийн дархлаа тогтсон байна. | |
| 3.4 | МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.38 дахь заалт | Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулах | Цэвэр үүлдрийн үхрийн тооны өсөлт, мянган толгой | 5 | 7.9 Хувийн хөрөнгө оруулалт | Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор Эрчимжсэн мал аж ахуйг хөгжлийг дэмжих хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан. Төлөвлөгөөнд арга хэмжээний үр дүнд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулах арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн. Беларусь улсын хөнгөлөлттэй урт хугацааны зээлээр 2019 онд сүүний чиглэлийн хар тарлан үүлдрийн 1300 толгой хээлтэй гунжийг импортлон газар тариалан, тэжээлийн аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг түшиглэн 200 болон 300 үнээний цогцолбор ферм байгуулах тухай гэрээ, хэлэлцээр хийгдсэн.<br>Махны экспортын нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсад баталгаажсан үүлдэр, омгийн малын тоо толгой өсөхөд анхаарч ажиллаа. Тухайлбал: Дорнод аймгийн | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Халхгол, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумдад цэврээр үржүүлж буй Дорнод Монголын Улаан үүлдрийн үхрийн хянан баталгаажуулсан. Тус үхэр нь зүүн бүсийн аймгийн махны хэрэгцээг 100 хувь, Монгол Улсын хэмжээний хүн амын махны хэрэгцээний 30 хувийг хангах боломжтой бөгөөд Халх гол суманд 5200, Түмэнцогт суманд 5300 цэвэр үүлдрийн үхрийг үржүүлж байна.<br>Цэвэр үүлдрийн үхрийн аж ахуй эрхэлдэг "Нүүдэлчин" ХХК нь 2019 онд 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 үнээний 2 кластер ферм байгуулсан байна.<br>Азийн Хөгжлийн банкны "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт" төслийн хөрөнгөөр Швейцарь улсаас сүүний чиглэлийн "Голштейн" (Хар тарлан), "Симменталь", мах-сүүний чиглэлийн "Brown Swiss", "Original Brounvieh", "Ангус" Улаан, махны чиглэлийн "Лиммузин" үүлдрийн өндөр ашиг шимт хүйс жолоодсон 1200 тун охин үр, 12.8 мянган тун гүн хөлдөөсөн үр, нийт 14.0 мянган тун үрийг 620.2 сая төгрөгийн хөрөнгөөр худалдан авч Малын удмын сангийн үндэсний төвд хүлээлгэж өгсөн.<br>ЖДҮХС-гаас 2019 онд сүү, махны үхрийн аж ахуйг өргөтгөхөд зориулж 40 төсөлд 3.8 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлснээр 292 шинээр ажлын байр бий болов. Дархан-Уул аймаг орон нутгийн төсөвтөө Үхрийн аж ахуйн суурьшлын бүс байгуулахад шаардлагатай 500 сая төгрөгийг тусгаж Булган аймгаас Сэлэнгэ үүлдрийн 100 толгой хээлтэгч худалдан авах бэлтгэл ажлыг хангасан байна. | |
| | | | Гахай, тахианы аж ахуйн тооны өсөлт, хувиар | 4 | 6.0 Хувийн хөрөнгө оруулалт | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан олгох зээлийн 25 хувийг Эрчимжсэн мал аж ахуйд олгох талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн шийдвэр гаргав. Ингэснээр гахай, тахианы аж ахуйг дэмжих, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн.<br>2019 оны жилийн эцсийн байдлаар 144 аж ахуйн нэгжид 13320 толгой гахай, 587 өрхийн 8026 толгой гахай тоологдсон. Нийт 21346 толгой гахай байгаагаас өмнөх оны мөн үеэс 8000 толгой гахай буурсан. Гахайн мялзан өвчин гарч 4000 толгой гахай устгалд оруулсан.<br>"Түмэн шувуут" ХК бонд гарган үйл ажиллагаагаа өргөтгөн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 120.0 мянган шувууны 3 байрыг шинээр ашиглалтад оруулж Био иодтой өндөг, Омега-3 агууламж өндөртэй өндөг зэрэг "бренд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүн"- ийг үйлдвэрлэж эхэлсэн байна. -"Зургаан хошуу" ХХК Дани улсаас цэвэр үүлдрийн 1000 мэгж, 50 бодон худалдан авах гэрээ байгуулж санхүүжилтийг нэмэгдүүлэхээр санал боловсруулж байна. Уг аж ахуйн нэгж нь фермээ Дани улсын технологиор засварлан гахай хүлээн авах байрыг засварлахад 1.5 тэрбум төгрөгийн хувийн хөрөнгө оруулалт хийсэн. | |
| | | | Зарим бүтээгдэхүүний импортыг бууруулах хувь<br>-Тахианы өндөг | 13.0 | | Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд шувууны аж ахуйн арчилгаа маллагаа, технологийн түвшин, эрчимжүүлэлтийг сайжруулах, сүрэг сэлбэх хэрэгцээнд дэгдээхэй нийлүүлэх үржлийн аж ахуйд бодлогын дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортын өндөгний хувийг бууруулах талаар тусгав.<br>2019 оны жилийн эцсийн байдлаар 160.8 сая ширхэг өндөг импортолж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.0 сая ширхэг өндгөөр өссөн дүнтэй байна. | |
| | | | -Зөгийн бал | 18.0 | 0.802<br>Гадаад эх үүсвэр | Зөгийн аж ахуйн зохион байгуулалт, үйлдвэрлэлийн технологийн түвшин, зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулан дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах ажлыг мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгэж, зорилтот зах зээлд бэлтгэн нийлүүлэх зөгийн бал, бусад дагалдах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэн, импортын зөгийн балыг 2023 онд 70.0 хувиар бууруулахаар Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан.<br>-"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил" төслийн хүрээнд 215.5 сая төгрөгийн хөрөнгөөр ХААИС-ийн Мал аж ахуй биотехнологийн сургууль, Улсын мал эмнэлгийн төв лаборатори, Мал эмнэлгийн хүрээлэнд нийт 34 нэр төрлийн зөгийн балаар эм болон ууpагт тэжээл үйлдвэрлэх зориулалт бүхий багаж, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч дээрх байгууллагуудын үйлдвэрлэлийн болон оюуны чадавхыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн.<br>-Мөн төслийн 347.4 сая төгрөгийн хөрөнгөөр зөгийн гэр 600 ширхэг, зөгийн сэмж 268 боодлыг худалдан авч Дархан-Уул, Булган, Орхон, Хэнтий, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын 26 хоршооны үйл ажиллагааг дэмжиж ажилласан. -Япон улсын ЖАЙКА-байгууллагатай хамтран Өвсний үндэс, техникийн хамтын ажиллагааны хүрээнд "Зөгийн аж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахуйн хөгжлийг дэмжих замаар орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх” төсөл Дархан, Сэлэнгэ аймагт хэрэгжиж Зөгийн балын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, зөгийчдийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулав.<br>2019 онд Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас зөгийн аж ахуйг өргөтгөх 2 төсөлд 240.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв.<br>2019 онд 289.2 мянган тонн зөгийн балыг импортолж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.6 тонн-оор өссөн байна. | |
| | | | Хүчит тэжээл | 11.0 | 0.665<br>Улсын төсөв | 2019 онд Улаанбаатар хотод протейн тэжээлийн үйлдвэр ашиглалтад орсон. Тус үйлдвэр өдөрт малын гаралтай 96 тонн хаягдал түүхий эд боловсруулж 24 тонн тэжээлийн ууpaг, малын гаралтай 17 тонн тос үйлдвэрлэх хүчин чадалтай болсон.<br>Манай улс жилд 18 орчим тэрбум төгрөгийн тэжээлийн уургийг импортоор авдаг. Гахай, тахианы эрчимжсэн аж ахуйн тэжээлийн уургийн 80 хувийг дангаараа хангах хүчин чадалтай энэ үйлдвэр ашиглалтад орсноор импортыг бууруулах бодит боломжийг бүрдүүлсэн. Уг тэжээлийн үйлдвэр нь импортын тэжээлийн 8.8 хувийг хангаж байна. Мөн “Баялаг феед” ХХК нь үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж өнжсөн өвсийг сүүлийн үеийн дэвшилтэд аргаар уураг өндөртэй 2000 тонн тэжээл үйлдвэрлэх боломжийг бүрдүүлсэн.<br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Тэжээлийн тогтвортой менежмент” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Уг төсөл нь импортоор орж ирдэг тэжээлийн түүхий эдийг Монголд тариалах, нутагшуулах, тэжээлийн нэр төрлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Төсөл хэрэгжсэнээр импортын тэжээлийн түүхий эдийг дотооддоо бэлтгэж, тэжээлийн импортыг бууруулна.<br>Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 2019 онд малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж шинэчлэх, бага оврын тэжээлийн үйлдвэр шинээр барих зэрэг 6 аж ахуйн нэгжид 665.0 сая төгрөгийн зээл олгосон байна.<br>2019 оны жилийн эцсийн байдлаар 23.4 мянган тонн хүчит тэжээл импортолж, хүчит тэжээлийн импорт өмнөх оны мөн үеэс жилээс 54.2 хувиар буурсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 4.Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний эрүүл ахуйн чанарыг сайжруулна. | | | | | | | |
| 4.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18, 2.23, 2.34 дэх заалт | "Мах, сүүний анхдугаар аян"-ы хүрээнд үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэмжээг нэмэгдүүлэх | Үйлдвэрийн аргаар боловсруулах махны хэмжээ, мянган тонн | 24.6 | | Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31.7 мянган тонн болж, хот суурин газрын хүн амын хүнсний махны хэрэглээг хангах ажлыг зохион байгуулж ажиллав. | 100 |
| | | | Үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээ, сая литр | 85.0 | | Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 2019 оны урьдчилсан байдлаар 168.1 сая литр буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.5 хувиар өссөн байна. Нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ 21.0 хувьтай байна. | |
| 4.2 | МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ТХХААТББ-ын 3.1.6 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.39, 2.40, 2.45 дахь заалт | Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хангалтыг нэмэгдүүлэх | Өвөл, зуны хүлэмжийн нэмэгдэх талбай, га | 10.0 | 0.690 Улсын төсөв | 2019 онд Орхон, Булган аймагт орон нутгийн төсвөөр 32 метр кв. талбай бүхий нийт 130 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж, улсын төсвийн 147.0 сая төгрөгийн хөрөнгөөр 120 метр кв. талбай бүхий 38 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмжийг нийлүүлж хүлэмжийн талбайг 9560 метр кв-аар нэмэгдүүлэв. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 2019 онд 372.1 сая төгрөгийн зээлийг өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах 4 төсөлд олгож хүлэмжийн талбайг 2000 метр кв-аар нэмэгдүүлэв. БНСУ-ын Гангвон мужийн хөрөнгө оруулалтаар Төв аймагт 1000 метр кв. орчин үеийн дэвшилтэт технологийн давхар хүлэмж байгуулав. Дээрх арга хэмжээний үр дүнд хүлэмжийн талбай 1.8 га талбайгаар нэмэгдсэний зэрэгцээ хувийн хөрөнгө оруулалтаар 0.26 га хүлэмж шинээр байгуулагдаж нийт хүлэмжийн талбайн 2.1 га-аар нэмэгдсэн байна. Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар Хөдөө аж ахуйг их сургуулийн дэргэд "Хүнсний ногооны хүлэмжийн жишиг агропарк, сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах" инновацын төсөл хэрэгжүүлэх төрийн өмч давамгайлсан гарааны компани байгуулахаар шийдвэрлэв. Төслийн хүрээнд БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар 10 га талбай бүхий өвөл, зуны хүлэмж байгуулж жилд 600-800 тонн ургац хураан авахаар төлөвлөж байна.<br>2019 онд өвөл, зуны хүлэмжийн талбай өнгөрсөн оноос 5.2 га талбайгаар нэмэгдэж 96.8 га болсон ба хураан авсан ургац 1080 тонноор нэмэгдэж 6780 тонн болов. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өвөл, зуны хүлэмжээс хураан авах ургац, тонн | 3500 | 0.690 Хөгжлийн банк | 2019 онд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд өвөл, зуны хүлэмжээс хураан авах ургац 1.0 мянган орчим тонноор нэмэгдэж улсын хэмжээнд жилд 6700 тонн хүнсний ногоо хураан авах боломжтой болов. | |
| | | | Нэмэгдэх зоорийн багтаамж, тонн | 2000 | 1.45 Улсын төсөв | Улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Ховд, Сүхбаатар аймагт нийт 1500 тонны багтаамжтай төмс, хүнсний ногоо хадгалах зоорь байгуулахаар ажиллаж байна. Ховд аймгийн зоорийг 2018-2019 онд байгуулж дуусгах гэрээг "МГБИ" ХХК-тай байгуулсан. Сүхбаатар аймгийн зоорины ажил дууссан. Ховд аймгийн зоорины ажлыг 2020 онд дуусгахаар гэрээг сунгасан.<br>2018 онд 210.2 мянган тонн багтаамжтай байснаас 2000 тонноор нэмэгдэж 212.2 мянган тонн болсон байна. | |
| | | | Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх хувь | 5.0 | 0.1 Улсын төсөв | 2019 онд төмс 14.9 мянган га-д тарьж 190.8 мянган тонн, хүнсний ногоо 8.4 мянган га-д тарьж 99.5 мянган тонн хураан авч төмс 100 хувь, ногооны хэрэгцээний 40 хувийг хангасан. Ил талбайн 3 нэр төрөл 1875.3 кг үр, хүлэмжийн 3 нэр төрлийн 21.5 кг ногооны үрийг хуулийн дагуу худалдан авч аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулан 625 ногоочдод дэмжлэгээр олгов. 2019 онд туршсан ногооны 6 сортыг хэлэлцэж лоолийн жижиг жимстэй "Seminis3 сорт, бөөрөнхий сонгины 4 сортыг сорилтод, гүзээлзгэнийн "Санта" сорт, цэсийн "Чёрный красавец", ил талбайн хэмхийн ""Restina f1" сортуудыг ирээдүйтэй сортоор хэлэлцэн батлав. Хүнсний ногооны 1 га талбайг услах бага оврын бороожуулагч 80 ширхэг, 10 га-аас дээш талбайг услах хүчин чадалтай дунд оврын дамартай бороожуулагч 18 ширхгийг авч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-107 дугаар тушаалаар төмс, ногооны тариалан эрхлэгчдэд 8 жилийн хугацаатай жилийн 2 хувийн хүүтэй зээлээр олгож байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-177 дугаар тушаалын дагуу ногоочдод түрээсийн үйлчилгээ үзүүлэх зориулалтаар Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт 12 нэр төрлийн 57 ширхэг техник, тоног төхөөрөмж олгов. | |
| | | | Жимс жимсгэнэ тариалах шинээр | 10 | | Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих" техник туслалцааны төслийн "Чацаргана" бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 107.0 сая төгрөгийн хөрөнгөөр органик шавж баригч наалтын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдэх талбайн хэмжээ, га | | 1.34 Улсын төсөв, 2.28 Гадаад эх үүсвэр | цехийг нийлүүлж Ургамал хамгаалын хүрээлэнд суурилуулж органик жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв. Мөн ШУТИС-ийн Техник, технологийн туршилтын төв дээр 945.3 сая төгрөгийн өртөгтэй Тайвань улсад үйлдвэрлэсэн "Нүүрсхүчлийн хийгээр хандлах аргаар чацарганын үрийн тосыг ялгах төхөөрөмж"-ийг суурилуулж хүлээлгэн өгөв. Үүний үр дүнд Монгол чацарганын үрийн тосыг нарийвчлан судалж чанарыг олон улсад баталгаажуулах, өндөр технологийн цэвэршилт сайтай чацарганын үрийн тосыг экспортлох боломжтой болов. АХБ-ны "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт" төслийн хүрээнд Завхан аймгийн "Завхан баялаг" ХХК-д жимс жимсгэнийн тариалалт, боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд зориулан 1.088 тэрбум төгрөгийн 7 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгож үйлдвэрлэлийн технологийг сайжруулахад дэмжлэг үзүүлэв. 2019 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1.2 тэрбум төгрөг санхүүжилтээр Ховд аймгийн Булган, Жаргалант суманд жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн төвүүдийг байгуулж орон нутагт нутагшсан стандартын шаардлага хангасан суулгац үржүүлэх эхлэл тавигдав. Булган аймагт Шинэ хөдөө төслийн хүрээнд 7 суманд тус бүр 8 га талбай бүхий жимс жимсгэнийн дуслын усалгааны төхөөрөмж, суулгац, нийлэг хальсан нийлүүлж жимс жимсгэнэ, хүнсний ногооны тариалалтыг 56 га талбайгаар нэмэгдүүлэв. Улсын төсвийн хөрөнгөөр 120 метр кв талбай бүхий 10 иж бүрдэл жимсний суулгац үржүүлгийн мананжуулагчтай хүлэмж нийлүүлж суулгац үйлдвэрлэлийг 200.0 мянган ширхгээр нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв. | |
| | | | Хүнсний ногооны механикжуулалтын түвшин, хувиар | 50.0 | 0.47 Улсын төсөв, 7.0 Гадаад эх үүсвэр | Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019.06.05-ны өдрийн А-177 дугаар тушаалын дагуу ногоочдод түрээсийн үйлчилгээ үзүүлэх зориулалтаар Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт нийт 470.0 сая төгрөгийн үнэ бүхий 12 нэр төрлийн 57 ширхэг техник, тоног төхөөрөмж олгож 3 аймгийн 6 сумын 80 гаруй ногоочин өрхийн 100 га төмс, хүнсний ногооны талбайн ажлыг механикжуулав. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн 2.7 сая ам. долларын хөрөнгөөр хүнсний ногооны үйлдвэрлэлийн зориулалттай 120 ширхэг трактор, бууц, бордоо цацагч 41 ширхгийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийлүүлж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-139 дүгээр тушаалын дагуу ТЭДС-гаар дамжуулан ногоочдод 10 хувийн урьдчилгаатай 7 жилийн хугацаатай, жилийн 2 хувийн хүүтэй зээлээр олгох ажлыг зохион байгуулж байна. 2019 онд нийт 732.1 мянган ам. долларын өртөг бүхий 33 ширхэг трактор, техник тоног төхөөрөмжийг журмын дагуу зээлээр олгосон.<br>Механикжуулалтын түвшин өмнөх оны мөн үеэс 3 хувиар нэмэгдэж 2019 оны байдлаар 45.0 хувь болж нэмэгдсэн байна. | |
| 4.3 | МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ТХХААТББ-ын 3.1.7 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.18, 2.39-2.47 дахь заалт | Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах | Барилгын ажлын явц, хувиар | 80.0 | 0.223 Хөгжлийн банк | Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах зураг төсөлд магадалгаа хийлгүүлэх зөвлөх үйлчилгээний ажлыг "ХБХДТ" ХХК-аар хийлгэсэн. ТЭЗҮ–д байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээг тендерт шалгарсан "Санни трейд" ХХК, ТЭЗҮ-д үерийн уснаас хамгаалах, . хөрсний усыг доошлуулах нэмэлт зураг төсөл хийх зөвлөх үйлчилгээг тендерт шалгарсан "Силвер Эделвэйз" ХХК-иуд тус тус гүйцэтгэсэн. | 0 |
| 4.4 | МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ТХХААТББ-ын 3.1.7 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.18, 2.39-2.47 дахь заалт | Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутгийн тариалалтыг дэмжих | Хураан авах үр тарианы хэмжээ, мянган тонн | 400 | 3.0 Улсын төсөв | 2019 оны ургац хураалтын дүнгээр нийтдээ 433.0 мянган тонн үр тариа, үүнээс 407.6 мянган тонн улаан буудай, 190.8 мянган тонн төмс, 94.6 мянган тонн хүнсний ногоо, 35.2 мянган тонн тосны ургамал, 119.6 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авч, гурил үйлдвэрлэлд 250.0 мянган тонн буудай нийлүүлэгдсэн байна. | 70 |
| | | | Тариалангийн талбайн загвар хашаа байгуулах хэмжээ, га | 1000 | 3.0 Улсын төсөв | 2019 онд Улсын төсвийн 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн Хонгор суманд 27 км, Дорнод аймгийн Халх гол суманд 45.0 км, Орхон аймгийн Жаргалант суманд 15.0 км, Төв аймгийн Жаргалант суманд 50.0 км, Борнуур суманд байрлах Хөдөө аж ахуйн их сургуулийн Судалгаа шинжилгээний Нарт төвд 4.07 км, Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 40.0 км, Хүдэр суманд 10.0 км, Орхон туул суманд 30.0 км, Баруунбүрэн суманд 10.0 км, Хушаат суманд 10.0 км, Зүүнбүрэн суманд 20.0 км, Баянгол суманд 50.0 км, Хөвсгөл аймгийн Тариалан суманд 20.0 км, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Хурх тосгонд 71.85 км, Биндэр суманд 21.0 км буюу нийт 423.9 км хашаа барих ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан. Орон нутаг дахь ажлын хэсгийн хашаа хүлээн авсан тухай актыг үндэслэн 10 аж ахуйн нэгжийн ерөнхий актыг үйлдэн гэрээг дүгнэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийт 423.92 км хашаа барихаас 2019 онд 281.0 км хашааг бүрэн барьж дуусгасан ба 142.92 км хашааны бараа материалыг хашаа барих байршилд бүрэн нийлүүлсэн. | |
| | | | Усалгаатай талбайн хэмжээ, мянган га | 55.6 | 19.4 Гадаад эх үүсвэр, 1.2 Улсын төсөв | Ховд аймгийн Зэрэг, Булган, Үенч, Буянт сумдын 4 услалтын системийг 1.2 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж, сэргээн засварлаж усалгаатай тариалангийн эргэлтийн талбайн хэмжээг 767 га–аар нэмэгдүүлээд байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих" төслийн хүрээнд 16.9 сая ам. долларын өртөг бүхий 50-125 га талбайг услах үр тарианы зориулалттай усалгааны тоног төхөөрөмж 130 ширхэг, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг услах зориулалттай бага болон дунд оврын усалгааны тоног төхөөрөмж 126 ширхэг, 0.8-1.0 mpa даралттай усалгааны хуванцар хоолойг тус тус худалдан авч усалгаатай тариалан эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид жилийн 2 хувийн хүүтэй 8-12 жилийн хугацаатай зээлийг Сайдын А-107, А-176 тоот тушаалаар ТЭДС-гаар дамжуулан зээлээр олгож эхлээд байна. Үр тариа, төмс хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг 13 аж ахуйн нэгж, 1 иргэнд 19.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 35 ширхэг усалгааны тоног төхөөрөмжийг 12 жилийн хугацаатай зээлээр олгож усалгаатай тариалангийн эргэлтийн талбайг 3000 га-аар нэмэгдүүлснээр 57.4 мянган га-д хүрсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3000 га-аар өссөн байна.<br>Нийт 3767 га талбай шинээр ашиглалтад орох боломж бүрдсэн. | |
| | | | Алслагдсан бүс нутагт шинээр элеватор байгуулах ажлын явц, хувиар | 80.0 | 0.47 Улсын төсөв | ОХУ-ын Засгийн газрын зээлийн эх үүсвэрээр 200 тонны 5 ширхэг, 300 тонны 5 ширхэг, 500 тонны 5 ширхэг босоо төмөр агуулах нийлүүлсэн. Босоо төмөр агуулахын багтаамжийг 6000 тонноор нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв. ТЭДС Хөтөл салбарт 1000 тонн Сэлэнгэ салбарт 1000 тонн багтаамжтай хэвтээ агуулахыг байгуулж ашиглалтад оруулсан. Увс аймгийн Баруунтуруун, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд тус бүр 10.0 мянган тонн багтаамжтай үр тариа хадгалах элеваторын ТЭЗҮ-ийг боловсруулав. | |
| 4.5 | | "Үйлдвэржилт | Хөтөлбөрийн | 30.0 | 17.5 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого /цаашид ТАҮТББ гэх/-ын 4.2.3 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.48, 2.50, 2.55, 2.56, 2.57 дахь заалт | 21:100" үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлэх | хэрэгжилтийн явц, хувиар | | Улсын төсөв, 12.7 Гадаад эх үүсвэр | 01 дүгээр сарын 08-ны өдрийн А-07 дугаар тушаалаар "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр", түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлав. УИХ-ын 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар "Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль", Засгийн газрын 2019 оны 190 дүгээр тогтоолоор "Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдох бүхий салбарын жагсаалт, "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-119 дүгээр тушаалаар "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам" тус тус баталж, хөнгөлөлттэй зээлийн төслийн сонгон шалгаруулалтыг орон даяар зохион байгуулав. Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр" батлав. Үйлдвэржилт 21:100 Үндэсний хөтөлбөрийн хууль эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд: •Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор баталсан дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулж Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлав. Үүнд: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж чанар, стандартын шаардлага хангасан 155 барааг дотоодын үйлдвэрээс хангахаар тусгасан. Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газрын 343 дугаар тогтоолоор шинэчлэн батлав. Нийт 38 үйлдвэр үйл ажиллагаа явуулж эхэлсэн, 65 үйлдвэр 10-90 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт 4000 орчим ажлын байр бий болсон байна. | |
| 4.6 | МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.48, 2.51 дэх заалт | "Ноолуур" хөтөлбөр хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 20.0 | 0.639 Улсын төсөв, 0.97 Гадаад эх үүсвэр, 107.9 Хөгжлийн | "Ямааны ноолуурын үйлдвэрлэл худалдаанд" мөрдөх техникийн зохицуулалтын төсөл болон холбогдох баримт бичгийг боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөл болон олон нийтээр хэлэлцүүлж, яамдаас санал авахаар хүргүүлэв. Швейцарийн хөгжлийн агентлагийн "Ногоон алт-Малын эрүүл" мэнд төслөөс 7 аймгийн 22 сумын 3100 малчин, Азийн хөгжлийн банкны "ХАА хөдөөгийн хөгжлийн техник | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | банк, 7.5 Хувийн хөрөнгө оруулалт | туслалцаа"-ны төслөөс 4 аймгийн 18 хоршооны 578 малчин, НҮБХХ-ийн "Тогтвортой ноолуур" төслөөс 2 аймгийн 6 хоршооны 400 малчинд ноос, ноолууран түүхий эдийг бэлтгэх чанарын сургалтыг зохион байгуулсан. Малчдаас бэлтгэсэн түүхий эдийг бүртгэлжүүлэх, чанарыг мөшгөх зорилгоор Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн санхүүжилтээр 18 аймгийн 28 сумын хоршоо болон сумын бэлчээр ашиглагчдын холбоог мөшгөх тогтолцооны RMTS цахим системд оруулж эхлэв. ТНБД-ын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь ноолуурын салбарт шаардлагатай ээрэх үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг хийж, Япон, Итали зэрэг ээрэх технологи өндөр хөгжсөн улсаас хөрөнгө оруулалт татах чиглэлээр холбогдох уулзалтуудыг хийв. Мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ээрэх үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүд суурилагдаж байна. "Монголын хаан ширхэгт" гэрчлэх тэмдгийг олгохтой холбогдсон бэлтгэл ажлууд хийгдэж байна. Ноолууран бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах зорилгоор АНУ, Япон зэрэг улсуудад үзэсгэлэн худалдаа, бизнес уулзалтуудыг зохион байгуулав. Ноолуурын үйлдвэрүүдэд аттестатчилал явуулах, салбарын мэргэжилтэй ажилтны судалгаа хийх ажлуудыг эхлүүлэхээр холбогдох баримт бичгийг боловсруулав. Хөтөлбөрийн биелэлт 64.9 хувьтай байна. | |
| 4.7 | МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.50, 2.15, 2.54 дэх заалт | Жижиг, дунд үйлдвэрийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих | Санхүүжүүлэх төслийн тоо | 400-гаас доошгүй | 47.4 Улсын төсөв, 43.7 Гадаад эх үүсвэр | 1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 дүгээр тушаалаар баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам"-ыг батлан төсөл сонгон шалгаруулалтад 47.0 тэрбум төгрөгийн 4 зээлийн багцын хүрээнд нийт 452 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд 5 жилийн хугацаатай 3.0-5.6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг олгох нөхцөл бүрдсэн. Энэ удаагийн хөнгөлөлттэй зээл олгох хүрээнд хүүг бууруулж, орон нутагт зориулсан зээлийн багцыг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлж, зээлдэгчдэд зээлийн эрсдэлийн даатгалын тогтолцоог бий болгож даатгалд хамруулж зээлийн нөхцөлийг сайжрууллаа.<br>2. Сум хөгжүүлэх сангаас 2019 оны 04 дүгээр улирлын байдлаар 2620 төсөлд 10.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож шинээр 2162 ажлын байр бий болсон байна. Сум хөгжүүлэх сангийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор Зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн программ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангамжийг боловсруулан 2019 оны жилийн эцсийн байдлаар Зээлийн мэдээллийн санд холбогдох мэдээлэл оруулах эрхийг 331 суманд олгосноос 190 сум 5485 зээлдэгчийн холбогдох зээлийн мэдээллийг мэдээллийн санд нэгтгэв. | |
| 4.8 | МУТХҮБ-2030-ын 2.1.3, ЗГҮАХ-ийн 2.57 дахь заалт | Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн парк байгуулах | Ажлын явц, хувиар | 30.0 | | Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулахаар үзэл баримтлалыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр бэлдээд байна. Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийг байгуулахад чиглэсэн дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Үүнд:<br>1. Засгийн газрын 73 дугаар тогтоолын дагуу арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэг Харгиа урьдчилсан цэвэрлэх байгууламж, Эмээлтийн үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхээр төлөвлөж, ТЭЗҮ-ийг шинэчлэх үүргийг хотын захиргаанд өгөв.<br>2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, газрын дарга, мэргэжилтнүүд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан болон ажлын албаныхантай ажил хэргийн уулзалт зохион байгуулж үйлдвэрлэл технологийн паркуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг ажлыг хурдацтай эхлүүлэх тал дээр хамтран ажиллахаар болов.<br>3. Барилга, хот байгуулалтын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар 2019/03, 2019/01, 01/07 тоот хамтран ажиллах санамж бичиг байгуулав. | 0 |
| 4.9 | МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.58 дахь заалт | Төрөөс дотоодын худалдан авалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх | Дотоодын худалдан авалтын өсөлтийн хувь | 10.0 | 24.0 Улсын төсөв | 1.Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор дотооддоо үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай 155 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг баталлаа. Эдгээр бараа, бүтээгдэхүүнийг аливаа тендерийн үндсэн нөхцөл болгож, худалдан авах бодлогыг Засгийн газар баримтлахаар тогтсон.<br>2. Засгийн газраас үүрэг болгосны дагуу төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлийг дэмжих нь эдийн засгийн хүндрэлээс гарахад бодитой хувь нэмэр | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оруулна гэж үзэж 2019 оны 4 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд "Эх оронч‍ худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл-2019" үзэсгэлэнг "Мишээл экспо" үзэсгэлэнгийн танхимд зохион байгууллаа. Үзэсгэлэнд 150 орчим үндэсний үйлдвэрлэгчид төрийн худалдан авалтад нийлүүлэх боломжтой стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээ дэлгэн үзүүлж, нөгөө талаас 70 орчим төрийн байгууллагууд энэ онд худалдан авах бараа бүтээгдэхүүний мэдээллийг нийтэд ил тод байршуулж оролцлоо. | |
| 4.10 | МУТХҮБ-2030-ын 2.1.7, Зорилт 1, ЗГҮАХ-ний 2.18, 2.23 дахь заалт | Орон нутгийн мэргэжлийн хяналтын лабораторийн ажиллах нөхцөлийг сайжруулах | Ашиглалтад орох лабораторийн барилга | 1 | 1.47 Улсын төсөв | Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилгын тендерийг зохион байгуулж 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр "Говийн өгөөж" ХХК-тай шууд гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлж 2019 оны 12 дугаар сарын 22-ны өдөр улсын комисс дүгнэлт гарган хүлээж авсан. Барилга барих газар тендер зарласны дараа өөрчлөгдсөнтэй холбоотойгоор барилгын зураг, төсөв шинэчлэгдэж төсөвт өртөг 639.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс 100.0 сая төгрөгийг Монгол Улсын 2020 оны төсөвт тусгасан. | 70 |
| | | | Шинээр ашиглалтад орох явуулын лаборатори | 12 | | Монгол Улсын 2019 оны төсөвт хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй тул явуулын лаборатори байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон. | |
| Зорилт 5.Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. | | | | | | | |
| 5.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 1, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид ТЭБСББ/-ын 3.2.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.59-2.61 дэх заалт | Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх | 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар | 43.5 | 6.27 Улсын төсөв | Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд 2019 онд Бурхант толгой-50, Дэвсгийн нуруу-50, Улаан толгой-50, Хулгарын элс-50, Суман хад-50, Хайлааст уул-50, Чандмань уул-50, Өлийн овоот-50 төслүүдийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 11, 110, 111, 116, 125, 126, 127, 138 дугаар тушаалаар хүлээн авсан.<br>Дээрх 8 төслийн үр дүнг хүлээн авснаар нийт нутаг дэвсгэрийн 40.5 хувийг тус судалгааны ажилд хамруулаад байна.<br>Мөн тус судалгааны ажлын хүрээнд 2019 онд 31 төслийг нийт нутаг дэвсгэрийн 4.2 хувьд хэрэгжүүлэхээр холбогдох төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2019 оны А13 дугаар тушаалаар баталж, хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Уг төслүүдийн 2019 оны ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийг хэлэлцэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар батлав.<br>Түүнчлэн, 2019 онд шинээр 10 төслийг хэрэгжүүлэхээр холбогдох сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. | |
| | | | Улсын геологийн иж бүрдэл зургийг "К" хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлын явц, хувиар | 50.0 | 0.755 Улсын төсөв | Улсын геологийн иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх төслийн 2019 оны төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлан К хавтгайн 35%-д буюу баруун хэсэгт хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар хээрийн судалгааны ажлыг 100 хувь дуусгасан. Мөн 2019 оны хээрийн болон суурин боловсруулалтын судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан. | |
| | | | Агаарын геофизикийн судалгааны ажлын хүрээнд Ховд-1 төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар | 20.0 | | "Ховд - 1" судалгааны ажлыг 2019 онд хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн шийдвэрээр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/13 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөөг тус тус батлуулсан.<br>Тус төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулсан хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангасан хуулийн этгээд шалгараагүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан зөвлөхийг сонгох тендерийг 2 удаа зарласан ч амжилтгүй болсон. | |
| | | | Монгол орны геохимийн 1:1000000-ын | 20.0 | 0.667 Улсын төсөв | Монгол орны нутаг дэвсгэрийн 1,149,529.0 кв.км талбай /73.5%/-г хамарсан 1:1000000-ны масштабын геохимийн зураглал хийх, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | масштабын зураг зохиох ажлын явц, хувиар | | | судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлуулсан. Судалгааны ажлын геологийн даалгаврыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн шийдвэрээр батлуулсан.<br>Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулж гүйцэтгэгч хуулийн этгээдийг шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан.<br>Монгол орны баруун, баруун өмнөд, зүүн өмнөд хэсэгт буюу К-48-А,Б, К-47-Б, L-48-А,Б,В,Г, L-49-А,Б,В, L-46-А,Б, L-47-А,Б,В,Г хавтгайд дээжлэлтийн ажлыг гүйцэтгэж нийт 1167 ширхэг дээжлэлт хийсэн. Ингэснээр 2019 онд нийт талбайн 31.3%-д хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн. | |
| 5.2 | МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 1, ТЭБСББ-ын 3.2.2 дахь заалт ЗГҮАХ-ийн 2.59-2.61 дэх заалт | Нутаг дэвсгэрийн ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах, геоэкологи, гидрогеологийн судалгаа хийх, геомэдээллийн санг баяжуулах сэдэвчилсэн судалгааны ажлыг гүйцэтгэх | Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлын тоо | 3 | 0.655 Улсын төсөв | Томоохон хотуудын геоэкологи, гидрогеологийн дараах ажлын хүрээнд 2019 онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологи-2017 төслийн 2019 оны төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/13 дугаар тушаалаар тус тус баталсан. Төслийн 2019 оны суурин боловсруулалтын ажлын төсөл, төсөвт хийх тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдөр хэлэлцэж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар батлан суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн.<br>- Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг 2019 оноос хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/13 дугаар тушаалаар, судалгааны ажлын геологийн даалгаврыг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн шийдвэрээр тус тус батлуулсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зарлаж гүйцэтгэгч хуулийн этгээдийг шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Дээрх төслийн 2019 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан.<br>- Дархан хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг 2020 оноос хэрэгжүүлэхээр санхүүжилтийн эх үүсвэрийг Улсын төсөвт тусгуулан батлуулсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Голлох ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгааны ажлын тоо | 1 | 12.7 Улсын төсөв | Бүс нутгийн хөгжлийг хангах, эрдэс түүхий эдийн нөөц, баялгийг өсгөх зорилгоор нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017)-ны ажлын 2019 оны төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/13 дугаар баталсан. Судалгааны ажлын 2019 оны төсөл, төсвийн тодотголыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/98 дугаар тушаалаар батлуулж, хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн.<br>Хээрийн судалгааны ажлаар 2019 онд хэтийн төлөв бүхий 78 талбайд нарийвчилсан эрлийн ажил, 24 талбайд уул-өрөмдлөгийн ажил, 278 талбайд эрэл шалгалтын ажил хийхээр төлөвлөж хээрийн үйлдвэрлэлийн ажлыг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн бүрэн дуусгасан. | |
| | | | Алт-2 хөтөлбөрийн хүрээнд Монгол орны алтны хэтийн төлөвийг тогтоох эрлийн ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар | 60.0 | 1.62 Улсын төсөв | Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлөвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын "ТЗМ-Алт-2017" төслийн төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлуулсан. Төслийн 2019 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар батлуулсан. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэж дууссан бөгөөд Монгол орны 521,200.0 кв.км талбай буюу 33.3%-д тархсан алтны хүдэржилт бүхий талбай, дүүрэг, зангилаа, түүнд тогтоогдсон орд, илрэл, эрдэсжсэн цэг, сарнилын хүрээ бүхий хэсгүүдийг 100% нарийвчлан судалсан. Хээрийн судалгааны ажлуудын анхдагч материал, лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэн суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэн төслийн үр дүнгийн тайланг 2020 оны 1-р улиралд багтаан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Мөн Монгол орны баруун, баруун өмнөд, хангайн бүсийн алтны хэтийн төлөвийн судалгааны ажлыг "БӨМ-Алт-2019" нэртэйгээр хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/13 дугаар тушаалаар батлуулсан. Судалгааны ажлын геологийн даалгаврыг боловсруулсан.<br>Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг цахимаар хийж, шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээний гэрээг байгуулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. | |
| | | Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах судалгааны ажлын тоо | 1 | 0.496 Улсын төсөв | Үндэсний гео мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, нэгдсэн загварт оруулах ажлын хүрээнд "Гео мэдээлэл-2019" төслийг хэрэгжүүлэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/13 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөөг батлуулсан. Мөн ажлын геологийн даалгаврыг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн шийдвэрээр батлуулсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахим тендерийг зохион байгуулж, хамгийн сайн үнэлэгдсэн оролцогчтой зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2019 онд хүлээн авсан. | |
| | | Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын хүрээнд хэрэгжүүлэх төслийн тоо | 1 | 0.281 Улсын төсөв | МУ, БНХАУ, БНСУ, ОХУ, БНКазУ-ын хамтарсан "Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" төслийн төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлуулсан. Төслийн 2019 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2019 оны 02 дугаар 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн 4-р шат буюу "Их Алтай"-н ажлын суурин боловсруулалтын ажил эхэлсэн бөгөөд Монголын тал Монгол Алтай хэмжээнд судалгааны ажлыг эхэлсэн. Хамтарсан төслийн 17-р ажлын уулзалтыг Улаанбаатар хотноо 8 дугаар сард зохион байгуулсан. Төслийн 2019 оны судалгааны ажлын анхдагч материалыг 2019 оны 11 дүгээр сарын 22-нд хүлээн авсан. | |
| | | Үндэсний геологийн албыг байгуулах ажлын явц, | 100 | | Үндэсний геологийн алба байгуулах тухай танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулахаар өөрчлөн зохион байгуулах байгууллагуудын танилцуулга, УИХ-ын тогтоолын төсөл, төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайлан, чиг үүргийн ангиллын тайлан болон холбогдох бусад материалыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2019 оны 01/2870 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 16- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хувиар | | | ны өдрийн хуралдаанаар тус асуудлыг хэлэлцэн дэмжиж, асуудлыг УИХ-д өргөн мэдүүлэхээр холбогдох хууль, тогтоомжийн дагуу Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зөвшөөрөл, Үндэсний хөгжлийн газар, Төрийн албаны зөвлөлөөс санал авч, тогтоолын үзэл баримтлалыг батлуулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч УИХ-д өргөн мэдүүлсэн. | |
| 5.3 | МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.24 дэх заалт | Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын явц, хувиар | 60.0 | 2,997.5 Хувийн хөрөнгө оруулалт | Далд уурхайн бүтээн байгуулалтын үйлдвэрлэлийн 2 дугаар босоо амыг барьж дуусгасан ба далд уурхайн хөндлөн малталт 30,923 экв.м3, налуу буюу конвейрийн малталт 8.299 экв.м3, босоо ам 3–нэвтрэлтийн тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэж байна.<br>Мөн дөрөвдүгээр босоо амны нэвтрэлтийн цамхаг барих ажил явагдаж байна.<br>Дээрх ажлууд хийгдсэнээр 2019 онд далд уурхайн бүтээн байгуулалтын ажил 64 хувьд хүрээд байна. | 70 |
| | | | Тавантолгойн орд ашиглалтыг өргөжүүлэн, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын явц, хувиар | 20.0 | 486.0 Хувийн хөрөнгө оруулалт | Таван толгойн орд ашиглалтыг өргөжүүлэн, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>- Тавантолгой ордын талбайн ашиглалтыг өргөжүүлэх, нөөцийн хэмжээг нарийвчлан тогтоох, уурхайн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгын хүрээнд Тавантолгойн ордын талбайд хайгуул, өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэж байна. Уг хайгуулын ажлын хүрээнд 2019 онд 2.02 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. Мөн Таван толгой ордын Бортээг болон Оорцогийн хэсгийн нарийвчилсан хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж гэр хорооллын 220 мянган айл, өрхийг шахмал түлшээр бүрэн хангах "Тавантолгой түлш" ХХК-тай гэрээ байгуулан ажилласан.<br>- Засгийн газрын шийдвэрийн дагуу "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.<br>- Мөн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 296 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн иргэд, аж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахуйн нэгжийн эзэмшиж байгаа хувьцааны хоёр дахь зах зээлийн арилжааг хөрөнгийн бирж дээр үе шаттайгаар эхлүүлэхтэй холбогдуулан зохион байгуулах ажлыг баталсан бөгөөд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд "Эрдэнэс- Тавантолгой"-ийн охин компани "Эрдэнэс -Тавантолгой Майнинг" ХХК-ийг үүсгэн байгуулсан. | |
| 5.4 | МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, 4, ЗГҮАХ-ийн 2.70-2.73 дахь заалт | Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх | Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн ажлын явц, хувиар | 50.0 | 119.0 Гадаад эх үүсвэр | Газрын тос боловсруулах үйлдвэр барихад шаардлагатай гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслүүд болох "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн 27 км урт салаа төмөр зам, 18.2 км урт цахилгаан хангамжийн 110 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 110/10 Кв-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажлыг 2018 оны 6 дугаар сард Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт эхлүүлж 2019 оны 10 дугаар сарын 08-ний өдөр ашиглалтад хүлээн авсан.<br>Харин 16.63 км урт хатуу хучилттай автозамын барилга угсралтын ажил 2019 оны жилийн эцсийн байдлаар 60 хувьтай хэрэгжиж байна. | 40 |
| | | | Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар | 10.0 | 0.360 Хувийн хөрөнгө оруулалт | Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх нэгж Дэлхийн банкны стандарт шаардлагад нийцсэн Техник эдийн засгийн үндэслэл, Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлангуудыг боловсруулсан.<br>Төслийн техник эдийн засгийн үндэслэлд тооцоолсноор одоогийн хүчин чадлаар үйлдвэрийг барихад 2.5 тэрбум ам.доллар буюу их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй байгаа тул батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд нэмэлт тодотгол хийх, мөн төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгох, түүнтэй гэрээ хэлэлцээр хийх, газрын болон бусад холбогдох зөвшөөрлүүдийг авахад уг төслийн үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх төсөл хэрэгжүүлэх нэгж бус аж ахуйн тооцоот хуулийн этгээд эрхлэн явуулах хууль, эрх зүйн бодит шаардлага үүссэн.<br>Иймд тус асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төслийн нэгжийг татан буулгаж чиг үүргийг "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдэн 451 дугаар тогтоолыг баталсан. | |
| | | | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар | 10.0 | 0.394 Хувийн хөрөнгө оруулалт | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" 378 дугаар тогтоолын дагуу 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр улсын тусгай хэрэгцээнд газрыг ашиглуулах тухай 2019/01 дугаар гэрээг байгуулсан.<br>2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг байгуулах тухай асуудлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмж гарсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулсан.<br>3. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх сонгон шалгаруулах ажил нь төрийн нууцад хамаарсан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасны дагуу зохион байгуулахыг Тагнуулын Ерөнхий Газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/1281 дүгээр албан бичгээр уламжилсан. Үүний дагуу Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдан 2019 оны 12 дугаар сард гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, холбогдох гэрээг байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр болон Төмөртэйн ордын баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажлын явц, хувиар | 10.0 | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/136 дугаар тушаалаар тус концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт гаргах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, батлагдсан удирдамжийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 17-ноос 20-ны өдрүүдэд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн гангийн үйлдвэр болон уурхай, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болон үйл ажиллагаатай танилцан, цаашид авах арга хэмжээний талаар урьдчилсан байдлаар дүгнэлт, санал боловсруулсан ажилласан.<br>Концессын гэрээний концессын зүйлийн хэсгүүдийн хэрэгжилт 75 хувьтай, гэрээний 2 дугаар бүлгийн 2.1.2, 2.1.3 дахь хэсгүүд болох Төмөртэйн уурхай дээр нойтон баяжуулах үйлдвэр байгуулах, төмрийн хүдэр боловсруулах, эцсийн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлууд хугацаандаа хэрэгжээгүй байна. Иймээс гэрээний хугацаандаа хэрэгжээгүй концессын зүйлийн хэрэгжүүлэх хугацааг 2025 он хүртэл сунгах, төлөвлөгөө боловсруулах, гэрээг сунгах хувилбарыг судалж байна. | |
| 5.5 | МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.17 дахь заалт | Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөнөөр болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулан, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны эзлэх хувийг нэмэгдүүлэх | Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны нэмэгдэх хувь | 10.0 | | Манай улс 2019 онд нийт 1473.6 мянган тонн шатахуун импортолсноос Евро-5 стандартын шаардлагад нийцсэн шатахуун 168.8 мянган тонн буюу нийт импортолсон шатахууны 11.5 хувьтай байна.<br>Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэхийг дэмжсэн эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр Онцгой албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Агаарын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулж, Сангийн яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж ажилласан.<br>Мөн манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын "Роснефть" компанийн төлөөлөлтэй 2019 оны 10 дугаар сард уулзалт зохион байгуулан, Евро-5 стандартын шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар хэлэлцсэн ба энэ талаарх албан бичгийг тус компанид хүргүүлсэн. | 70 |
| Зорилт 6.Эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭБТББ-ын 3.2.1.2, 4.1.1.4, ЗГҮАХ-ийн 2.97 дахь заалт | Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх | Эрдэнэтийн ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар | 50.0 | 34.1 Гадаад эх үүсвэр | Эрдэнэтийн ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгөх ажлын хүрээнд төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан ЭХА-001/2017 дугаартай "түлхүүр гардуулах" нөхцөлтэй ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.<br>Төслийн барилга угсралтын ажил 2019 оны жилийн эцсийн байдлаар тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 95 хувьтай, төслийн талбай дээр үндсэн тоноглол болох турбингенартор, шугам хоолой бусад тоноглолууд ирж, барилга угсралтын ажил 70 орчим хувьтай явагдаж байна. | 40 |
| | | | Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төслийн гэрээ, хэлэлцээрийн ажлын явц, хувиар | 100 | | Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар нэмэгдүүлэх ажлын хүрээнд төслийн гүйцэтгэгчийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан.<br>Мөн төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| | | | Гуравдугаар ДЦС-ыг 250 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар | 30.0 | | Улаанбаатарын дулааны III цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлж, цахилгаан, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх төслийн урьдчилсан шатны Техник эдийн засгийн үндэслэл хийгдэж ТЭЦ-3-ын техникийн зөвлөл болон салбарын Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр тус тус хэлэлцэгдэж дэмжигдсэн.<br>ОХУ-ын "ИНТЕР РАО" компаниас ЭКС/СМ/445 албан тоотоор төслийн техник эдийн засгийн үндэслэлээс 2 дахин их буюу хэт өндөр үнийн санал ирүүлсэн нь дэмжих боломжгүй нөхцөл байдлыг үүсгээд байна.<br>Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг ОХУ-ын "Интер РАО Экспорт" ХХК-ийн төлөөлөгчтэй 2019 оны 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд төслийн техникийн асуудлыг хэлэлцэх уулзалтыг зохион байгуулж, уг уулзалтаар ДЦС-ыг өргөтгөх ажлыг 52 сард багтаан барих саналыг 42 сар болгон бууруулсан.<br>Мөн 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдөр болсон Монгол Улс болон ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын хуралдааны протоколд станцын өргөтгөлийн санхүүжилт, төсөвт өртгийг харилцан тохиролцсон нөхцөлд хэрэгжүүлэхээр тусгасан.<br>ОХУ-ын "Интер РАО Экспорт" компанитай 2019 оны 10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 29, 30-нд "ДЦС-3" ТӨХК-иар ахлуулсан ажлын хэсэг албан уулзалтыг зохион байгуулж, төслийн үнийн санал дээр үргэлжлүүлэн хэлцэл хийгдэж байна. | |
| 6.2 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 4.1.1.1, 3.2.1 ЗГҮАХ-ийн 2.98 дахь заалт | Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, Өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих | Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц барих төслийн санхүүгийн хаалт хийх ажлын явц, хувиар | 100 | | Тавантолгой 450 МВт-ын цахилгаан станц барих төслийн санхүүжилтийн гэрээ байгуулагдах, санхүүгийн хаалт хийгдэхэд Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулж гарын үсэг зурах, компанийн хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай болсон.<br>Энэ хүрээнд 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн а/1472 тоот болон 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн б/2963 тоот албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн, Тавантолгойн цахилгаан станцын бүтээн байгуулалттай холбоотой асуудлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдөр а/2031, 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдөр а/3147 тоот бичгээр тус тус станцыг бүтээн байгуулахад шаардлагатай асуудлуудыг Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлүүлэхээр хандсан. Харин Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар Эрдэнэс Монгол компанийн 15 хувийн эзэмшлийн асуудлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын удирдлагуудад болон Эрдэнэс Оюу Толгой, Эрдэнэс Монгол компанийн удирдлагууд нэмэлт тайлбар өгөх шаардлагатай болсны улмаас удаашраад байна. Цаашид Засгийн газрын шийдвэр гарсан даруйд холбогдох компаниуд хувьцаа худалдах, худалдан авах гэрээг тус тусын Төлөөлөн удирдах зөвлөлөөр албажуулан EPC гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажил эхлүүлэх боломжтой болно.<br>Мөн Оюутолгой ХХК-ийн зүгээс төслийн шинэчилсэн Техник эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчний яаманд 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр танилцуулсан. Төслийн цаашдын бүтээн байгуулалтын ажил нь Улсын Их Хурлын 2019 оны "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолын хүрээнд Засгийн газраас байгуулах ажлын хэсэг болон Оюутолгой ХХК-ийн Тавантолгойн цахилгаан станц барих үнийн саналыг өрсөлдөхүйц түвшинд хүргэж бууруулахаас хамаарна. | 0 |
| | | | Багануурын 700 МВт-ын ДЦС барих | 20.0 | | Багануурын 700 МВт-ын ДЦС барих төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрчим хүчний сайдын 2019 оны 04 дүгээр сард БНХАУ-д хийсэн албан айлчлалын хүрээнд холбогдох | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төслийн барилгын ажлын явц, хувиар | | | төлөөлөлтэй уулзалт хийж нэгж блокийн хүчин чадлыг Монгол Улсын нэгдсэн сүлжээнд эрсдэл учруулахгүй, найдвартай ажиллагааг хангахуйцаар 150 МВт хүртэл бууруулах чиглэлээр санал тавьсан. Нэгж блокийн хүчин чадлыг бууруулж ажиллуулах тохиролцоонд хүрсэнтэй холбогдуулан Эрчим хүч худалдах, худалдан авах тухай гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулахаар хүргүүлсэн боловч нэгж блокийн хүчин чадлыг бууруулах шинэ нөхцөл байдал үүссэний улмаас буцаан татсан.<br>Багануурын станцын концесс эзэмшигч компанитай концессын гэрээнд өөрчлөлт оруулах хэлцэл хийхээр Үндэсний хөгжлийн газартай хамтран ажиллаж байна. Үндэсний хөгжлийн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А-218 дугаар тушаалаар концессын гэрээний хэлцэл хийх ажлын хэсэг байгуулагдан концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний төсөл дээр ажиллаж байна. | |
| | | | Баруун бүсийн 60 МВт-ын ДЦС-ын барилгын ажлын явц, хувиар | 20.0 | | Баруун бүсэд 60 МВт-ын дулааны цахилгаан станцыг барих ажлын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны төлөөлөгчид БНХАУ-д ажиллаж "Тэлмэний дулааны цахилгаан станц" төслийн хөрөнгө оруулагч Blue Ocean Corporate Services Limited компани, зээлийн даатгагч SINOSURE корпорац, хөрөнгө оруулалтын зуучлагч Хятадын үйлдвэр худалдааны банк (ICBC), барилгын ажлын гүйцэтгэгч Электрик компани болон Шинэ Азиа группийн албаны хүмүүстэй ажил хэргийн уулзалт хийж, төслийн санхүүгийн хаалтын гэрээний талаар санал солилцсон.<br>Мөн БНХАУ-ын экспортын зээлийн даатгалын корпорац уг төсөлд зээлийн даатгал хийх тухайгаа Монгол Улсын Үндэсний хөгжлийн газарт мэдэгдсэн. Хөгжлийн банкнаас санхүүжилтийн баталгаа хүлээгдэж байгаа бөгөөд санхүүжилтийн бэлтгэл ажил бүрэн хангагдсан байна. | |
| | | | Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх ажлыг эхлүүлэх төслийн гэрээ, | 100 | | Багануурын уурхайн хүчин чадлыг жилд 4-10 сая тонн нүүрс олборлох үе шаттайгаар өргөтгөх ажлын хүрээнд техникийн шинэчлэл хийхэд шаардагдах хөрөнгийг Улсын төсөв болон бусад эх үүсвэрээс шийдвэрлүүлэхээр саналыг хүргүүлсэн.<br>Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон Засгийн газрын 2018 оны 132 дугаар тогтоолын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэлэлцээрийн ажлын явц, хувиар | | | хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх тухай албан тоотыг тус тус боловсруулан Засгийн газрын эрхлэх газарт 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн а/500, 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн а/1067 тоот албан бичгээр хүргүүлэв. | |
| | | | Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ-г боловсруулж, хүчин чадлыг өргөтгөх төслийн, гэрээ, хэлэлцээрийн ажлын явц, хувиар | 100 | | Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг жилд 4.5 сая тонн нүүрс олборлох хүчин чадлаар өргөтгөх Техник эдийн засгийн үндэслэлийг "Шивээ-Овоо" ХК-ийн захиалгаар Уул уурхайн хүрээлэн боловсруулж дууссан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдэн, батлагдсан.<br>Уурхайн өргөтгөлийн техник эдийн засгийн үндэслэл батлагдсанаар шаардагдах хөрөнгө оруулалт тодорхой болсон бөгөөд уурхайн техникийн шинэчлэлтэд шаардагдах хөрөнгийг Улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | |
| 6.3 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 4.1.1.2, ЗГҮАХ-ийн 2.103 дахь заалт | Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлэх | Төслийн гэрээ хэлэлцээрийн ажлын явц, хувиар | 100 | | Шивээ-Овоогийн нүүрсний орд газрыг түшиглэсэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай, станцын усан хангамжийн "Шивээ-Энержи" цогцолбор төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төслийн Техник эдийн засгийн үндэслэлийн эдийн засгийн үр ашгийн хувилбарт тооцоо ирүүлэх тухай албан бичгийг 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А-12 албан тоотоор БНХАУ-ын Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компанид хүргүүлсэн. | 0 |
| 6.4 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 2, ТЭХТББ-ын 3.2.6, ЗГҮАХ- | Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар | Эрдэнэбүрэнгийн 64 МВт-ын УЦС-ын суурь судалгааны | 100 | 0.36 Гадаад эх үүсвэр | Эрдэнэбүрэнгийн 100 МВт-ын усан цахилгаан станц барих төслийг БНХАУ-ын 1,0 тэрбум ам.долларын зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэхээр Засгийн газрын шийдвэр гарсан.<br>БНХАУ-ын Засгийн газрын зүгээс төслийн Техник эдийн | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ийн 2.104 дахь заалт | хөгжүүлэх | ажлын явц, хувиар | | | засгийн үндэслэлийг шинэчлэх шаардлагатай гэж мэдэгдсэний дагуу Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийн хүрээнд БНХАУ-ын Төрийн өмчит China Water Resources Beifang Investigation Design and Research /BIDR/ компанитай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, төслийн техник эдийн засгийн үндэслэлийн судалгааны ажлыг эхлүүлсэн.<br>БНХАУ-ын BIDR компаниас төслийн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж, Эрчим хүчний яаманд 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хурлаар хэлэлцэн, дэмжигдсэн. БНХАУ-ын Эксим банканд төслийн техник эдийн засгийн үндэслэл болон Байгаль орчны үнэлгээг хүргүүлэн Зээлийн тусгайлсан хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна. |
| | | | Баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн барилгын ажлын явц, хувиар | 30.0 | 1.3 Гадаад эх үүсвэр | Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжих Сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх төслийн хүрээнд нийтдээ 41 МВт суурилуулсан чадалтай сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр барьж байгуулах юм. Үүнд: Увс аймгийн Өмнөговь сумын нутагт 10 МВт суурилуулсан чадалтай салхин цахилгаан станц, Говь-Алтай аймгийн төв Есөнбулагт 10 МВт суурилуулсан чадалтай нарны цахилгаан станц, Говь-Алтай аймгийн Алтай сумын төвд 0.5 МВт суурилуулсан чадалтайн нар-салхины цэнэг хураагуурын систем бүхий хосолмол систем, Завхан аймгийн төвийн 5 МВт-ын суурилуулсан чадалтай нарны цахилгаан станц цэнэг хураагуурын системтэй хамт, Завхан аймгийн Тэлмэн сумын нутагт 5 МВт суурилуулсан чадалтай салхин цахилгаан станц, Хөвсгөл аймгийн Мөрөнд 10 МВт суурилуулсан чадалтай нарны цахилгаан станц, Ховд аймгийн төв болон төслийн бүс нутгийн хүрээнд 5 байрлалд газрын гүний халаалтын систем зэрэг болно.<br>Төслийн менежментийн зөвлөхийн сонгон шалгаруулалтыг зарлаж, гэрээг 2019 оны 07 дугаар сард байгуулсан. Төслийн менежментийн зөвлөх 2019 оны 08 дугаар сард ажилдаа орж тендерийн баримт бичгүүдийг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.<br>Мөн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10МВт нар, Завхан аймгийн Улиастай хотын 5МВт нар ба эрчим хүчний хураагуур, Говь-Алтай аймгийн Алтай сумын сэргээгдэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрчим хүчний хосолмол систем байгуулах дэд төслүүдийн тендерийн үнэлгээний хороо байгуулагдаж, техникийн үзүүлэлт, шаардлага, тендерийн бичиг баримт боловсруулж дуусган Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн. | |
| 6.5 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.1.6, 3.2.5.3, 4.1.1.5, ЗГҮАХ-ийн 2.105 дахь заалт | Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг эхлүүлэх | Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт 260 км ЦДАШ, 220 кВ-ын дэд станц барих, Оюутолгой, Тавантолгой дэд станцуудыг өргөтгөх барилгын ажлын явц, хувиар | 50.0 | 109.4 Гадаад эх үүсвэр | Уг төслийн хүрээнд нийт 249 км 330 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил, Мандалговь, Тавантолгой, Оюутолгойн 220 кВ-ын дэд станцын барилга угсралтын ажлууд тус тус 100% хийгдэж дуусан бөгөөд төслийн ажлыг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр хүлээлгэн өгсөн.<br>Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас хэрэгжүүлж буй Сонгино дэд станцын барилга угсралтын ажил гэрээний хугацаандаа хийгдээгүй хүлээгдэж байгаагаас шалтгаалж БНХАУ-ын зээлээр хэрэгжсэн дээрх шугам, дэд станцын ажилд бүрэн хэмжээний хүчдэл өгч турших боломжгүй байна. Сонгино дэд станцын төслийн нийт барилга угсралтын ажил 95 орчим хувьтай хэрэгжиж байгаа бөгөөд одоогоор техникийн комиссын акт баталгаажих шатандаа байна. | 40 |
| | | | Багануур дэд станцаас Чойр хүртэл 220 кВ-ын 2 хэлхээт 178 км ЦДАШ болон дэд станц барих төслийн гэрээ, хэлэлцээр хийх ажлын явц, хувиар | 100 | | Тус төслийг ОХУ-ын "Эдийн засгийн коридор" төсөл, хөтөлбөрийн жагсаалтад оруулсан. Мөн Концессын зүйлийн жагсаалтад тусгуулах саналыг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.<br>Сангийн яам болон Европын сэргээн босголт хөгжлийн банк хооронд байгуулсан 300 сая ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх боломжийг судлан дэмжиж өгөх тухай Эрчим хүчний сайдын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн а/2357 тоот албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | |
| | | | Тайшир-Есөнбулагийн 110 кВ-ын 50 км урттай ЦДАШ, Есөнбулаг дэд станцын барилгын ажлын явц, хувиар | 80.0 | | Тайшир – Есөнбулагийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан эрчим хүчний салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцэн баталсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 388 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалт"-д Эрчим | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүчний сайдын багцаас Тайширын УЦС–аас аймгийн төв уруу татах 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Говь-Алтай/ төсөл, арга хэмжээ тусгагдсан.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. | |
| | | | Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, Айраг, Сайншандын 220 кВ-ын дэд станцын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх ажлын явц, хувиар | 100 | | Чойр дэд станцаас Сайншандын 220 кВ-ын хоёр хэлхээт 216 км Цахилгаан дамжуулах агаарын шугам, 220 кВ-ын дэд станц барих төслийн Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан салбарын салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Төслийн зураг төслийг хийлгэн холбогдох зөвлөх, шинжээчээр батлуулсан. | |
| | | | 220 кВ-ын Дархан дэд станцын барилгын ажлын явц, хувиар | 20.0 | | Төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад саналыг хүргүүлж ажилласан болно. Уг төслийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүйгээс шалтгаалж хэрэгжилт удааширч байна. | |
| | | | Төвийн бүсийн дамжуулах сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн зээлийн гэрээ байгуулах ажлын явц, хувиар | 100 | | Төслийн хүрээнд Эрчим хүчний яам, Сангийн яам, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК болон ХБНГУ-ын “KfW” банкны төслийн үнэлгээний багийн хооронд хэлэлцэн тохиролцсон асуудлуудыг нэгтгэн “Харилцан Ойлголцлын Санамж Бичиг” байгуулагдсан.<br>Зээлийн хэлэлцээрийн төсөл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдсэн.<br>“Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийн санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, зээлийн болон төслийн гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн ба Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж баталсан.<br>Хууль зүйн, дотоод хэргийн яам нь “Төвийн бүсийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл"-ийн зээлийн болон төслийн гэрээний хууль зүйн дүгнэлтийг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу нягтлан судалж хууль зүйн дүгнэлтийг гаргасан. Хууль зүйн, дотоод хэргийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1-1/5453 албан тоотоор хуулийн дүгнэлтийг ХБНГУ-ын Сэргээн босголт зээлийн банканд хүргүүлээд байна. | |
| 6.6 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.1.4, ЗГҮАХ-ийн 2.106 дахь заалт | Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Аймгийн төвүүдийн дулааны станцын барилгын ажлын явц, хувиар | 20.0 | 4.8 Гадаад эх үүсвэр | Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээ шинээр байгуулах төслийн хүрээнд Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 26 дугаар тушаалаар Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Монголын талаас 2019 онд төслийн зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулсан. Зөвлөх үйлчилгээний урилгыг БНСУ-ын 3 компанид хүргүүлсэн ба нэг оролцогч оролцсон. Төслийн зөвлөх компаниар БНСУ-ын "KDHEC" компанийг шалгаруулан гэрээний хэлцэл хийж, 2019 оны 07 дугаар сард гэрээ байгуулсан. 2019 оны жилийн эцсийн байдлаар зураг төсөл боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг боловсруулах болон судалгааны ажлууд хийгдэж дуусан.<br>Зөвлөх компанид гэрээний дагуу урьдчилгаа 10 хувь, гүйцэтгэлийн 10 хувь, нийт 20 хувийн санхүүжилтийг олгоод байна. | 70 |
| | | | Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй хот суурин газрын дулааны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх барилгын ажлын явц, хувиар | 70.0 | 14.1 Улсын төсөв | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төвлөрсөн дулаан хангамжийн системтэй хот, суурин газруудын дулааны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ажлын хүрээнд 2019 дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Эрчим хүчний дулааны төв магистраль шугамын шинэчлэлт, их засвар, өргөтгөл /Улаанбаатар/ (XVI.2.1) арга хэмжээний хүрээнд:<br>- Дулааны 9А магистралийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын барилга угсралтын гүйцэтгэл 75%;<br>- Шинэ Яармаг хорооллын дулааны магистраль шугам /гэр хорооллоос төв зам дагуу/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100%;<br>- Дулааны 8А магистралийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын барилга угсралтын гүйцэтгэл 100%;<br>- Мамба дацан орчмын халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаанд холбох ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тус тус 100%-тай байна.<br>2. Халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаанд холбох барилга угсралтын ажил /Улаанбаатар/ (XVI1.7)-ын хүрээнд:<br>- У-18 цэгээс 7И магистраль ДХ7138 дугаар цэг хүртэл шинээр 2Ф700 мм-ийн голчтой дулааны шугам шинээр татах ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 45%;<br>- ТЭЦ-4-өөс Яармаг хүртэлх дулааны Ф600мм голчтой шугамын гэр хороолол доторх үргэлжлэл ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл тус тус 100%-тай байна.<br>3. Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Хэнтий аймгийн Хэрлэн сумын Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэлтийн барилга угсралтын ажил бүрэн дуусаж 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>4. Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгөөр Дорноговь аймгийн Сайншанд сумын Дулааны станцын зуух, шугам сүлжээний шинэчлэлтийн ажлын Багц-1 буюу дулааны станцын зуухны шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Дулааны техник, үйлдвэр, экологийн хүрээлэн", "Эрчим дөл" ХХК-ийн түншлэл шалгаран, гэрээ байгуулагдсан. Энэ хүрээнд хуучин зуухны буулгалтын ажил хийгдэж дууссан, шинээр угсрах зуухны суурийн цутгалтын ажил хийгдсэн, зуух, туслах тоног төхөөрөмжийг захиалсан, зуухны хийцүүд үйлдвэрлэгдэн, тээвэрлэлт хийгдсэн. Барилга угсралтын ажил графикийн дагуу хийгдэж байна. Багц-2 буюу дулааны станцын дулаан дамжуулах төвүүд шинээр барих ажлын гүйцэтгэгчээр "Одкон холдинг" ХХК шалгаран, гэрээ байгуулагдсан. Дулаан дамжуулах төвийн барилга баригдаж, тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн. | |
| 6.7 | ТЭХТББ-ын 3.2.5, ЗГҮАХ-ийн 2.108 дахь заалт | Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, цахилгаан түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар | Багануур зүүн өмнөд бүс, Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг 4 | 50.0 | 8.5<br>Гадаад эх үүсвэр | Төслийн хүрээнд түгээх сүлжээний алдагдлыг бууруулах, ухаалаг тоолуур суурилуулах, ухаалаг тоолуур, борлуулалтын нэгдсэн программ хангамж нэвтрүүлэх ажил хийгдэж байна.<br>Борлуулалт, арилжааны программ нэвтрүүлэх ажлын хувьд "ЕСМ" ХХК-тай хийсэн гэрээний дагуу программыг нийлүүлж, хэрэгжүүлж, хүлээн авах ажил нь Орхон, Булган, Өвөрхангай, Хархорин, Архангай салбаруудад мэдээллийн бааз хөрвүүлж сургалт хийгдсэнээр гүйцэтгэл 90% болж одоогоор борлуулалт шинэ бүтцээр ажиллах бүрэн боломжтой болсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх, алдагдлыг бууруулах, шинэ техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх | аймагт хэрэгжүүлэх ажлын явц, хувиар | | | Төслийн хүрээнд хийгдэх ажлуудаас Говьсүмбэр аймгийн төвийн шугам сүлжээг шинэчлэх ажил 55.1 хувь; Багануур дүүргийн шугам сүлжээг шинэчлэх ажил 19.2 хувь; Өвөршанд 35/10кВ-ын 10 МВА дэд станцын барилга угсралтын ажил 54.0 хувь; Булган аймгийн төвийн шугам сүлжээний шинэчлэлт 64.8 хувь; Архангай аймгийн төвийн шугам сүлжээний шинэчлэлт 86.1 хувь; Эрдэнэтийн 35/6кВ-ын 2*10 МВА дэд станц 63.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Мөн төслийн хүрээнд 2020 онд зарлагдах тендерийн бэлтгэл ажлууд хангагдаж байна. | |
| 6.8 | ЗГҮАХ-ийн 2.110 дахь заалт | Метан хийг ашиглах боломжит нөөцийг бүрдүүлэх судалгааг эрчимжүүлэх, хийн хангамжийг хөгжүүлэх эрх зүй, дэд бүтцийн орчныг бүрдүүлэх, нүүрснээс цэвэр түлш гарган авах үйлдвэр барих төслийг эхлүүлэх | Метан хийн нөөцийг бүрдүүлэх, салбарын хөгжлийг дэмжсэн бүтэц зохион байгуулалт бий болгох, норм, дүрэм стандартуудыг батлуулах ажлын явц, хувиар | 100 | | "Хийн хангамжийн сүлжээ. Нэр томьёо, тодорхойлолт", "Хийн хангамжийн сүлжээ. Хийн ерөнхий шаардлага", "Хийн хангамжийн сүлжээ. Үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар ашиглах хийн техникийн шаардлага" стандартуудыг боловсруулан Стандартчиллын Үндэсний Зөвлөлөөр батлуулсан.<br>Метан хийг сүлжээнд нийлүүлэхэд бэлтгэх болон газар доорх хий хадгалах байгууламжийн технологийн төлөвлөлтийн нормчлол, Метан хий хадгалах байгууламж – Барилгын норм ба дүрэм, Метан хий дамжуулах сүлжээний техник ашиглалтын дүрэм, Орон сууцанд метан хийгээр ажилладаг тоног төхөөрөмжийг байршуулах ажлын зураг хийх заавар, Амины орон сууц болон зуслангийн байшинд метан хийн төхөөрөмж суурилуулах, инженерийн шугам хоолойн зураг хийх, угсралтын ажил гүйцэтгэх заавар зэрэг норм, дүрмүүдийн төслийг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн орчуулгад дахин редакц хийх ажлыг зохион байгуулж байна. Норм, дүрмийн орчуулгад редакц хийгдсэний дараа холбогдох байгууллагуудаас санал авч, салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | 40 |
| | | | Хийн хангамжийг хөгжүүлэх дэд бүтцийг байгуулах зураг төслийн ажлын явц, хувиар | 20.0 | | Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх "Метан хийн хангамжийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-ний бэлтгэл ажлыг хангах хүрээнд Азийн хөгжлийн банкны төлөөлөгчийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллав. Азийн хөгжлийн банкны төлөөлөгчтэй 2019 оны 4, 6, 10, 11 дүгээр саруудад албан уулзалт хийж төслийн цар хүрээг тодорхойлов. Мөн төсөл хэрэгжүүлэх зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулсан.<br>Төслийн санхүүжилтийн асуудал 2019 оны 09 дүгээр сард шийдвэрлэгдэн мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эхлүүлэх боломж бүрдэж Эрчим хүчний яам, Сангийн яам болон Азийн хөгжлийн банкны төлөөлөл "Метан хийн хангамжийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх САНАМЖ БИЧИГ"-т гарын үсэг зурсан.<br>Энэ хүрээнд мастер төлөвлөгөө боловсруулах зөвлөх сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, төслийн ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. | |
| 6.9 | ТЭХТББ-ын 4.1 дэх заалт | Эрчим хүчний нормативын баримт бичгийн тогтолцоог төгөлдөржүүлж, олон улсын стандартыг нутагшуулах, эрх зүйн орчныг сайжруулах | Боловсруулах дүрэм, норм, нормативын баримт бичгийн тоо | 2 дүрэм, 2 норм, 5 стандарт | 0.2 Нормчлолын сан | Эрчим хүчний нормчлолын сангийн хөрөнгөөр боловсруулсан "220 кВ-ын фазын удирдлага бүхий хийн таслуурын угсралт", "35 кВ-ын хийн таслуурын угсралт", "OPzV маягийн аккумляторын батарейг суурилуулах угсралт", "Батарейг байрлуулах тавиурыг угсарч суурилуулах" гэсэн 4 хөдөлмөр зарцуулалтын норм, "Иж бүрэн хуваарилах байгууламжийн угсармал иж бүрдэл хоргыг суурилуулах угсралтын төсвийн суурь норм", "ДЦС-ын тоног төхөөрөмжийн материал зарцуулалтын норм" нэртэй нийт 6 нормыг Эрчим хүчний сайдын 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 168, 169, 170, 173 дугаар тушаалаар тус тус баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 4442, 4443, 4444, 4445 дугаарт тус тус бүртгүүлсэн.<br>Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журмыг Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 125 дугаар тушаалаар баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 4378 дугаарт бүртгүүлэв.<br>Эрчим хүчний барилга байгууламжийг барих ажлын нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээ боловсруулах дүрмийг Эрчим хүчний сайдын 2019 оны 15 дугаар тушаалаар батлуулсан ба Эрчим хүчний нормативын баримт бичгийн дүрмийн төслийг батлуулах бэлтгэл хангуулсан. Нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээг Барилга хот байгуулалтын сайдаар батлуулахтай холбогдуулан Сангийн сайдтай зөвшилцөхөөр төслийг хүргүүлсэн.<br>Эрчим хүчний цахилгаан тоног төхөөрөмж, тоолуур, шугам сүлжээ, зуух, даралтат сав, хэмнэлт, аудит, эрчим хүчний менежмент, нэр томьёоны холбогдолтой нийт 44 стандартыг үндэсний стандартаар батлуулсан. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрчим хүчний стандартчиллын техникийн хорооны 2019 оны ээлжит 6 удаагийн хуралдаанаар ISO 16528-1; ISO 16528-2; эрчим хүчний аудитын холбогдолтой MNS EN 16247-3, 16247-4; эрчим хүчний хэмнэлттэй технологийн MNS IEC 60076-8 ба 20-р цуврал; MNS IEC 60034 -2-1,30-1, тоолуурын IEC 62056-21, IEC 61968-1 ба 9-р цуврал, цахилгааны нэр томьёоны 19, менежментийн 6, тоноглолын IEC 8 стандарт батлагдав. | |
| Зорилт 7.Эдийн засгийн өсөлтийг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 7.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.107 дахь заалт | Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөх | Ашиглалтад оруулах хатуу хучилттай авто замын урт, км | 500 | 68.5 Улсын төсөв, Гадаад эх үүсвэр | 2019 онд дараах авто замын бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэн, нийт 672.359 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулсан.<br>Үүнд:<br>1. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын 2.29 км хайрган хучилттай авто замыг улсын комиссын 10/01/19 дүгээр дүгнэлтээр;<br>2. "Эрдэнэс таван толгой" ХХК-ийн уурхайгаас Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн авто замтай холбох 8.2 км авто замыг улсын комиссын 10/02/19 дүгээр дүгнэлтээр;<br>3. Төв аймаг Зуунмод сумын 26-р багт баригдсан 0.4 км хатуу хучилттай авто замыг улсын комиссын 10/03/19 дүгээр дүгнэлтээр;<br>4. Булган-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 22 км авто замыг улсын комиссын 10/04/19 дүгээр дүгнэлтээр;<br>5. Аглаг бүтээлийн хийд чиглэлийн 6.2 км авто замыг улсын комиссын 10/05/19 дүгээр дүгнэлтээр;<br>6. Улаанбаатар-Хөшигийн хөндий чиглэлийн 32.226 км авто замыг улсын комиссын 10/07/19 дүгээр дүгнэлтээр;<br>7. Донойн нисэх буудлын хөөрч, буух хатуу хучилттай зурвас, явгалах зам, үерийн хамгаалалтын далангийн ажлыг улсын комиссын 10/09/19 дүгээр дүгнэлтээр;<br>8. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто замыг улсын комиссын 10/10/19 дүгээр дүгнэлтээр;<br>9. Баянхонгор-Байдрагын гүүр чиглэлийн 129.4 км авто замыг улсын комиссын 10/11/19 дүгээр дүгнэлтээр;<br>10. Баянзүрх дүүрэг 16 хороо Хорооллын доторх 3 км авто замын засварын ажлыг улсын комиссын 10/14/19 дүгээр дүгнэлтээр;<br>11. Тосонцэнгэлийн 4 замын уулзвар Нөмрөг-Сонгино | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замыг улсын комиссын 10/15/19 дүгээр дүгнэлтээр;<br>12. Гэр хорооллын авто замын засвар, шинэчлэлт 1 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20-р хороо/ авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг улсын комиссын 10/16/19 дүгээр дүгнэлтээр;<br>13. "Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын төсөл"-ийн концесс эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр хэрэгжиж буй 126.7 км хатуу хучилттай авто замын 30 км авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/17/19 дүгээр дүгнэлтээр;<br>14. "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх (BT) концессын гэрээгээр хэрэгжиж буй авто замын үлдсэн хэсэг болох 52.2 км авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/18/19 дүгээр дүгнэлтээр;<br>15. Чингис хот-Бэрх чиглэлийн аялал хатуу хучилттай авто замын эхлэл /20 км/ авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/19/19 дүгээр дүгнэлтээр;<br>16. "Морингын давааны хатуу хучилттай авто зам 1.2 км /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10-р хороо/" авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/20/19 дүгээр дүгнэлтээр;<br>17. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбох 17.5 км хүнд даацын хатуу хучилттай авто замыг улсын комиссын 10/21/19 дүгээр дүгнэлтээр;<br>18. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах Газрын тос боловсруулах үйлдвэр чиглэлийн дагнасан хэрэглээний салбар төмөр зам Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн АН-3 авто замтай огтлолцож буй хэсэгт баригдсан 3.686 км авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/22/19 дүгээр дүгнэлтээр;<br>19. "Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутагт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх MON-2710/0240 төсөл"-ийн хүрээнд баригдсан логистикийн төвийг Замын-Үүд сумтай холбох 4.347 км авто замын барилгын ажил улсын комиссын 10/23/19 дүгээр дүгнэлтээр; | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 20. Ховд-Өлгий чиглэлийн 60 км авто замын барилгын ажлыг 10/24/19 дүгээр дүгнэлтээр тус тус ашиглалтад оруулсан. | |
| | | | Ашиглалтад оруулах төмөр бетон гүүрийн урт, метр | 130 | 4.03<br>Улсын төсөв | Шинээр ашиглалтад орох төмөр бетон гүүр барих ажлын хүрээнд 2019 онд дараах ажлуудыг хийж, нийт 188.3 урт метр төмөр бетон гүүрийг ашиглалтад оруулсан. Үүнд:<br>1. Согоогийн голын 18.7 у/м төмөр бетон гүүрний барилгын ажлын гүйцэтгэгчээр "Жол" ХХК ажиллаж, тус гүүрний барилгын ажлыг 2019 оны 04 дүгээр сарын 01-нээс эхэлж, 100% хийж гүйцэтгэн, 2019 оны 06 дугаар сарын 12-нд ашиглалтад оруулсан. Улсын комиссын 10/01/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан.<br>2. Бооржийн голын 30.68 у/м төмөр бетон гүүрний барилгын ажлыг "Эйч Кэй Би Интернейшнл холдинг" ХХК барилгын бүрэн дуусаж, ашиглалтад оруулсан. Улсын комиссын 07/09/18 дугаар дүгнэлтээр баталгаажуулсан.<br>3. Намирын голын 48 у/м төмөр бетон гүүрний барилгын ажлын гүйцэтгэгчээр "Тэргүүн саруул зам" ХХК ажиллаж, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад хүлээн авсан. Улсын комисс 2019 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч, ашиглалтад оруулсан. Комиссын 10/06/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан.<br>4. Ширээгийн голын 90.9 у/м төмөр бетон гүүрний барилгын ажлын гүйцэтгэгчээр "ЗЗБ" ХХК ажиллаж, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулсан. Улсын комиссын 10/12/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан. | |
| 7.2 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.121 дэх заалт | Авто замын засвар, арчлалтын хугацааг уртасгах, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах | Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн хэрэгжилтийн явц, хувиар | 10.0 | 58.8<br>Гадаад эх үүсвэр | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд 2019 онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.1 км авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын ажлын зураг төслийг 2019 оны 03 дугаар сард эцэслэн боловсруулж дуусгасан. Зам барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын тендерийг 5 багц хэсгээр 2019 оны 03 дугаар сарын 21-нд зарлаж, 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр нээсэн. Шалгарсан гүйцэтгэгч | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | компаниудтай 2019 оны 06 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд гэрээ байгуулсан. Зам барилгын ажлыг 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр эхлүүлсэн. Нийт барилгын ажлыг гүйцэтгэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 33.2 хувьтай байна.<br>- Зам барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөхийн сонгон шалгаруулалтын ажлыг 2019 оны 01 дүгээр сарын 05 өдөр зохион байгуулж, шалгарсан зөвлөх компанитай 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулан, зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж байна.<br>- Төслийн 2 дахь шатны МОН-3786 зээлийн хэлэлцээрийг 2019 оны 03 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд зохион байгуулсан. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаар соёрхон баталсан ба Зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан.<br>- Дархан-Алтанбулаг чиглэлийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдсэн засвар арчлалтын ажлыг зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлсэн.<br>- Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засварын ажлын зураг төслийг 2019 оны 08 дугаар сард боловсруулж дууссан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан, тендерийн баримт бичгийн төслийг боловсруулж Азийн хөгжлийн банкнаас зөвшөөрөл авахаар хүргүүлсэн. | |
| | | | Улсын чанартай авто зам, гүүрийн засвар арчлалтын ажлын явц, хувиар | 100 | 30.0 Улсын төсөв | Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын хүрээнд 2019 оны төлөвлөгөөг замын чиглэл, хариуцагч компани бүрээр хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчимтэй уялдуулан гаргаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 288 дугаар тушаалаар батлуулж, зам хариуцагч төрийн өмчит 20, хувийн хэвшлийн 12 нийт 32 компанитай гэрээ байгуулан, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Өвлийн арчлалтын 47 цэгт "Шуурхай ажлын хэсэг" гарч ажилласан.<br>Олон улсын болон улсын чанартай 14918.7 км авто зам, замын байгууламжийн өдөр тутмын байнгын бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.<br>2019 онд замын засвар арчлалтын ажил 92%-тай хэрэгжсэн.<br>Улсын чанартай гүүрний засвар, арчлалтын ажлын хүрээнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дорнод аймгийн Хэрлэнгийн доод 264 у/м төмөр бетон гүүрний их засварын ажлыг гүйцэтгэхээр "ЗМЗ" ХХК шалгарч гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгасан. Улсын комисс 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн авч, 10/08/19 дүгээр дүгнэлтээр ашиглалтад оруулсан.<br>Хэнтий аймгийн Дадал сумын 238.9 у/м төмөр бетон гүүрний их засварын ажлыг гүйцэтгэхээр "Гангүүр" ХХК-тай гэрээ байгуулж, барилгын ажлын гүйцэтгэл 65 хувьтай хэрэгжиж байна.<br>Увс аймгийн Улаангом сумын Гашууны голын 72 у/м төмөр бетон гүүрний их засварын ажлын гүйцэтгэгчээр "Тэргүүн саруул зам" ХХК шалгарч гэрээ байгуулж, барилгын ажлын гүйцэтгэл 45 хувьтай хэрэгжиж байна. | |
| 7.3 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.119 дэх заалт | Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан авто замын сүлжээг сайжруулах, түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээ авах | Яармагийн 260 у/м шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах барилгын ажлын явц, хувиар | 100 | 15.9<br>Гадаад эх үүсвэр | Төслийн гүйцэтгэгч "Хятадын төмөр замын 20-р товчоо групп" корпорац төслийн зураг төсөв боловсруулах болон барилгын ажлыг гүйцэтгэсэн.<br>Төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаа 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тул үлдэгдэл ажлыг гүйцэтгэх график төлөвлөгөөг гаргуулж, төслийн ажлыг дуусгах асуудлаар зөвшилцөж 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс барилгын ажил эхлүүлсэн.<br>Төслийн хүрээнд 4 эгнээ шинэ гүүр бүхий 250 у/м, 20.5 м өргөнтэй, 50 у/м нүхэн гарц, D-рамп шинэ гүүр нь 276 у/м, 8.5 м өргөнтэй, 2 эгнээ бүхий хуучин гүүр нь 250 у/м, 9 м өргөнтэй, 57 у/м тунелтэй, гэрэлтүүлэг, борооны ус зайлуулах шугам, инженерийн шугам сүлжээний ажлуудыг тус тус хийхээр төлөвлөж гүүрний барилгын ажлыг бүрэн дуусган улсын комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажил хангагдаж байна. | 70 |
| | | | Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих ажлын явц, хувиар | 100 | 48.8<br>Гадаад эх үүсвэр | Төслийн гүйцэтгэгч "Хятадын төмөр замын 20-р товчоо групп" корпорац төслийн зураг төсөв боловсруулах болон барилгын ажлыг гүйцэтгэж байна.<br>Төслийн хүрээнд 2019 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>- Үндсэн гүүр, В рампын зам барилгын ажил, тэмдэг тэмдэглэгээ болон гэрэлтүүлгийн ажил хийгдэж авто замын хөдөлгөөнийг нээсэн.<br>- -L туслах 66 у/м гүүр /Дунд гол дээрх/-ийн ажлыг дуусган буцаж эргэх U-эргэлтийн хамт асфальтбетон хучилт хийж, түр замын замын хөдөлгөөнийг нээсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Төслийн барилгын ажлын А, С рамп, Олимпийн гудамжийг Нарны замтай холбосон үндсэн гүүрийн 2 талаар авто зам, U-эргэлтийн баруун хэсэгт Дунд гол дээгүүрх гүүрэн болон авто зам, үлдэгдэл гэрэлтүүлгийн ажил, явган хүний гүүр болон авто зам, инженерийн шугам сүлжээний ажлууд хийгдээ байна. Төслийн нийт барилгын ажлын явц 85 хувьтай байна. | |
| | | | Туул гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажлын явц, хувиар | 90.0 | 31.7<br>Гадаад эх үүсвэр | Төслийн гүйцэтгэгч “Бээжин Юни-Констракшн Групп”ХХК, туслан гүйцэтгэгч “Гангүүр”ХХК барилгын ажил гүйцэтгэж байна.<br>Төслийн зөвлөх үйлчилгээний ажлыг мөн зээлийн хөрөнгөөр “Гуанжоу Ванан Констракшн Сүпервишн” компани ажиллаж байна.<br>➢ Сонсголонгийн гүүр: Төслийн хүрээнд шинээр 289.4 у/м, 21.9 м өргөнтэй, 2 эгнээ төмөр бетон гүүрийг параллелаар шинээр барьж өргөтгөх ба Налайхын чиглэлийн шинэ замын дагуу Баянзүрхийн гүүрний ойролцоо шинээр 281.2 у/м, 22.6 м өргөнтэй, 4 эгнээ, үргэлжилсэн хайрцган дам нуруу бүхий төмөр бетон гүүрний барилга угсралтын ажил хийгдсэн. Сонсголонгийн гүүрний барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна. Комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажил хангагдаж байна.<br>➢ Баянзүрхийн гүүр: Гүүрний барилгын ажил дуусаж авто замын зорчих хэсгийн хөдөлгөөнийг нээсэн бөгөөд үерийн хамгаалалтын далангийн ажил, нөхөн сэргээлт, явган хүний замын хавтан суурилуулах ажлууд хийгдэж байна. Баянзүрхийн гүүрний барилгын ажлын гүйцэтгэл 93.55 хувьтай явагдаж байна. | |
| | | | Гачуургын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл шинэчлэл хийх барилгын ажлын явц, | 75.0 | 56.3<br>Гадаад эх үүсвэр | Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч Синохайдро Корпорейшн Лимитед компани Монголын үндэсний аж ахуйн нэгжүүд болох “Дардан говь” ХХК, “Тэгш плант” ХХК, “Гашууны гол” ХХК зэрэг нийт 3 туслан гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан гүйцэтгэсэн.<br>Зам барилгын ажлыг 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлүүлж, 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр 4 эгнээ авто замын зорчих хэсгийг дуусгаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээгээд байна.<br>Замын хуучин цемент бетон хучилтыг хуулж зөөх ажил 100 хувь, ухмал 100 хувь, далангийн дүүргэлт 100 хувь, 38 цэгт баригдах ус зайлуулах хоолойн ажил 100 хувь, 3 ш нүхэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хувиар | | | гарц буюу туннелийн ажил 100 хувь, Хөлийн голын төмөр бетон гүүрийн ажил 100 хувь, үндсэн 20.9 км авто замын суурь асфальтбетон хучилтын ажил 100 хувьтай байна.<br>Үлдэгдэл ажлууд болох төмөр туузан хашлага, суурьшлын бусийн хэсгүүдийн 5.1 км явган хүний болон дугуйн зам, 5 цэгт явган хүний гүүрэн гарц, өнгө асфальтбетон хучилт буюу 4 см-ээр нэмж хучих зэрэг ажлууд хийгдэж байна. | |
| | | | Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар | 30.0 | | "Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх" үндэсний хөтөлбөр боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 100 дугаар тушаалаар байгуулав. Хөтөлбөрийн төслийг боловсруулж, Авто тээврийн үндэсний төв, Зам тээврийн хөгжлийн төв, Нийслэлийн харьяа агентлагууд, Авто тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг хамруулсан хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр зохион байгуулсан.<br>Хөтөлбөрийг Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалт"-д нэмж тусгуулах талаар Засгийн газрын гишүүдээс санал авах 01/6634 тоот албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна. | |
| | | | Тусгай замын автобус (BRT) системийг нэвтрүүлэх 1 дүгээр шатны барилгын ажлын явц, хувиар | 50.0 | | Төслийн удирдах хороо 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:<br>1. "Тусгай замын автобусны сүлжээний чиглэл, коридоруудын хэрэгжүүлэх дараалал"-ыг тогтоохдоо:<br>1 дүгээр үе шатанд буюу Коридор 1А-г Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудал, Наадамчдын зам, Яармагийн гүүр, Чингисийн өргөн чөлөө, Сүхбаатарын талбай чиглэлд нийт 14.9 км зам;<br>2 дугаар үе шатанд Коридор 1Б-г Сүхбаатарын талбай, Их сургуулийн гудамж, Сүхбаатарын гудамж, Ногоон нуурын гудамж, Алтайн гудамж, Чингэлтэйн өргөн чөлөө, 7-н буудлын автобусны эцсийн зогсоол буюу нийт 7.8 км зам; Коридор 2-г Саппорогийн уулзвар, Ард-Аюушийн өргөн чөлөө, Энэбишийн өргөн чөлөө, Их тойруу, Намьянжугийн гудамж, Их хүрээ гудамж, Дүнжингарав олон улсын худалдааны төвийн уулзвар буюу нийт 10 км замын чиглэл зэрэг болно.<br>2019 онд төслийг хэрэгжүүлэх зорилгоор нийт 16 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тендерийн материалын төслийг Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн боловч тендер зарлахтай холбоотой хариу ирүүлээгүй.<br>Нийслэлийн Засаг дарга уг төслийг хэрэгжилтийг эрчимжүүлэхээр ажиллаж байна. | |
| 7.4 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.113 дахь заалт | Замын-Үүдэд тээвэр логистикийн төв байгуулах | Барилгын ажлын явц, хувиар | 100 | 11.5 Гадаад эх үүсвэр | Зам, тээвэр хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Улсын комисс 2018 оны 12 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд ажиллаж, Замын-Үүдэд тээвэр логистикийн төвийн байгуулах төслийн барилгыг 18/432/02 дугаар актаар ашиглалтад хүлээн авсан.<br>Тус яамнаас байгуулагдсан ажлын хэсэг 2019 оны 04 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд ажиллан логистикийн төвийн хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хүргүүлсэн.<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн "Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай" 218 дугаар тогтоол батлагдсан.<br>"Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН2719/0240 төсөл"-ийн Замын-Үүд логистикийн төвийн өмчлөгч "Монголын төмөр зам" ТӨХК, ашиглагч "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн хооронд түрээсийн гэрээ байгуулсан.<br>Төслийн удирдах хороо болон Азийн хөгжлийн банкны шийдвэрээр Замын-Үүдэд хэрэгжиж буй Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төслийн хүрээнд Замын-Үүд сумыг тус төвтэй холбох 4.3 км авто замын барилгын ажил гүйцэтгүүлэхээр Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо групп компанитай №4 дугаартай нэмэлт гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| 7.5 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.108, 2.112 дахь заалт | Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх | Төмөр замын зүүн, хойд коридорыг бий болгох төвийн коридорыг шинэчлэх барилгын ажлын явц, хувиар | 30.0 | | Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам:<br>Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөл нь Монгол-Орос-Хятадын "Эдийн засгийн коридор" хөтөлбөрийн Төмөр замын зүүн коридор байгуулах төсөлд багтсан. "Монголын төмөр зам" ТӨХК нь БНХАУ-ын "Башинь төмөр зам" ХХК-тай санамж бичиг байгуулж, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг "Башинь төмөр зам" ХХК-ийн санхүүжилтээр Хятадын Төмөр замын зураг төслийн гуравдугаар хүрээлэнгээр гүйцэтгүүлсэн. Тус техник эдийн засгийн үндэслэлийн үр ашиг бага гарсан тул Хөөт орчимд нүүрс боловсруулах, нүүрснээс хий, шингэн түлш гаргах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах аж үйлдвэрийн парк байгуулж төмөр замтай уялдуулан цогцоор нь | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжүүлэх, ачааны эх үүсвэрийг нэмэгдүүлж, Техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэхээр ажиллаж байна.<br>Монгол Улсын Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/188 дугаар тушаалаар Хөөт аж үйлдвэрийн парк төсөл санаачлагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу техник эдийн засгийн үндэслэл, төсөл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулан, ажиллаж байна.<br>Улаанбаатар төмөр замын шинэчлэлийн төсөл:<br>“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дохиолол, хориглол, төвлөрүүлэлтийн шинэчлэлийн ажлын хүрээнд хэсгийн нэвтрүүлэх чадварыг 20 хос галт тэргээр, тээх чадварыг 33 сая тонн хүртэл нэмэгдүүлэх, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг дээшлүүлэх, ашиглалтын зардлыг бууруулах “Хойд-Улаанбаатар-Замын-Үүд”-ийн чиглэлд нэг замт хоорондын замыг радио сувгаар галт тэрэгний хөдөлгөөнийг хоорондын зай, хугацаагаар зохицуулах системээр тоноглох, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн төвлөрүүлэлт, тоон радио холбоо, тоон технологийн холбооны системийг шинэчлэх Улаанбаатар төмөр замын 65 өртөө, зөрлөгт дохиолол төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн угсралт, суурилуулалтын ажлыг 2019 оны 08 дугаар сарын 30-нд хэрэгжүүлж дууссан.<br>Захиалагч Техникийн комисс ажиллуулсны дараа Улсын комисс хүлээж авах болно.<br>Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр зам:<br>Монгол Улсын Засгийн газрын 2017.01.11-ний өдрийн 10 дугаар тогтоолоор “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын шугамын чиг батлагдсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас УИХ-аар "Зарим газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах тухай" тогтоолоор Булнайн нурууг байгалийн цогцолборт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авснаар батлагдсан чигээс 100 гаран км дайран өнгөрсөн, мөн Ханжаргалантын байгалийн нөөц газартай давхацсанаар төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлэх боломжгүй болсон.<br>Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 282 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Булган аймгийн Бугат суманд 2019 оны 07 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд ажиллаж “Эрдэнэт-Овоот” | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэлийн төмөр замын төслийг Хужирын голын хөндийгөөр зэрэгцүүлэн явуулах боломжийг судалж, батлагдсан чигийн дагуу 47 км газарт Эгийн голын усан цахилгаан станц төслийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр замын трасстай огтлолцох 6 цэгийг газар дээр нь үзэж Хужирын голын хөндийгөөр явуулах боломжтой гэж үзэн 2019 оны 07 дугаар сарын 16-ны 19/228/07 дугаартай дүгнэлтийг гаргасан.<br>“Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын Концессын гэрээний хугацаа 2020 оны 04 дүгээр сард дуусахтай холбогдуулан Үндэсний хөгжлийн газраас 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 01/2255 дугаартай албан бичгээр ажлын хэсэг байгуулах санал иргүүлсэн. Уг саналын дагуу концесс эзэмшигч "Нортерн рэйлвэйс" ХХК-ны захиралтай уулзалт зохион байгуулж Хөвсгөл аймгийн Мөрөн чиглэлээр трассыг өөрчлөх боломжийг судлах, өмнөх шийдвэр, мэдээллийг яамны удирдлагуудад танилцуулахаар ажиллаж байна. | |
| | | | Их засвар хийгдэх төмөр замын урт, км | 50 | | 2019 оны жилийн эцсийн байдлаар гол замын их засварын ажлыг хойд, урд чиглэлүүдэд 37 км, Сүхбаатар, Аршаант өртөөдөд 13 км өргөтгөлийн ажил, нийт 50 км замд их засварын ажил хийж гүйцэтгээд байна. | |
| 7.6 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.114 дэх заалт | Орон нутгийн нисэх буудлуудын чадавхыг дээшлүүлэх | Ховд, Өмнөговь аймгийн нисэх буудлуудыг өргөтгөн шинэчлэх барилгын ажлын явц, хувиар | 40.0 | | Ховд аймгийн нисэх онгоцны буудлыг өргөтгөн шинэчлэх ажил:<br>Ховд аймгийн нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төслийг “Алтайн газрын хүч” ХХК гүйцэтгэж дуусган Иргэний нисэхийн ерөнхий газарт хүлээлгэн өгсөн.<br>Нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, аэродромыг 4С болгох ажлыг 2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.<br>Өмнөговь аймгийн нисэх онгоцны буудлыг өргөтгөн шинэчлэх ажил:<br>Өмнөговь аймгийн “Гурвансайхан” нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга, байгууламжийн зураг төсвийг гүйцэтгүүлэхээр “Алтайн газрын хүч” ХХК-тай гэрээг шинэчлэн байгуулахаар ажиллаж байна. Зураг төсөв боловсруулах ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ИНЕГ болон "ЭЗТ" ХХК хооронд "Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадал бүхий нисэх буудал болгох, өргөтгөх зураг, төсөл боловсруулах" ИНЕГ/ХО/ТББ/ЗҮ-09/19 дүгээр гэрээг 2019.10.25-ны өдөр байгуулсан. Зураг төсөл боловсруулах ажлын явц 40 хувьтай байна.<br>Нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх ажлыг 2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | |
| **ГУРАВ.БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО** | | | | | | | |
| Зорилт 8.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангана. | | | | | | | |
| 8.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.79 дэх заалт | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулах | Төсөл боловсруулах ажлын явц, хувиар | 70.0 | 0.6 Улсын төсөв | Төслийг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, хамтарч ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг 21 аймгийн Засаг даргын захирамжаар аймаг тус бүрд байгуулан ажиллуулсан. Судалгааны ажлын хүрээнд хангайн бүсээс бусад төвийн бүсийн 7, зүүн бүсийн 3, баруун бүсийн 5 аймгийн 160 сум, суурин газар, тосгонд ажиллаж, 15 аймгийн төвд төслөө танилцуулж, холбогдох саналыг авсан. Мөн сум, суурин газар бүрд орон нутгийн удирдлагыг хамруулсан фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулж, 34 судалгааны маягтаар нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тоон мэдээллүүдийг гаргуулан авч нэгтгэн боловсруулсан. Тухайн сум, суурин газар бүрд холбогдох барилга, байгууламж, хот байгуулалтын дэд бүтцийн талаар фото зураг авах бичлэг хийж, ажиглалтын болон баримтжуулах судалгааг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 70 хувьд хийж гүйцэтгэсэн.<br>Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 31 дүгээр тушаалаар Зөвлөх багийг байгуулан ажиллуулж, "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл" боловсруулах ажлыг мэргэжлийн арга зүй, зөвлөгөөгөөр хангаж, хамтран ажиллаж байна.<br>Төсөл боловсруулах ажлын явц, үр дүнг хянах, нэгдсэн удирдамж, чиглэлээр хангах үүрэг бүхий Төслийн хамтарсан зохицуулах хороог Ерөнхий сайдын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 32 дугаар захирамжаар байгуулсан. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төслийн хүрээнд салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулах үүрэг бүхий 5 дэд ажлын хэсгийг Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 110 дугаар тушаалаар, төслийн хүрээнд боловсруулах бодлогын баримт бичгүүдийн харилцан уялдаа, салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах, зөвлөх багуудтай хамтран ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 158 дугаар тушаалаар тус тус байгуулан ажиллаж байна.<br>Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын техник туслалцааны хүрээнд "Хүн амын нутагшилт, суурьшлыг хөгжлийн төсөл" боловсруулахад олон улсын туршлага, бодлогын дэмжлэг үзүүлэх, зөвлөмжийг боловсруулахаар 2019 оны 01 дүгээр сараас хамтран ажиллаж байна. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг эхний байдлаар боловсруулсан "Дунд шатны тайлан 1"-ийн хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулж, салбарын мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн, судлаачдыг хамруулан зохион байгуулж, холбогдох яам, газруудаас санал авч, төсөлд тусгаад байна. | |
| 8.2 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.81 дэх заалт | Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох | Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах хувь | 10.0 | | Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын хүрээнд Ортофото болон өндрийн тоон загварын 548 хуудас 2011-01-101/2019-01 дугаартай, 160 хуудас байр зүйн зургийг 2011-01-101/2019-02 дугаартай дугнэлтээр 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр, 220 хуудас ортофото болон өндрийн тоон загвар, 19144.5 км2 талбайн агаар, сансрын зургийг 2011-01-101/2019-05 дугаартай дүгнэлтээр 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр тус тус Архивын Мэдээллийн Төвд хүлээлгэн өгсөн.<br>ОХУ-ын буцалтгүй тусламжаар МУ-ын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах асуудлыг Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, уг асуудлыг Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэн зөвлөмж авах нь зүйтэй гэж шийдвэрлэсний дагуу Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд холбогдох материалыг хүргүүлсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс дээрх ажлыг дотоодын хөрөнгө оруулалтаар хийх нь зүйтэй гэж зөвлөсний дагуу ОХУ-ын буцалтгүй тусламжийг авах боломжгүй болсон. | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1:25000-ны масштабтай байр зүйн зураг зохиох суурь зураг болох сансрын зургийг 2018-2019 онд БНХАУ-ын Хэмжил, зураглалын байгууллагаас Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 70 хувьд хамрах талбайн хэмжээнд авсан. Илүү өндөр нарийвчлалын зураг авахаар Азербайджан улсын Азеркосмос байгууллагатай 2019 оны 11 дүгээр сард хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан. | |
| | | | Шинээр байгуулах GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай суурин станцын тоо | 15 | | Улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын судалгаа авахаар судалгааны маягтыг 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/186 албан тоотоор Оюу толгой ХХК, Таван толгой ХК, Энержи ресурс ХХК, Геомастер ХХК, Гео Инструментс ХХК, Геосүрвэй ХХК, Инженер геодези ХХК, Монмэп ХХК, Эрдэнэт үйлдвэр, Одон орон геофизикийн хүрээлэн зэрэг байгууллагуудад хүргүүлэн, судалгааг авч нэгтгэсэн.<br>Шинээр байгуулах GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай суурин станцын холбогдох тооцоо судалгааг хийж, Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, батлуулсан. Тус төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. | |
| | | | Газар зүйн 350 мянган нэрийн тодруулга, солбицолжуулалт хийх, хувиар | 30.0 | | Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг орон нутгийн төсөвт тусгуулах тухай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 1/1118 тоотыг 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлсний дагуу Дундговь аймаг 2019 онд орон нутгийн төсвөөр Сайнцагаан, Өлзийт сумын 2700 орчим газар зүйн нэрийн тодруулалт, солбицолжуулалтын ажлыг гүйцэтгэсэн байна.<br>Мөн Булган аймгийн 7 сум, Дундговь аймгийн 13 сумын нэрийн тодруулалтын Ажлын даалгаврыг хянаж, батлуулан, 2019 оны 12 дугаар сард тухайн аймгуудад хүргүүлсэн.<br>Газар зүйн нэрийг зөв нэрлэж хэвшүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах үйл ажиллагааны хүрээнд "Газар зүйн нэр түүхийн түүчээ" телевизийн нэвтрүүлэг бэлтгэн гаргаснаас гадна гарын авлага бэлтгэж иргэдэд тараах, газар зүйн үнэн, зөв нэрийг хэрэглэх, хадгалах, хамгаалах талаар таниулан сурталчлах ажлыг 21 аймагт зохион байгуулсан.<br>Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн стандарт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулж 2019 оны 10 дугаар сард Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2019 оны 11 дүгээр сард Стандарт хэмжил зүйн газарт батлуулахаар хүргүүлэв.<br>Газар зүйн нэрийн тодруулалт, солбицолжуулалтын талаар танилцуулга бэлтгэн 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын ажилтнуудад танилцуулав. | |
| | | | Өндрийн II дугаар ангийн сүлжээний давтан хэмжилт, хайгуул судалгаа, хэмжилт хийх цэгийн тоо | 681 | | Өндрийн 1-р ангийн сүлжээний цэгүүд дээрх GNSS-ийн сүлжээний нийт 375 цэгийн хэмжилтийн өгөгдлийг авч, урьд өмнө хийсэн ажлын үр дүнтэй харьцуулан шалгаж, солбицлын жагсаалт /каталог/-ыг геодезийн солбицол, тэгш өнцгийн солбицол, эллипсоидын өндөр, геоидын загвар ашиглан шилжүүлсэн ортометрийн өндөр гэсэн мэдээлэлтэйгээр бэлтгэсэн.<br>Цэгүүдийн хэвийн өндрийг өндрийн 2-р ангийн цэгүүдтэй харьцангуйгаар тодорхойлж 2019 оны 08 сард хэрэглээнд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>1944 онд байгуулсан өндрийн 2-р ангийн сүлжээний 2 шугамын цэгийн мэдээллийг Орон зайн өгөгдлийн системд оруулахаар 2019 оны 06 дугаар сард хүлээлгэн өгсөн.<br>Мөн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд өндрийн II ангийн сүлжээний 140 цэг дээр 1-р ангийн нарийвчлалаар өндрийн сүлжээний хэмжилт хийх ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын урсгал төсөвт тусган батлуулсан. | |
| 8.3 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.85 дахь заалт | Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн | Боловсруулах ерөнхий төлөвлөгөөний тоо | 10 | 1.84 Улсын төсөв | "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" баримт бичгийн хэрэгжилтийн байдал, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатар хотын бүс нутаг, хот орчмын судалгаа"-ны ажил, "Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци"-ийг боловсруулж, Архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, Барилга хот | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | еренхий төлөвлөгөөнд тодотгол хийх | | | | байгууллалтын сайдын зөвлөлийн хуралдаанаар 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр тус тус хэлэлцүүлж, дэмжигдсэн.<br>Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны буудлыг даган бий болох шинэ хот "Аэросити" –ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор, Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2019 оны 30 дугаар тогтоолоор батлуулаад байна.<br>Орхон, Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.<br>Завхан аймгийн төв Улиастай хот, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлж, мэргэжлийн зөвлөлийн гишүүдээс гарсан санал зөвлөмжийг тусгуулан холбогдох аймгуудын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2019 оны 12 дугаар сард хэлэлцүүлж дэмжигдсэн.<br>Замын-Үүдийн хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг "Нийслэлийн зураг төслийн хүрээлэн" орон нутгийн өмчим аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Нью урбанизм" ХХК, Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Идеал групп" ХХК боловсруулж, эцсийн шатны тайланг Барилга хот байгууулалтын яаманд ирүүлсэн. Барилга хот байгууулалтын сайдын 2019 оны 177, 180-р тушаалаар Алтанбулаг, Замын-Үүд хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд магадлал хийх экспертүүд томилогдон ажиллаж байна. "Алтанбулаг", "Бичигт", "Замын-Үүд" хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав. | |
| 8.4 | МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.91 дэх заалт | Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих болон | Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн явц, | 30.0 | 17.8 Гадаад эх үүсвэр | Булган, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Дундговь аймгийн төвд хоногт 3000 $м^3$ ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийг шинээр барих ажлын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>1. Булган аймгийн цэвэрлэх байгууламжийг барих ажлын хүрээнд биологи цэвэрлэгээний байгууламжийн барилгын ажил, шугам сүлжээний угсралтын ажил, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх | хувиар | | | захиргаа, харуул, дэд өртөөний барилга, лаг боловсруулах цехийн барилга, лагийн талбай, бохир усны шугам сүлжээний төмөр бетон тулгуурын угсралтын ажлууд бүрэн дууссан. Бохир усны 2,1км даралттай болон өөрийн урсгалтай ф300, ф150 мм-ийн голчтой хос шугам хоолойн угсралт, халаалтын зуухны дотор сантехникийн угсралтын ажлууд үргэлжлэн хийгдэж байна. Гадна цахилгаан хангамжийн ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн. Булган аймгийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 55 хувьтай явагдаж байна.<br>2. Хөвсгөл аймгийн цэвэрлэх байгууламжийн биологи цэвэрлэгээний блокийн барилгын ханын арматурчлал, механик цэвэрлэгээний блокийн суурийн цутгалт, баганын арматурчлалын ажил, захиргаа, дэд өртөөний, харуулын байрны барилгуудын хучилтын цутгалтын ажил, лаг боловсруулах цехийн суурийн цутгалт, цэвэрлэгдсэн усны насос станцын гадна өрлөгийн ажил, бохир усны, өрлөгийн угсралтын ажлууд хийгдсэн. Дотор цэвэр ус, дулааны шугамын угсралт, лагийн болон элсний талбайн бетоны ажлууд бүрэн дууссан. Хөвсгөл аймгийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын нийт ажил 52 хувьтай байна. | |
| | | | Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоох суурин газрын хөгжлийн төслийн явц, хувиар | 100 | 28.7<br>Гадаад эх үүсвэр | Өвөрхангай, Архангай, Өмнөговь, Дорноговь аймгуудын төвд ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байгуулах ажлын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар дараах ажлыг хийж гүйцэтгээд байна.<br>1. Архангай аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьж дуусган, аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/536 тоот захирамжаар байгуулагдсан комисс 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ажиллан, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.<br>2. Өмнөговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлын хүрээнд биологи цэвэрлэгээний блок, технологийн шугам сүлжээний ажил, бохир усны 5.1 км шугамын угсралтын ажил, лаг боловсруулах цех, лагийн талбай, цахилгаан дамжуулах агаарын 10 кв-ын шугамын угсралт, цахилгааны дэд өртөөний угсралтын ажлуудыг гүйцэтгэсэн. Үйлдвэрийн, механик цэвэрлэгээний блокийн барилгын ажил дуусах шатандаа явагдаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр барих барилгын ажлын явц, хувиар | 30.0 | 0.637 Улсын төсөв | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг эхлүүлж, 17.6 га талбайд баригдах шинэ цэвэрлэх байгууламжийн зураг төслийг Шанхайн зураг төслийн хүрээлэнд боловсруулж, 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр ЭЗ-5/2019 тоот ерөнхий дүгнэлтээр магадлал хийлгэн баталгаажуулсан.<br>Цахилгаан хангамжийн 45/2019, дулаан хангамжийн 145с/2019/87, холбоо дохиоллын ТН-В546/2019 тоот техникийн нөхцөлүүдийн сунгалт хийгдсэн. Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчлэн батлуулсан.<br>Цэвэрлэх байгууламжийн барилгын ажилд хэрэглэгдэх 120м3/цаг хүчин чадалтай бетон зуурмагийн 2 узелийг угсарч, БМҮ-БЭ-376/2019 тоот технологийн зааврыг батлуулсан. Узелийн машин механизм, тоног төхөөрөмжүүдийг шалгаж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын №18000000104 тоот аюулгүй ажиллагааны гэрчилгээгээр баталгаажуулсан. Барилга байгууламжийн ажил эхлүүлэх 01/2019 тоот зөвшөөрөл авсан. Зөвшөөрлийн дагуу төслийн барилга угсралтын талбайн бэлтгэл ажлыг хангаж түр ажилчдын байр, хашаа, цамхагт краныг байршуулан, биологи цэвэрлэгээний байгууламжийн суурийн газар шорооны ажил, бетон зуурмагийн узель угсрах, байгууламжийн суурийн ул бетон цутгах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. | |
| 8.5 | МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 2 | "Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх | Ус цэвэршүүлэх станцын барилгын ажлын явц, хувиар | 100 | 31.9 Гадаад эх үүсвэр | Австрийн хөнгөлөлттэй зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Тайшир-Алтай ус хангамж" төслийн хүрээнд Австри Улсын "Тиролер Рохре" ХХК-тай "Зураг төсөл-нийлүүлэлт-барилга угсралт"-ын ажлын гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Барилга байгууламжийн зураг төслийн ажил 100 хувь дуусаж, 2019 оны 4 дүгээр сарын 1-ны өдрийн 408/2019 дугаартай магадлалын дүгнэлт гарсан.<br>Барилгын ажил 2019 оны 04 дүгээр сараас эхэлсэн. Төслийн хүрээнд 54 км ган хоолой угсрахаас 27 км хоолойг угсарсан. Ус цэвэршүүлэх станц, усан сан, өргөлтийн насос станц болон 14 метрийн гүнтэй ус авах цооногийн төмөр бетон цутгалтын ажил тус тус бүрэн дууссан. Нийт барилга байгууламжийн угсралтын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. | 70 |
| 8.6 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 6, | Гэр хорооллын дахин | Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу | 80.0 | 26.0 Гадаад эх үүсвэр | Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, авто зам, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.3.1. Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.96 дахь заалт | төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд инженерийн дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх | дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажлын явц, хувиар | | | нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил 2019 оны жилийн эцсийн байдлаар 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ хүрээнд 2019 онд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:<br>Баянхошуу дэд төв:<br>- Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын хүрээнд 2ф700мм-ийн диаметртэй 1,6 км шугам, 2ф600мм-ийн диаметртэй 1,6 км шугам угсарч, тохижилт, нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн дуусган, 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр комисс ажиллаж, 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 2019/358 тоот актаар ашиглалтад оруулсан.<br>- Шинээр хийх гадна дулааны 2ф600мм-ийн 0.5 км шугам, 2ф400мм-ийн 0.4 км шугамын угсралтын ажил хийгдсэн.<br>- Цахилгааны 35/10кВ-ийн дэд станц, 10 кВ-ын хуваарилах байгууламж /ХБ/, мөн 2 ш хаалттай дэд өртөө /ХТП/-ний барилга угсралтын ажил дуусаж, цахилгаан тоноглол суурилуулах ажил хийгдэж байна.<br>- Баянхошуу дэд төвд барьж буй 1000 м3 усан сан, 2 насос станцын барилгын ажил болон 5.6 км ус дамжуулах шугамын барилга угсралтын ажил хувийн гүйцэтгэлтэй байна. Усан сангийн туршилт тохируулга хийгдсэн.<br>- Баянхошуу дэд төвийг холбосон ариутгах татуургын ф450-500мм, 2250 м ф600мм –ийн 4116 м шугам хоолойг угсарч, ашиглалтад оруулсан.<br>Сэлбэ төв:<br>- Нийт 8 Ус дулаан дамжуулах төв барихаас 6 барилгын угсралтыг хийж, дотор заслын ажил хийгдэж байна. Ус дулаан дамжуулах төв №1 барилгын суурийн ажил, Ус дулаан дамжуулах төв №4 барилгын 1-р давхрын өрлөгийн ажил хийгдэж дууссан.<br>- Сэлбэ дэд төвийг Чингэлтэй төвийн ус, дулаантай холбох дулааны төв шугамын угсралтын ажлыг дуусган, замын нөхөн сэргээлтийг хийсэн.<br>- Сэлбэ дэд төвд 28 МВт дулааны станцын барилгын ажил хийгдэж байна.<br>- 35/10кВ-ийн дэд станцын 10кВ-ын хуваарилах байгууламжийн барилгын гадна ханын өрлөгийн ажил дууссан. Мөн 2 ширхэг хаалттай дэд өртөөний барилгын ажил хийгдэж байна. Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын ажил 50 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувьтай хэрэгжиж байна.<br>- Сэлбэ дэд төвд үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил, үерийн далан дагуух тохижилтын ажлыг гүйцэтгэн, хүлээлгэн өгсөн.<br>- Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилгын ажил болон ус хангамжийн шугам хоолой суурилуулах ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж дууссан бөгөөд туршилт тохируулга, угаалга, шахалт хийгдсэн. | |
| | | | Шинээр байгуулах дэд бүтцийн төвийн тоо | 3 | 10.3 Улсын төсөв | Шинээр дэд бүтцийн төсвийг байгуулах ажлын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>- Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны төсвийн багцад нийслэлийн Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороонд "Бичил дэд төв"-ийг барих санхүүжилтийг тусган батлуулж, эхний ээлжийн газар чөлөөлөлт, барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 2019 оны жилийн эцсийн байдлаар 25 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>- Мөн нийслэлийн Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны "Бичил дэд төв"-ийн ус, дулаан хангамж, нам даралтын халаалтын зуух, авто зам, гадна тохижилт, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж, 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ашиглалтад оруулсан. | |
| 8.7 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.76, 3.4.3 дахь заалт | Гэр хороололд амины орон сууц барихад зориулж урт хугацааны хөнгөлөлттэй нөхцөлөөр ипотекийн зээл олгох | Ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах иргэдийн тоо | 6000 | 443.3 Улсын төсөв, Бусад эх үүсвэр | 2019 оны жилийн эцсийн байдлаар Монголбанкнаас 213.4 тэрбум төгрөг, улсын төсвөөс 112.0 тэбрум төгрөг, Арилжааны банкуудын эх үүсвэрээс 117.9 тэрбум төгрөг буюу нийт 443.3 тэрбум төгрөгийг ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй зээлд зарцуулж, 6476 зээлдэгчийг хамруулсан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 138.7 тэрбум төгрөг, 1800 зээлдэгчээр илүү байна.<br>Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам"-аар гэр хорооллын иргэн өөрийн өмчлөл, эзэмшлийн газартаа амины орон сууцыг зээлээр барих боломж бүрдүүлсэн бөгөөд энэ хүрээнд Улаанбаатар хотод 2019 онд амины орон сууц барихад 150 сая төгрөгийн зээл олгосон байна. | 70 |
| | | | Түрээсийн орон сууцанд хамрагдах иргэдийн тоо | 2000-аас доошгүй | 109.0 Хөгжлийн банк | "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айл, нийт 1542 айлын орон сууцыг 2019 оны 6 дугээр сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолоор МУ-ын Хөгжлийн банкнаас орон нутгийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн. Барилга, хот байгуулалтын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайдын баталсан "Түрээсийн орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах журам"-ын дагуу тухайн орон нутагт амьдарч байгаа иргэдийг хамруулах ажлыг орон нутгаас зохион байгуулсан.<br>БНСУ-ын Экспорт-Импорт банкны Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан /EDCF/-ийн Үнэлгээний ажлын хэсэг, Сангийн яам, "ТОСК" ТӨХХК-тай хамтран "Солонго 1, 2 орон сууцны хороолол барих" төслийн зээлийн гэрээнд тусгах "Хэлэлцээрийн тэмдэглэл"-ийг эцэслэн боловсруулж, 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр албажуулан, талууд гарын үсэг зурж баталгаажуулсан.<br>Энэхүү зээлийн хүрээнд Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд "Солонго 1", "Солонго 2", Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороонд "Баянголын ам" зэрэг газарт түрээсийн 7000 айлын орон сууцны хорооллуудыг барих ажлыг эхлүүлэхээр бэлтгэж байна.<br>Мөн БНХАУ-ын Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийн хүрээнд баригдах орон сууцны зарим хэсгийг түрээслэх бөгөөд төслийн зээлийн хэлэлцээрт Барилга хот байгуулалтын яамны холбогдох удирдлагууд 2019 оны 7 дугаар сард гарын үсэг зурж баталгаажуулсан. | |
| 8.8 | МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.72.6 дахь заалт | Ган, төмөрлөг болон цементийн үйлдвэрлэлийг дэмжих, бизнесийн таатай орчныг бий болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй барилгын ган туйвангийн 16 үйлдвэрээс 12 үйлдвэр хэвийн ажиллаж 2019 онд 55700 тонныг үйлдвэрлэсэн. Энэ нь үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оноос 54 хувиар өссөнийг харуулж байна.<br>Энэ нь 2019 онд "Лэл минерал" ХХК, "Дархан анд" ХХК-ын ган туйвангийн үйлдвэр шинээр ашиглалтад орсонтой холбоотой. Дотоодын гангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Бэрэн группын гангийн үйлдвэрийг бодлогоор дэмжин хөнгөлөлттэй зээлд хамруулсан. "Бэрэн" ХХК-ийн гангийн үйлдвэрт 73,852.7 сая төгрөгийн санхүүжилтийг Хөгжлийн банкнаас олгосон. Энэхүү санхүүжилтээр домен 35 м.куб зуух, домен 70 м.куб зуух, кран, хүчилтөрөгчийн конвертор, цахилгаан нуман зуух, шанаган зуух, тасралтгүй цутгах машин, хөргөлтийн усан сан, хүчилтөрөгчийн станц, цувих цехийг ашиглалтад оруулаад байна. Нийт ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.<br>Мөн Цементийн 14 төрлийн евро стандартыг боловсруулан, Стандартчилал хэмжил зүйн газрын Стандартын Техникийн Хороогоор 2019 оны 11 дүгээр | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сард хэлэлцүүлэн дэмжигдсэн.<br>Түүнчлэн БНХАУ-д мөрдөж буй цементийн турших аргын химийн шинжилгээний стандартуудыг шинээр боловсруулан Стандартчилал хэмжил зүйн газрын Бетоны стандартын Техникийн Хорооны хурлаар 2019 оны 11-р сард хэлэлцүүлэн, дэмжигдсэн. | |
| Зорилт 9.Агаар, орчны бохирдлыг бууруулан, байгалийн нөөцийн хамгаалалт, зохистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | | | | | | | |
| 9.1 | МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.1.3, 4.1.6 дахь заалт | Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Агаарын бохирдлыг бууруулахад шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 100 | 44.4 Улсын төсөв | БНСУ-ын дэвшилтэт технологи, инновацад суурилсан орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглосон "Сайжруулсан шахмал түлш"-ний үйлдвэр байгуулан гэр хорооллын түлшний хэрэгцээг хангах зорилт тавин "Тавантолгой Түлш" ХХК байгуулагдан ажиллаж байна. Эрчим хүчний салбарын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар сайжруулсан шахмал түлш болох бүтээгдэхүүний орц, жорыг баталгаажуулсан. Тус үйлдвэрийн 3 шугам 24 цагаар үйлдвэрлэл явуулж байсан ба 4, 5-р шугамын тоног төхөөрөмжийн угсралтын ажил дуусан, туршилт тохируулгын ажил хийгдэж, 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс 4 шугам бүрэн бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна. Батлагдсан орц, жорын дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэл тасралтгүй, хэвийн явагдаж, нөөцлөлтийн ажлыг зохион байгуулж байна.<br>Тус үйлдвэр хоногт 2096 орчим тонн сайжруулсан шахмал түлшийг үйлдвэрлэж, 1800-2000 тонн сайжруулсан шахмал түлшийг дундын агуулах болон түгээлтийн цэгүүдэд хүргүүлж байна.<br>Сайжруулсан шахмал түлшний MNS 5679:2019 стандартыг Стандартчилал Хэмжил Зүйн Үндэсний төвийн Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.<br>Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, түүнтэй холбогдож гарсан тогтоол, шийдвэрүүдийн дагуу Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын 41 964 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах түгээх сүлжээний техникийн боломжийг бүрдүүлэх барилга угсралтын ажлыг 2017-2019 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж дуусгав.<br>Уг ажлаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 1 ба 3-р бүсэд байрлах Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн 35 хорооны 41 964 айл өрх хамрагдсан.<br>Дээрх айл өрхүүдэд 4 кВт цахилгаан халаагуураар залгах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боломж бүрдүүлэх ажлын хүрээнд 2019 онд 110 кВ-ын 1 дэд станц, 35 кВ-ын 1 дэд станц, 10 кВ-ын 3 хуваарилах байгууламж, шинээр 6-10 кВ-ын 246 дэд өртөө, хуучин байсан 152 дэд өртөөний хүчин чадлыг нэмэгдүүлэх, 6-10 кВ-ын 25 шугам, фидерийн ачааллыг хувааж хөнгөлөх, 13 шугамын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, 35 цэгт сүлжээг секцлэн хуваах автомат таслуурын пунктыг шинээр суурилуулах, 7 фидерийн хүчдэлийг 6 кВ-оос 10 кВ болгон нэмэгдүүлэх, 0.4 кВ-ын 561 км шугам шинэчлэх, 20 602 айлын оруулгын утсыг шинэчлэн солих ажлыг тус тус хийж гүйцэтгэв.<br>6-10 кВ-ын агаарын шугамын ачааллыг хөнгөлөх, дамжуулагчийн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, 6 кВ-оос 10 кВ-д шилжүүлэх, шугам фидерийг алсын удирдлагатай таслуураар секцлэн хувааснаар гэр хорооллын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлж, сүлжээний горим ажиллагааг оновчтой болгож аваар устгах хугацааг бууруулсан. Мөн нэг хэрэглэгчид ногдох тасалдлын дундаж хугацаа (САЙДИ) 45.9 минутаас 28.3 минут болж 17.6 минутаар 38 хувиар буурч, нэг хэрэглэгчид ногдох тасалдлын тоо 0.75-аас 0.54 удаа болсон. Мөн фидерийг автоматаар секцлэн хуваах төхөөрөмж суурилуулснаар нэгж тасралтад хамрагдах хэрэглэгчийн тоог 23 хувиар бууруулсан. | |
| 9.2 | МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 1, 2.3.3. Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.1, 4.2.2 дахь заалт | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгаалалтын менежментийг сайжруулах | Тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээ, мянган га | 600.0 | | Монгол Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн өргөтгөл 908.6 мянган га, Отгонтэнгэрийн ДЦГ-ын өргөтгөл 102.2 мянган га, Булган гол-Их Онгогийн БЦГ-ын өргөтгөл 152.7 мянган га, Дарьгангын БЦГ-ын өргөтгөл 302.4 мянган га, Нөмрөгийн ДЦГ-ын өргөтгөл 266.7 мянган га, Монгол дагуурын "Б" дархан цаазат газрын өргөтгөл 876.5 мянган га, байгалийн цогцолборт газрын ангиллаар Тэсийн гол, Булнайн нуруу 369.6 мянган га, байгалийн нөөц газрын ангиллаар Дулаан хайрхан уул 39.0 мянган га, Дэлгэрхаан уул 48.4 мянган га, Хөх нуур 94.7 мянган га, Улз голын эх 102.5 мянган га, Ташгайн таван нуур 155.1 мянган га, Жаран тогоон тал- А, Б хэсэг 97514.16 га /А/ 91.0 мянган га /Б/, Мэнэнгийн цагаан хоолой 45.7 мянган га, Халхын таван уул 99.4 мянган га, Баяндун уул 53.0 мянган га, Баяндун уулын өргөтгөл 53.0 мянган га, Зотол хаан уулын өргөтгөл 42.6 мянган га, Гүн гашууны хоолой 141.3 мянган га, Онгон таван булгийн БНГ-ын өргөтгөл 155.9 мянган га, байгалийн дурсгалт газрын ангиллаар Цагаан дэлийн агуй 116.0 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мянган га талбай бүхий 22 газрын 3.4 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад авлаа. Эдгээр 22 газрыг Улсын тусгай хамгаалалтад нэмж авснаар Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тоо 117 болж улсын газар нутгийн 20.11 хувь буюу нийт 31.4 сая га талбайг хамарч байна. Цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 48.4 хувь, ойн сан бүхий газрын 39.3 хувийг хамгаалалтад авсан. Цаашид 6 аймгийн 13 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 9 газар бүхий 2.1 сая га талбайн "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай" УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлж байна. | |
| | | Дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авсан хамгаалалтын захиргааны тоо | 11 | 2.7 Гадаад эх үүсвэр | Биологийн олон янз байдлыг хамгаалах уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн 11 хамгаалалтын захиргаадад 206.1 сая төгрөгийн галд тэсвэртэй иж бүрэн 40 ширхэг хувцас хэрэглэл, 80 ширхэг гутал, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын 33 захиргаад болон БОАЖЯ, сав газрын захиргаадад 54.3 сая төгрөгийн 71 ширхэг дрон, 7 ширхэг таблет Тарвагатайн нурууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 630.0 сая төгрөгийн хамгаалалтын захиргааны байр 1 ширхэг, сургалт мэдээллийн төв 1 ширхэг, 3 ширхэг байгаль хамгаалагчийн байруудыг Бийрийн уулс ХХК-аар, Отгонтэнгэрийн Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 506.3 сая төгрөгийн сургалт мэдээллийн төв 1 ширхэг, 6 ширхэг байгаль хамгаалагчийн байрыг Тамирын цахиур ХХК-аар ажлыг тус тус гүйцэтгүүлж, ашиглалтад оруулсан. Хустайн нурууны байгалийн цогцолборт газарт 780 сая төгрөгийн байгаль хамгаалагч, судлаач, мэргэжилтнүүдэд зориулсан 2 давхар 16 айлын 700 м.кв хэмжээтэй судлаач байгаль хамгаалагчийн байрыг 2019 оны 12 дугаар сард хүлээн авсан. Нийт 1 ширхэг хамгаалалтын захиргааны байр, 2 ширхэг сургалт мэдээллийн төв, 28 ширхэг байгаль хамгаалагч мэргэжилтний байр барьсан байна. Хамгаалалтын захиргаадыг радио холбоогоор холбох ажлын хүрээнд техникийн шийдэл, гүйцэтгэгчийн ажлын даалгавар, төсөв боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах зөвлөх багийг сонгон шалгаруулж 79.0 сая төгрөгийн гэрээг байгуулж, зөвлөх үйлчилгээг үзүүлсэн байна.<br>2019 оны жилийн эцсийн байдлаар 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, Тусгай хамгаалалттай газар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сард хэлэлцүүлэн дэмжигдсэн.<br>Түүнчлэн БНХАУ-д мөрдөж буй цементийн турших аргын химийн шинжилгээний стандартуудыг шинээр боловсруулан Стандартчилал хэмжил зүйн газрын Бетоны стандартын Техникийн Хорооны хурлаар 2019 оны 11-р сард хэлэлцүүлэн, дэмжигдсэн. | |
| Зорилт 9.Агаар, орчны бохирдлыг бууруулан, байгалийн нөөцийн хамгаалалт, зохистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | | | | | | | |
| 9.1 | МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.1.3, 4.1.6 дахь заалт | Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Агаарын бохирдлыг бууруулахад шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 100 | 44.4<br>Улсын төсөв | БНСУ-ын дэвшилтэт технологи, инновацад суурилсан орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглосон "Сайжруулсан шахмал түлш"-ний үйлдвэр байгуулан гэр хорооллын түлшний хэрэгцээг хангах зорилт тавин "Тавантолгой Түлш" ХХК байгуулагдан ажиллаж байна. Эрчим хүчний салбарын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар сайжруулсан шахмал түлш болох бүтээгдэхүүний орц, жорыг баталгаажуулсан. Тус үйлдвэрийн 3 шугам 24 цагаар үйлдвэрлэл явуулж байсан ба 4, 5-р шугамын тоног төхөөрөмжийн угсралтын ажил дуусан, туршилт тохируулгын ажил хийгдэж, 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс 4 шугам бүрэн бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна. Батлагдсан орц, жорын дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэл тасралтгүй, хэвийн явагдаж, нөөцлөлтийн ажлыг зохион байгуулж байна.<br>Тус үйлдвэр хоногт 2096 орчим тонн сайжруулсан шахмал түлшийг үйлдвэрлэж, 1800-2000 тонн сайжруулсан шахмал түлшийг дундын агуулах болон түгээлтийн цэгүүдэд хүргүүлж байна.<br>Сайжруулсан шахмал түлшний MNS 5679:2019 стандартыг Стандартчилал Хэмжил Зүйн Үндэсний төвийн Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.<br>Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, түүнтэй холбогдож гарсан тогтоол, шийдвэрүүдийн дагуу Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын 41 964 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах түгээх сүлжээний техникийн боломжийг бүрдүүлэх барилга угсралтын ажлыг 2017-2019 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж дуусгав.<br>Уг ажлаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 1 ба 3-р бүсэд байрлах Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн 35 хорооны 41 964 айл өрх хамрагдсан.<br>Дээрх айл өрхүүдэд 4 кВт цахилгаан халаагуураар залгах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боломж бүрдүүлэх ажлын хүрээнд 2019 онд 110 кВ-ын 1 дэд станц, 35 кВ-ын 1 дэд станц, 10 кВ-ын 3 хуваарилах байгууламж, шинээр 6-10 кВ-ын 246 дэд өртөө, хуучин байсан 152 дэд өртөөний хүчин чадлыг нэмэгдүүлэх, 6-10 кВ-ын 25 шугам, фидерийн ачааллыг хувааж хөнгөлөх, 13 шугамын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, 35 цэгт сүлжээг секцлэн хуваах автомат таслуурын пунктыг шинээр суурилуулах, 7 фидерийн хүчдэлийг 6 кВ-оос 10 кВ болгон нэмэгдүүлэх, 0.4 кВ-ын 561 км шугам шинэчлэх, 20 602 айлын оруулгын утсыг шинэчлэн солих ажлыг тус тус хийж гүйцэтгэв.<br>6-10 кВ-ын агаарын шугамын ачааллыг хөнгөлөх, дамжуулагчийн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, 6 кВ-оос 10 кВ-д шилжүүлэх, шугам фидерийг алсын удирдлагатай таслуураар секцлэн хуваасаар гэр хорооллын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлж, сүлжээний горим ажиллагааг оновчтой болгож аваар устгах хугацааг бууруулсан. Мөн нэг хэрэглэгчид ногдох тасалдлын дундаж хугацаа (САЙДИ) 45.9 минутаас 28.3 минут болж 17.6 минутаар 38 хувиар буурч, нэг хэрэглэгчид ногдох тасалдлын тоо 0.75-аас 0.54 удаа болсон. Мөн фидерийг автоматаар секцлэн хуваах төхөөрөмж суурилуулснаар нэгж тасралтад хамрагдах хэрэглэгчийн тоог 23 хувиар бууруулсан. | |
| 9.2 | МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 1, 2.3.3. Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.1, 4.2.2 дахь заалт | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгаалалтын менежментийг сайжруулах | Тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээ, мянган га | 600.0 | | Монгол Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн өргөтгөл 908.6 мянган га, Отгонтэнгэрийн ДЦГ-ын өргөтгөл 102.2 мянган га, Булган гол-Их Онгогийн БЦГ-ын өргөтгөл 152.7 мянган га, Дарьгангын БЦГ-ын өргөтгөл 302.4 мянган га, Нөмрөгийн ДЦГ-ын өргөтгөл 266.7 мянган га, Монгол дагуурын "Б" дархан цаазат газрын өргөтгөл 876.5 мянган га, байгалийн цогцолборт газрын ангиллаар Тэсийн гол, Булнайн нуруу 369.6 мянган га, байгалийн нөөц газрын ангиллаар Дулаан хайрхан уул 39.0 мянган га, Дэлгэрхаан уул 48.4 мянган га, Хөх нуур 94.7 мянган га, Улз голын эх 102.5 мянган га, Ташгайн таван нуур 155.1 мянган га, Жаран тогоон тал- А, Б хэсэг 97514.16 га /А/ 91.0 мянган га /Б/, Мэнэнгийн цагаан хоолой 45.7 мянган га, Халхын таван уул 99.4 мянган га, Баяндун уул 53.0 мянган га, Баяндун уулын өргөтгөл 53.0 мянган га, Зотол хаан уулын өргөтгөл 42.6 мянган га, Гүн гашууны хоолой 141.3 мянган га, Онгон таван булгийн БНГ-ын өргөтгөл 155.9 мянган га, байгалийн дурсгалт газрын ангиллаар Цагаан дэлийн агуй 116.0 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мянган га талбай бүхий 22 газрын 3.4 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад авлаа. Эдгээр 22 газрыг Улсын тусгай хамгаалалтад нэмж авснаар Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тоо 117 болж улсын газар нутгийн 20.11 хувь буюу нийт 31.4 сая га талбайг хамарч байна. Цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 48.4 хувь, ойн сан бүхий газрын 39.3 хувийг хамгаалалтад авсан. Цаашид 6 аймгийн 13 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 9 газар бүхий 2.1 сая га талбайн "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай" УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлж байна. | |
| | | | Дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авсан хамгаалалтын захиргааны тоо | 11 | 2.7 Гадаад эх үүсвэр | Биологийн олон янз байдлыг хамгаалах уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн 11 хамгаалалтын захиргаадад 206.1 сая төгрөгийн галд тэсвэртэй иж бүрэн 40 ширхэг хувцас хэрэглэл, 80 ширхэг гутал, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын 33 захиргаад болон БОАЖЯ, сав газрын захиргаадад 54.3 сая төгрөгийн 71 ширхэг дрон, 7 ширхэг таблет Тарвагатайн нурууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 630.0 сая төгрөгийн хамгаалалтын захиргааны байр 1 ширхэг, сургалт мэдээллийн төв 1 ширхэг, 3 ширхэг байгаль хамгаалагчийн байруудыг Бийрийн уулс ХХК-аар, Отгонтэнгэрийн Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 506.3 сая төгрөгийн сургалт мэдээллийн төв 1 ширхэг, 6 ширхэг байгаль хамгаалагчийн байрыг Тамирын цахиур ХХК-аар ажлыг тус тус гүйцэтгүүлж, ашиглалтад оруулсан. Хустайн нурууны байгалийн цогцолборт газарт 780 сая төгрөгийн байгаль хамгаалагч, судлаач, мэргэжилтнүүдэд зориулсан 2 давхар 16 айлын 700 м.кв хэмжээтэй судлаач байгаль хамгаалагчийн байрыг 2019 оны 12 дугаар сард хүлээн авсан. Нийт 1 ширхэг хамгаалалтын захиргааны байр, 2 ширхэг сургалт мэдээллийн төв, 28 ширхэг байгаль хамгаалагч мэргэжилтний байр барьсан байна. Хамгаалалтын захиргаадыг радио холбоогоор холбох ажлын хүрээнд техникийн шийдэл, гүйцэтгэгчийн ажлын даалгавар, төсөв боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах зөвлөх багийг сонгон шалгаруулж 79.0 сая төгрөгийн гэрээг байгуулж, зөвлөх үйлчилгээг үзүүлсэн байна.<br>2019 оны жилийн эцсийн байдлаар 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, Тусгай хамгаалалттай газар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутгийн хамгаалалтын захиргаадын дэд бүтэц, материаллаг бааз сайжирсан. | |
| | | | Шинээр баригдах байгаль хамгаалагчийн байрны тоо | 30 | 1.36 Гадаад эх үүсвэр | Тарвагатайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 630.0 сая төгрөгийн дүнтэй хамгаалалтын захиргааны байр 1 ширхэг, сургалт мэдээллийн төв 1 ширхэг, 3 ширхэг байгаль хамгаалагчийн байруудыг Бийрийн уулс ХХК-аар, Отгонтэнгэрийн ДЦГ-н хамгаалалтын захиргаанд 506.3 сая төгрөгийн сургалт мэдээллийн төв 1 ширхэг, 6 ширхэг байгаль хамгаалагчийн байрыг Тамирын цахиур ХХК-аар ажлыг тус тус гүйцэтгүүлж, ашиглалтад оруулсан. Хустайн нурууны байгалийн цогцолборт газарт 780 сая төгрөгийн өртөгтэй байгаль хамгаалагч, судлаач, мэргэжилтнүүдэд зориулсан 2 давхар 16 айлын 700 метр кв. хэмжээтэй судлаач байгаль хамгаалагчийн байрыг 2019 оны 12 дугаар сард хүлээн авсан. Нийт 1 ширхэг хамгаалалтын захиргааны байр, 2 ширхэг сургалт мэдээллийн төв, 28 ширхэг байгаль хамгаалагч мэргэжилтний байр барьсан байна. | |
| 9.3 | МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.3.3.7 дахь заалт | Цаг уур, орчны шинжилгээний техник, технологийн шинэчлэл, сүлжээний өргөтгөл хийх | Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхагийн барилгын ажлын явц, хувиар | 100 | | Барилга барих зөвшөөрлийг Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Архитектур төлөвлөлтийн даалгавар дугаар МЗХ2019/04-07 гаргуулж, ажлын даалгаврын дагуу барилгын эскиз зургийг "Форум Арт" ХХК-аар гүйцэтгүүлж байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер 2 удаа зарласан боловч, гомдол гарч дахин тендер зарлахаар болсон. | 40 |
| | | | Байгаль орчны төв лабораторийн барилгын ажлын явц, хувиар | 100 | | Бүгд Найрамдах Солонгос улсын Засгийн Газрын 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 14 сая ам.долларын өртгөөр Байгаль орчны төв лабораторийг тоноглох арга хэмжээ дэмжигдэж, Санамж бичгийн жагсаалтад орсон.<br>Байгаль орчныг хамгаалах хэмжилзүйн төв лабораторийн шинэ барилга барих талаар Солонгосын "EXIM" банктай 5 удаагийн уулзалтыг зохион байгуулж, ТЭЗҮ боловсруулах шатанд хэрэгжиж байна. БОХЗТЛ-ийн барилгыг шинээр барих төслийн хүрээнд БНСУ-ын мэргэжилтэн ТЭЗҮ-г урьдчилсан байдлаар танилцуулав. Эхний байдлаар төсөвт өртөг 15.9 сая ам. доллар болсон нь тохиролцоноос 2 сая ам. доллароор нэмэгдсэн. | |
| | | | Цаг уур, | 100 | | Барилга барих зөвшөөрлийг Нийслэлийн хот төлөвлөлт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орчны шинжилгээний газрын конторын барилгын ажлын явц, хувиар | | | ерөнхий төлөвлөгөөний газрын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Архитектур төлөвлөлтийн даалгавар дугаар МЗХ2019/04-07 гаргуулсан. Даалгаврын дагуу барилгын эскиз зургийг "Форум Арт"ХХК-аар гүйцэтгүүлж байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер 2 удаа зарлагдсан ч шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул дахин зарлахаар болсон. | |
| | | | Технологийн шинэчлэл хийх цаг уурын өртөөний барилгын тоо | 6 | 0.966 Улсын төсөв | БОАЖЯ-аас Өвөрхангай аймгийн орон нутгийн өмчийн газарт тус арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлсэн ба 2019.04.22-нд тендер зарлан амжилтгүй болсон тул 2019.05.22-нд цахимаар дахин нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, гүйцэтгэгчээр "Шоо констракшн" ХХК-ийг шалгаруулан, 96.6 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу ажил дуусаж, барилгыг хүлээн авсан. | |
| | | | Усны бохирдлыг тодорхойлох багаж, тоног төхөөрөмжийн тоо | 2 | | Усны бохирдлыг тодорхойлох спектрофотометрийн багаж 2019 онд Архангай, Говьсүмбэр, Дархан, Дорноговь, Дундговь, Төв, Увс, Ховд, Завхан, Багануурын байгаль орчны шинжилгээний лабораториудад хуваарилан хэмжилтэд ашиглаж байна. | |
| 9.4 | МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 4.2.3-4.2.5 дахь заалт | Хүн амын ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж, хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлэх борoo, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, | Гидрогеологийн дунд масштабын зураглал, хайгуул судалгааны ажлын тоо | 3 | 0.7 Гадаад эх үүсвэр | Дэлхийн банкны санхүүжилтээр Уул уурхайн дэд бүтцийг дэмжих төслийн хүрээнд:<br>1.1. Дорноговь аймгийн төв - Сайншанд сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсврийн газрын доорх усны ашиглалтын хайгуул судалгааны ажлыг "Эрдэнэдрийлинг" ХХК хийж гүйцэтгэн хайгуулын ажлын үр дүнгээр тогтоогдсон газрын доорх усны "Зээгийн хөтөл"-ийн ордын нөөцийг үйлдвэрлэлийн А зэргээр нийт 76.0 л/с буюу 6566.4 м3/хоногоор;<br>1.2. Говь-Алтай аймгийн Цогт сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсврийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын ажлыг "Охь ус" ХХК хийж гүйцэтгэн энэ ажлын үр дүнгээр тогтоогдсон газрын доорх усны "Төгрөгийн гол"-ын ордын нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр нийт 13.0 л/с буюу 1123.3 м3/хоногоор;<br>1.3. Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвийн хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсврийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын ажлыг "Гранд электротехноком" ХХК хийж гүйцэтгэн Усны нөөцийн зөвлөлд хэлэлцүүлэн ТНБД-ын 2019 оны 06 дугаар сарын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гол, горхи, булаг, шандны эхийг хашиж хамгаалах | | | | 18-ны өдрийн А/271 тоот тушаалаар нөөцийг тус тус баталж, Улсын усны мэдээллийн санд бүртгэж авсан. 1.4.Дархан-Уул аймгийн Шарын гол сумын төвийн хүн амын ус хангамжийн Буянтын эх үүсвэрийн газрын доорх усны ордын нөөцийг үйлдвэрлэлийн А зэргээр 5.0 л/с буюу 432 м3/хоног, В зэргээр 10 л/с буюу 8640 м3/хоног, нийт А+В зэргээр 15.0 л/сек буюу 1296 м3/хоногоор тогтоож 2019 оны 09 дүгээр сарын 23-нд Усны нөөцийн зөвлөлд хэлэлцүүлэн усны нөөцийг батлуулсан.<br>Газрын доорх усны хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх ажлыг Дэлхийн банкны санхүүжилтээр Уул уурхайн дэд бүтцийг дэмжих төслийн хүрээнд 2014-2016 онуудад говийн бүсийн 3 сав газруудын газрын доорх усны хяналт шинжилгээний 119 цооногийг цэвэрлэж, хяналт шинжилгээний тоног төхөөрөмжийг засварлан усны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг хангасан. Мөн шинээр 30 цэг байгуулан багаж тоног төхөөрөмж суурилуулж, 10 цооногийг нэмж гарган, төхөөрөмжилсөн. 2019 оны байдлаар газрын доорх усны хяналт шинжилгээний 265 цэг болж өргөжүүлсэн. | |
| | | | Шинээр байгуулах хөв, цөөрмийн тоо | 10 | 2.6 Улсын төсөв | 2019 онд 1905800 $м^3$-ийн эзлэхүүнтэй 12 хөв, цөөрмийн барилга угсралтын ажлыг Увс, Архангай, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт хийж гүйцэтгээд байна. Хөв, цөөрөм барих ажилд нийт 2.6 тэрбум төгрөгийг зарцуулсан. | |
| | | | Хамгаалалт хийх булаг, шандны тоо | 100 | | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан "Байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх тухай" 2019 оны гэрээний 1, 2 дугаар хавсралтад булаг, шандын эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг тусгуулж, ажилласнаар 2019 онд орон нутгийн төсвөөр нийт 182 булаг, шандын эхийг хамгаалсан. | |
| | | | Сүлжээнд холбогдсон усны хяналт-шинжилгээний харуулын тоо | 50 | | Ус, цаг уурын улсын сүлжээнд 158 ус судлалын өртөө харуул ажиллаж, гадаргын усны чанарын хяналтыг 194 цэг дээр хийж байна. 2019 оны төсөвт шинээр ус судлалын харуул байгуулахад шаардлагатай урсгал зардал батлагдаагүй ч 1 харуулыг Сэлэнгэ аймагт шинээр байгуулан 8-р сарын нэгнээс ажиллуулж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 33 бүрэн автомат, 188 хагас автомат багаж суурилуулж, нийт 221 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | усны хяналт-шинжилгээний цэгийг улсын сүлжээнд холбон ажиллуулж байна. | |
| 9.5 | МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт-1, Төрөөс ойн талаар баримтлах бодлого" /цаашид ТОТББ гэх/-ын 3.1, 3.2, 3.3, ЗГҮАХ-ийн 4.1.4, 4.2.7 дахь заалт | Ой хамгаалал, ойжуулалтын ажлыг чанаржуулж, ойн нөхөн сэргээлтийн ажлыг дэмжих | Ойжуулалт, нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ, мянган га | 7.5 | 2.4 Улсын төсөв, 2.0 Гадаад эх үүсвэр, 1.1 Хувийн хөрөнгө оруулалт | Улсын хэмжээнд 8954.1 га талбайд ойжуулах ажлыг гүйцэтгэсэн. Үүнээс, улсын төсвийн хөрөнгөөр 5153.5 га, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1205.5 га, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 2558.3 га талбайг ойжуулсан. Нийт ойжуулсан талбайн 2392.5 га нь ойг нөхөн сэргээх, 4683.5 га нь байгалийн сэргэн ургалтад туслах, 1846.3 га нь ойн зурвас байгуулах, 31.8 га нь ногоон байгууламж байгуулсан.<br>Нийт 5.5 тэрбум төгрөг зарцуулсан. Үүнээс:<br>Улсын төсвийн хөрөнгөөр 2.4 тэрбум төгрөг<br>Олон улсын байгууллагаас 2.0 тэрбум төгрөг<br>Орон нутгийн төсөв, Хувийн хэвшлийн хөрөнгөөр 1.1 тэрбум төгрөг зарцуулсан. | 100 |
| | | | Ойн цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мянган га | 30.0 | 0.750 Улсын төсөв | "2019 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай" Байгаль орчин,аялал жуулчлалын сайдын 2018 оны А/299 дугаар тушаалаар ойн сан бүхий аймаг, сум болон тусгай хамгаалалттай газар нутгийн ойн санд ойн цэвэрлэгээний арга хэмжээг 30.6 мянган га талбайд хэрэгжүүлэхээр батлан, аймаг, орон нутагт хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан. 2019 оны 12 дугаар сарын байдлаар ойн арчилгаа, цэвэрлэгээг 30.5 мянган га талбайд хийж 410.6 мянган шоометр мод бэлтгэж, 1450.8 сая төгрөг төсөвт орсон байна. Байгаль орчин,аялал жуулчлалын сайдын 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/38 дугаар тушаалаар ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад зориулж 750.0 сая төгрөг баталсан. Ойн цэвэрлэгээний техник тоног төхөөрөмжийг цэвэрлэгээний ажилд нэвтрүүлэх, туршилт, үйлдвэрлэлд ашиглах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ойн цэвэрлэгээний тоног төхөөрөмж нийлүүлэх нээлттэй тендерийн ажлыг зохион байгуулж, гэрээт ажлыг дүгнэн, модыг унагах, мөчирлөх, сортиментэд хуваах, модыг базаж ачих нэмэлт тоноглол бүхий олон үйлдэлт тракторыг актаар хүлээж аваад байна.<br>Улсын төсвийн хөрөнгөөр 750.0 сая төгрөг зарцуулсан | |
| | | | Ойн хөнөөлт шавьжийн хөнөөлийн | 200.0 | 1.0 Улсын төсөв | 2019 онд улсын хэмжээнд ойн хөнөөлт шавж, өвчний тархалт, хөнөөлийн голомтыг тогтоох судалгааны ажлыг 260.0 мянган га талбайд, хөнөөлийн голомтыг хязгаарлах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | голомттой тэмцэх талбайн хэмжээ, мянган га | | | тэмцлийн ажлыг 129.8 мянган га талбайд, нийт судалгаа, тэмцлийн ажлыг 2729.8 мянган га талбайд хийж гүйцэтгэсэн. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр ойн хөнөөлт шавж өвчний тархалтын судалгааны ажлыг 15 аймаг, нийслэлийн 145 сум, дүүргийн ойн сангийн 2.4 сая га талбайд, хөнөөлийн голомтыг хязгаарлах тэмцлийн ажлыг 4 аймгийн 12 сумын ойн сангийн 67.1 мянган га талбайд, орон нутгийн төсвийн хөрөнгөөр судалгааны ажлыг Булган аймгийн ойн сангийн 200.0 мянган га, тэмцлийн ажлыг Завхан, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл, Хэнтий, Төв аймгийн ойн сангийн 62.7 мянган га талбайд явуулсан. Ойн хөнөөлт шавж, өвчний хөнөөлийн голомт бүхий 129.8 мянган га талбайн 33.2 хувь буюу 43.0 мянган га-д онгоцоор, 37.5 хувь буюу 48.7 мянган га-д механик аргаар /өндөг түүх/, 13.4 хувь буюу 17.4 мянган га-д гэрлэн урхиар, 15.9 хувь буюу 20.7 мянган га-д үүргийн шүршигчээр тэмцлийн ажлыг хийж гүйцэтгэв.<br>Улсын төсвийн хөрөнгөөр 1 тэрбум төгрөг зарцуулсан | |
| 9.6 | МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.4.3 дахь заалт | Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу үйлчилгээний цогцолборыг байгуулах | Үйлчилгээний цогцолбор байгуулах ажлын явц, хувиар | 50.0 | 7.7 Улсын төсөв, 0.14 Гадаад эх үүсвэр, 1.0 Хувийн хөрөнгө оруулалт | 1.Богдхан уул, Түлүүгийн даваанд аялагчдад зориулсан ариун цэврийн байгууламж барьсан. /100 сая төгрөг /<br>2. Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газарт 2 отоглох цэг тохижуулсан /Орхоны хөндийд 2, Горхи-Тэрэлжийн цогцолбор газарт 2 отоглох цэг байгуулах ажлын тендерийг зарлаад байна /төслийн санхүүжилтээр 140 сая төгрөг/<br>3. Хан-Хэнтийн Тусгай хамгаалалттай газар нутаг, Хорго-Тэрхийн ТХГН, Хөгнө Тарнын ТХГН, Дундговийн эх газрын чулуу зэрэг газарт нэгдсэн отоглох цэг, тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбар, хогийн цэг, ариун цэвэр байгуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. /150 сая төгрөг төсөвлөсөн одоогоор зарцуулаагүй/.<br>4. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт үйлчилгээний цогцолбор төв байгуулах ажлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулах ажлыг эхлүүлсэн. /хувийн хэвшлийн санхүүжилт 1 тэрбум төгрөг/<br>5. 2019 онд нийт 2 ариун цэврийн байгууламж, зохих тэмдэг тэмдэглэгээ, авто зогсоол бүхий 4 түр буудаллах цэг, 4 отоглох цэг байгуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.<br>6. Бурхан Халдун буюу Хан Хэнтийн ТХГН-ыг зорих жуулчдад зориулсан аялал жуулчдын бүтээгдэхүүн бий болгох ажлыг 37.5 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7. Дорноговь аймгийн Хамрын хийдэд шашны аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох ажлыг 100 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж, 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр хүлээн авсан. Өвөрхангай аймгийн Хархорин суманд жуулчдад зориулсан задгай театр байгуулах ажлыг 200 сая төгрөгийн санхүүжилтээр 2019 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан.<br>8.Төв аймгийн Манзуширын хийдийг шашин, соёл, аялал жуулчлалын төв болгох ажлын ТЭЗҮ-ыг 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр боловсруулсан.<br>9.Хэнтий аймагт Андлалын өргөө, Их хуралдай, Шихихутаг цогцолборуудыг байгуулах ажлуудыг 5.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар эхлүүлж 2019 онд 2 цогцолборыг хүлээн авсан. 2020 онд 1 цогцолборыг ашиглалтад оруулна. | |
| 9.7 | МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.4.3 дахь заалт | "Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих санхүүжилтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхлэх | Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар | 30.0 | 0.157 Гадаад эх үүсвэр | "Тогтвортой аялал жуулчлал" төслийг 38 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх ажлыг 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, төслийг Хэнтий аймгийн Дадал сумын нутагт Мянганы суут хүн-Их эзэн Чингис хаан цогцолборыг 19 сая ам.доллар, Хөвсгөл аймгийн Хатгал, Ханх сумдад "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх" төслийг 19 сая ам.доллароор тус тус 2019-2023 онд хэрэгжүүлж эхлээд байна. | 100 |
| 9.8 | МУТХҮБ-2030-ын 2.3.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.2.5 дахь заалт | Ундны усан дахь уран болон бусад хүнд металл тодорхойлох орчны шинжилгээний лабораторийг чадавхжуулах | Шинжилгээнд ашиглах тоног төхөөрөмж | 1 | - | Монгол Улсын 2019 оны төсөвт хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй тул энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон. | Үнэлэх боломж-гүй. |
| 9.9 | МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.6 дахь заалт | Байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тогтоох үнэлгээнд орон нутаг | Хууль бус үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх | 100 | 0.605 Улсын төсөв | 2019 оны жилийн эцсийн байдлаар 6 хавсралт бүхий Нөхөн сэргээлтийн мэдээ, тайлан ирүүлэх тухай албан бичгийг орон нутагт хүргүүлэн, тайланг нэгтгэсэн. 2019 онд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 350 сая төгрөг, 10 аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 227 сая төгрөг, Өмнөговь аймаг Олон улсын санхүүжилт болон Бичил уурхай эрхлэгчдийн санхүүжилтээр 25 сая төгрөг, Увс аймагт бичил уурхайчид | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | оролцдог байх, санхүүжилтийг төсөвт тусгах | талбайн хэмжээ, га | | | өөрсдөө 3 сая төгрөг буюу нийт 605 сая төгрөгийг эвдэрч эзэнгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийхээр төсөвлөсөн байна. 2019 онд 9 аймгийн 13 сум, нийслэлийн 2 дүүрэгт Нөхөн сэргээлтийн 5 мэргэжлийн байгууллага буюу "Шал констракшн" ХХК, "Нигүүлсэн" ХХК, "Өү Би Би Таун" ХХК, "Экоминерал" ХХК, "Бэсү консалтинг" ХХК, Хэнтий аймгийн "Хариуцлагатай бичил уурхайчдын нэгдсэн холбоо гишүүдэд үйлчлэх" ТББ, Орхон аймгийн "Очир төв" ХХК, Говьсүмбэр аймгийн "Церкон геологи" ХХК, Увс аймгийн "Бум-Эрдэнэ", "Боргочуудын хишиг" нөхөрлөлүүд болон иргэд орон нутгийн төрийн байгууллагууд Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тусгай хамгаалалтын нутгийн удирдах газруудын 112 га-д техникийн, 30 га-д биологийн нөхөн сэргээлт буюу нийт 142 га-д нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэн тайлан гарган, актаар хүлээлгэж өгсөн. | |
| 9.10 | МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.6 дахь заалт | Цөлжилт, газрын доройтлыг бууруулах | Шинэчлэх аргачлалын тоо | 1 | - | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 07 дугаар 29-ний А/412 дугаар тушаалаар "Цөлжилт газрын доройтлыг бууруулах аргачлал шинэчлэн боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хурал зохион байгуулсан. 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдөр яамны цахим хуудаст Аргачлал боловсруулах зарыг байршуулж, Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 8 дугаар сарын 30-ны "Хөрөнгө гаргах тухай" тушаал гаргаж, 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр 19/368 дугаартай гэрээг байгуулсан. Аргачлалыг 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд болон Ус цаг уурын орчны төвийн байгаль орчны лабораторийн төлөөллүүдэд танилцуулан хэлэлцүүлж, санал авсан. Гэрээний дагуу 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр аргачлалыг хүлээн авсан. "Цөлжилт газрын доройтлыг бууруулах аргачлал"-ыг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. | 0 |
| Зорилт 10.Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүний чадавхыг сайжруулж, гамшгийн үеийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 10.1 | МУТХҮБ-2030-ын 2.3.2, Зорилт 1, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах | Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, аврах, гал | Шинээр баригдах аврах, гал унтраах ангийн тоо | 1 | 1.14 Улсын төсөв | Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, аврах, гал унтраах ангийн чадавхыг сайжруулах хүрээнд дараах аймаг, орон нутагт аврах, гал унтраах ангийн барилгыг шинээр барих болон их засварын ажлыг гүйцэтгэж байна. Үүнд:<br>Увс аймгийн Баруунтуруун суманд баригдаж буй Гал түймэр унтраах, аврах ангийн барилгын суурийн ажил | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлого, хөтөлбөр /цаашид “ГХТТББХ” гэх/-ийн 5.10, ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт | унтраах ангийн чадавхыг сайжруулах | | | | бүрэн хийгдэж, гадна фасадны будаг, зам талбайн тохижилтын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын ажил 90.0 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| | | | Их засвар хийх аврах гал унтраах ангийн тоо | 2 | | - Засгийн газрын 2018 оны 114 дүгээр тогтоолоор Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд шинээр байгуулсан Гал түймэр унтраах, аврах 71 дүгээр ангийг барилга байгууламжаар хангахад сум дундын эмнэлгийн хуучин байрыг ангийн байр болгож засварлахад 10.0 сая төгрөг, автограш барихад 75.0 сая төгрөгийг зарцуулж 2019 оны 6 дугаар сарын 24-ний өдөр үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлсэн.<br>- Төв аймгийн Мөнгөнморьт сум дахь Гал түймэр унтраах, аврах 75 дугаар ангийн үйл ажиллагааг эхлүүлэх, барилга байгууламжаар хангахад тухай орон нутгаас 2019 онд 40.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, ашиглалтад оруулсан.<br>- Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум дахь Гал түймэр унтраах, аврах 73 дугаар ангийг барилга байгууламжаар хангахад орон нутгаас 2019 онд 20.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд барилгын засварын ажил 90.0 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>- Баянхонгор аймгийн Бууцагаан суман дахь Гал түймэр унтраах аврах 72 дугаар ангийн барилга байгууламжийг барихад тус сумын Засаг даргын Тамгын газрын хуучин барилгыг Онцгой байдлын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэн авч засварыг хийж ашиглалтад оруулсан. | |
| 10.2 | ГХТТББХ-ийн 5.4, ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт | Аврах, гал унтраах техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 40.0 | 0.5 Улсын төсөв<br>12.2 Гадаад эх үүсвэр<br>1.4 Хандив | Аврах, гал унтраах техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2019 онд дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл”-ийг амжилттай хэрэгжүүлж, нийт 3.0 сая евро буюу 9.0 тэрбум төгрөгийн өртөгтэй 3 төрлийн 15 нэгж автомашиныг хүлээн авч, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар, Төв, Өмнөговь, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газруудад олгосон. Энэхүү төслийн хүрээнд 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр “Хээрийн удирдлагын штаб”-ын зориулалтаар ашиглах автомашиныг Нийслэлийн онцгой байдлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газарт хүлээлгэж өгсөн.<br>- Австрали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа "Монгол Улсын Сэлэнгэ, Хэнтий аймгийн зарим сумдын гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн гал түймэр унтраах чадавхыг сайжруулах" төслийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо, Норовлин, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдад 55.0 сая төгрөгийн 9 төрлийн 60 ширхэг багаж, хэрэгслийг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдөр хүлээлгэн өгөв.<br>- Япон Улсын "Жайка" Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжиж буй "Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд газар хөдлөлтийг биеэр мэдрүүлэх төхөөрөмжийг Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд суурилуулсан.<br>Барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилт үнэлэх, бат бэх чанарыг шалгах 5 нэр төрлийн 50.0 сая төгрөгийн өртөг бүхий багаж тоног төхөөрөмжийг хүлээн авсан.<br>- Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл (GRANT9187-MON)-ийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр, Улаан-Уул сумдад 133 эрт зарлан мэдээллийн болон гамшгийн аюулын дотоод зарлан мэдээллийн системийн тоног төхөөрөмжийг суурилуулж, 12 завь, 370 ширхэг амьсгалын бие даасан төхөөрөмж, 270 ширхэг зөөврийн усны үүргэвч, суурин болон хөдөлгөөнт холбооны хэрэгсэл, 380 ширхэг үлээгч аппаратыг төсөл хэрэгжиж буй аймгуудад хүлээлгэн өгсөн.<br>- "Монгол Улсын Онцгой байдлын албаны хот доторх эрэн хайх, аврах ажиллагааны чадавхыг сайжруулах нь" төслийн хүрээнд 25 нэр төрлийн 292 хайрцаг багаж, хэрэгслийг Үндэсний аврах бригадад хүлээн авч байршуулсан.<br>- Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд II шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх хүчин чадал бүхий гамшгийн үеийн хөдөлгөөнт хээрийн эмнэлгийн нийт 6.5 сая еврогийн өртөг бүхий 250 гаруй нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжийг хүлээн авч, 2019 оны 12 дугаар сарын 26, 27-ны өдөр Үндэсний аврах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бригадын агуулахад байршуулсан.<br>- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Био аюулгүй байдлыг хангах үндэсний хороо, Европын Холбооны Хими, биологи, цацраг идэвхт болон цөмийн эрсдэлийг бууруулах (CBRN CoE санаачилга) санаачилгатай хамтран "Төв Азийн орнуудад био аюулгүй байдал, био хамгааллын үндэсний хууль эрхзүйн орчныг сайжруулах бүсийн P53" төслийн хүрээнд нийт 11.2 сая төгрөгийн өртөг бүхий "Агаараас бичил биетний дээж авах" багажийг хүлээн авсан.<br>- Аврах ажиллагааны 3 ширхэг завь худалдан авах 2019 оны улсын төсөвт 500.0 сая төгрөгийн эх үүсвэр батлагдсан бөгөөд худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу цахим тендер шалгаруулалт зарлаж Харх ХХК-тай гэрээ байгуулан тийрэлтэт завь 3 ширхэгийг 410.0 сая төгрөгөөр, хийлдэг завь 4 ширхэгийг 59.4 сая төгрөгөөр худалдаж авсан.<br>- Иргэдийн санаачилгаар 2018-2019 онд цугларсан 1.4 тэрбум төгрөгийн хандиваар дулаан мэдрэгч камераар тоноглогдсон нисгэгчгүй нисэх аппарат, дагалдах хэрэгсэл, усчин болон уулчин аврагчийн иж бүрэн хувцас хэрэглэл, хорт хийн утаанаас хамгаалах амьсгалын бие даасан төхөөрөмж, 4 дугуйт кавдроцикл, металл хайгч аппарат зэрэг 14 төрлийн 1,378 багаж хэрэгсэл худалдан авч 21 аймгийн Онцгой байдлын газарт хуваарилсан. | |
| 10.3 | ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт | Гамшгийн үед ашиглах нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах механикжсан хүнсний болон шатахууны агуулахыг барих | Шинээр барих механикжсан агуулахын тоо | 2 | 0.35 Улсын төсөв 0.078 Гадаад эх үүсвэр | Гамшгийн үед ашиглах нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах механикжсан хүнсний болон шатахууны агуулахыг барих хүрээнд 2019 онд дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Гамшгийн үед ашиглах нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах механикжсан хүнсний болон шатахууны агуулахыг шинээр барих зорилгоор Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороонд улсын нөөцийн хүнсний бараа, материал механикжсан иж бүрэн агуулахын цогцолбор барилга барих 0.7 га, Рашаант өртөөнд улсын нөөцийн газрын тосны бүтээгдэхүүний 20.0 мянган метр куб багтаамжтай терминал агуулах барих 12.0 га газар эзэмших зөвшөөрөл авч мэргэжлийн байгууллагаар зураг, төслийг хийлгэж, Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөр хянуулан баталгаажуулж, Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Улаанбаатар Дулааны сүлжээ" ТӨХК, УБТЗ-аас цахилгаан, дулаан, салбар зам барих, өргөтгөх техникийн нөхцөлүүдийг авсан. | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хүнсний бараа, материал хадгалах иж бүрэн механикжсан агуулах барихад 42.0 тэрбум төгрөг, газрын тосны бүтээгдэхүүний 20.0 мянган метр куб багтаамжтай терминал агуулах барихад 54.0 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд агуулахуудыг барих төслийг Концессын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 заалтын дагуу "Барих-шилжүүлэх" төрлөөр төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулах саналыг холбогдох газруудад хүргүүлсэн.<br>Онцгой байдлын ерөнхий газраас 2019 онд улсын нөөцийн агуулахын чадавхыг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн 1 ангийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахын 1000 м.куб багтаамжтай 8 савны тоноглолыг шинэчлэх;<br>- Улсын нөөцийн хүнсний бараа, материал хадгалах иж бүрэн механикжсан агуулах болон газрын тосны бүтээгдэхүүний терминал агуулах барих төсөв /2013 онд хийгдсэн./-ийг норм дүрэм, стандартын дагуу шинэчлэх, ажлын зурагт тодотгол хийх;<br>- Төв, орон нутаг дахь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, Улсын нөөцийн салбар, цэгүүдийн нөөцийн бараа, материал хадгалах агуулахуудын их засвар, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажилд 358.9 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж агуулах, сав, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажилласан.<br>- Мөн Онцгой байдлын ерөнхий газар, Азийн хөгжлийн банктай хамтран Ядуурлыг бууруулах Япон сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх" төслөөс нийт 78.8 сая төгрөгөөр төв, орон нутаг дахь улсын нөөцийн 4 салбарын нөөцийн бараа, материал хадгалах агуулахын их засвар, хашааг шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн. | |
| **ДӨРӨВ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| Зорилт 11.Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ая тухтай сурч, боловсрох орчны бүрдүүлэх бодлого хэрэгжүүлж, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр цогц арга хэмжээ авна. | | | | | | | |
| 11.1 | МУТХҮБ-2030-ын 2.2.3, | Сургуулийн өмнөх | Хамран сургалтын бохир жин, хувиар | 85.0 | 91.1 Улсын төсөв | Монгол Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд нийт 1439 хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, эдгээрт нийт 263,333 хүүхэд хамрагдаж байна. Мөн 8 цэцэрлэгийн дэргэд болон 2 их сургууль, 2 цэргийн анги, 4 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2 дахь заалт | боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлэх | | | 2.8 Гадаад эх үүсвэр | аж ахуй нэгж, байгууллагын санаачилгаар "салбар бүлэг" байгуулж, шинээр 500 хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 84.1 хувьтай байна. | |
| | | | Шинээр ашиглалтад орох цэцэрлэгийн тоо | 85 | | 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10,020 хүүхдийн хүчин чадал бүхий 76 цэцэрлэг, гадаадын зээл тусламжаар 275 хүүхдийн хүчин чадал бүхий 3 цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орсон. | |
| | | | Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдийг камержуулах хувь | 100 | | 2019 онд 66 цэцэрлэгт 658 камер шинээр суурилуулсны 129 нь гадна орчинд, 529 нь дотно орчны хяналтыг сайжруулахад зориулагдсан байна. Ингэснээр нийслэлийн төрийн өмчийн 239 цэцэрлэгийн 233 буюу 97.4 хувь нь бүрэн камержуулагдсан байна. | |
| 11.2 | МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.3, 3.2.6, 3.2.14 дэх заалт | Ерөнхий боловсролын сурагчдын аюулгүй, аятухтай сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх | Гурван ээлжээр хичээллэж буй сургуулийн тоог бууруулах, хувиар | 100 | 121.3 Улсын төсөв | 2019 онд 17,790 хүүхдийн хүчин чадал бүхий 46 сургуулийг шинээр ашиглалтад оруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр "Барилга түрээслэх тухай" А/522 дугаар тушаалаар нийслэлийн хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд 11 сургууль сургалтын зориулалтын барилга түрээслэн сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж 3 ээлжээр хичээллэж буй сургуулиудыг 2 ээлжид бүрэн шилжүүлэв. | 100 |
| | | | Шинээр ашиглалтад орох Ерөнхий боловсролын сургуулийн тоо | 62 | | 2019 онд улсын хэмжээнд нийт 17,790 хүүхдийн хүчин чадалтай 46 сургуулийг шинээр ашиглалтад оруулснаас Улаанбаатар хотод 10,560 хүүхдийн хүчин чадалтай 20 сургууль, орон нутагт 7,230 хүүхдийн хүчин чадал бүхий 26 сургуулийг шинээр ашиглалтад оруулсан байна. 2019 оны жилийн эцэст барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 73 сургууль байна. | |
| | | | Орчин нөхцөлийг сайжруулах дотуур байрны тоо | 18 | 17.1 Улсын төсөв | 2019 онд 1320 ортой 12 дотуур байрыг орон нутагт шинээр ашиглалтад оруулж, 6 дотуур байранд засвар үйлчилгээ хийсэн байна. 2019 оны жилийн эцэст барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 26 дотуур байр байна. | |
| | | | Аюулгүй загвар орчин бүрдүүлэх сургуулийн тоо | 652 | | Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамнаас төрийн өмчийн 654 сургууль, 373 дотуур байранд эрсдэлийн үнэлгээг хийж, үнэлгээнд хамрагдсан нийт сургуулийн 19 хувьд гэрэлтүүлэг, 14 хувьд хашаа, хайс, 19 хувьд сургуулийн орчны цардсан зам, талбай, үүдний шат, 20 хувьд довжооны хэсэг, 26 хувьд биеийн тамирын талбай, 19 хувьд цахилгааны утас, шит, 19 хувьд дээвэр, 26 хувьд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авто зам тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч, 19 хувьд нь дотор цахилгааны мантаж, 19 хувьд сантехникийн шугам хоолой болон анги танхимын халаагуур, 14 хувьд цонх, 12 хувьд нь хаалга, 11 хувьд шат, 22 хувьд үүд, коридор, 18 хувьд ариун цэврийн байгууламж, 16 хувьд нь цайны газарт засвар үйлчилгээг хийж, нийт 654 сургуулийн орчин, аюулгүй загвар болгож, 305 дотуур байр стандартын дагуу камержуулалт хийсэн. | |
| | | | Шинээр сонгон, секц, дугуйлан хичээллэх төвийн тоо | 100 | 4.1 Улсын төсөв | Улсын хэмжээнд 2019 онд үйл ажиллагаа явуулж байгаа 532 дотуур байр, 820 ерөнхий боловсролын сургуульд давхардсан тоогоор нийт 4008 секц, дугуйлан хичээллэж байна. Үүнээс, 2019 онд 127 дотуур байранд хүүхдийн хөгжлийн төвийг шинээр нээж, шинээр ашиглалтад орсон 29 сургуульд 819 ширхэг спортын тоног төхөөрөмж, 498 ширхэг хөгжмийн тоног төхөөрөмж олгож сонгон, секц, дугуйлангууд хичээллэх боломжийг бүрдүүлсэн. | |
| 11.3 | МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.10 дахь заалт | Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн түрээсийн тогтолцоог нэвтрүүлэх | Сурах бичгийн "Түрээсийн сан" байгуулах ажлын явц, хувиар | 100 | 8.2 Улсын төсөв | Монгол Улсын Засгийн газрын "Сурах бичгийн талаар авах зарим арга хэмжээний Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам"-ыг БСШУС-ын сайдын 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн А/302 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж, ахлах ангийн нийт сурагчдын 60 хувийг хэрэгцээтэй бүх сурах бичгээр 12400-21000 төгрөгийн ашиглалтын төлбөр төлж, ашиглах боломжийг бүрдүүлэн, түрээсийн сан байгуулав. | 100 |
| 11.4 | МУТХҮБ-2030-ын 2.2.3, ЗГҮАХ-ийн 3.2.6 дахь заалт | Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байранд амьдарч байгаа бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгох | Дотуур байранд бага ангийн хүүхэдтэй ажиллах асрагч-багш, хүүхэд хөгжлийн багшийн тоо | 122 | | Дотуур байранд бага ангийн хүүхэдтэй ажиллах асрагч багш, хүүхэд хөгжлийн багшийг ажиллуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд дотуур байранд амьдарч байгаа 6,7,8 настай хүүхдэд асрагч багш үйлчлэх асуудлыг "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин, үйлчилгээ MNS 6781:2019 стандарт"-д тусгаж Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар баталж, 2019-2020 оны хичээлийн жилд 532 дотуур байр үйл ажиллагаа явуулж байгаагаас 381-д нь хүүхэд хөгжлийн төв үйл ажиллагаа явуулж, 85 бага ангийн асрагч багш ажиллаж байна. | 70 |
| 11.5 | МУТХҮБ-2030- | Дээд | Мэргэжил | 700 | 1.2 | Дээд боловсролын байгууллагын хүний нөөцийн чадавхыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.18 дахь заалт | боловсролын байгууллагын хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн магадлан итгэмжлүүлэх | дээшлүүлэх багшийн тоо | | Гадаад эх үүсвэр | нэмэгдүүлж, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор 2019 онд нийт 6046 багшийг сургалтад хамруулаад байна. Үүнд, 653 багшийг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн сургалт семинарт, 717 багшийг Шинжлэх ухаан, судалгааны арга зүйн сургалт семинарт, 710 багшийг хөтөлбөр хөгжүүлэх, жендерийн сургалт семинарт, 412 багшийг Үр дүнд суурилсан боловсролын арга зүйн сургалт, 47 багшийг гадаад сургалт семинарт, 3507 багшийг Зайн, онлайн болон Дээд боловсролын удирдлага мэдээллийн системийн сургалт семинарт хамруулав. | |
| | | | Магадлан итгэмжлэгдэх хөтөлбөрийн тоо | Дотоод-30, Гадаад-5 | | 2019 онд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын хуралдаанаар 36 сургалтын хөтөлбөрийг хэлэлцэн магадлан итгэмжлээд байна. Үүнд, боловсролын чиглэлийн 2, урлаг хүмүүнлэгийн чиглэлийн 6, байгалийн шинжлэх ухааны 1, бизнес, удирдлага, эрхзүйн 10, мэдээлэл харилцаа, холбооны технологийн 3, инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн 8, анагаах ухааны 3, үйлчилгээний 3 хөтөлбөрийг магадлан итгэмжлэв. Мөн Германы ASIIN байгууллагаар 7 хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлээд байна. Үүнд Монгол Улсын боловсролын их сургуулийн Багш байгалийн ухаан (физик, хими, газар зүй, биологи)-ны 4 хөтөлбөр, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн "Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөр"-ийн бакалавр 1, магистрын 2 хөтөлбөрийг магадлан итгэмжлэв. | |
| 11.6 | ЗГҮАХ-ийн 3.3.3 дахь заалт | Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн давхардлыг арилгаж, зарим хөтөлбөрийг нийслэлийн алслагдсан дүүрэг, хөдөө орон нутагт шилжүүлэх | Шилжүүлэх хөтөлбөрийн тоо | 10-аас доошгүй | | 2019 онд нийт 3 их сургуулийн 10 хөтөлбөрийг нийслэлийн алслагдсан дүүрэг, хөдөө орон нутагт шилжүүлэн 2485 оюутныг хамруулаад байна. Үүнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороонд ашиглалтад орсон шинэ цогцолборт 7 хөтөлбөр, Соёл, урлагийн их сургуулийн Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежид 2 хөтөлбөр, Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал, газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуульд 1 хөтөлбөрийг тус тус шилжүүлж, сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100 |
| 11.7 | ЗГҮАХ-ийн | Багш нарын | Үйл | 100 | | Боловсролын салбарт гүйцэтгэсэн ажлын ачаалал, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.3.11 дэх заалт | цалин, урамшууллыг нэмэх | ажиллагааны хэрэгжилт, хувиар | | 20.0 Улсын төсөв | хариуцлага, мэргэшлийн ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл зэрэг хүчин зүйлүүдийг харгалзсан ажлын байрны үнэлгээг үндэслэн Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн "Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 25 дугаар тогтоолоор "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"-ийг тус тус шинэчлэн тогтоов.<br><br>Тухайлбал, цэцэрлэгийн багшийн цалин 26.3 хувиар, ЕБС-ийн багш нарын цалин 20.0 хувиар, мэргэжлийн боловсрол олгох сургалтын багш нарын цалин 21.0-28.3 хувиар тус тус нэмэгдэв. | |
| Зорилт 12.Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын салбарт техник, технологийн ололтыг нэвтрүүлж, бүх нийтийн биеийн тамирын хөгжилд төрөөс дэмжлэг үзүүлнэ. | | | | | | | |
| 12.1 | ЗГҮАХ-ийн 3.2.47 дахь заалт | Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд инноваци, | Шинээр ашиглалтад оруулах сумдын соёлын төв, театрын тоо | 27 | 71.6 Улсын төсөв | Улсын хэмжээнд 2019 онд нийт 6070 суудалтай 23 соёлын төв шинээр ашиглалтад орсон байна. Мөн Гандантэгчилэн хийдийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулсан. 2019 оны эцсээр барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 48 соёлын төв байна. | 100 |
| | | | Шинээр ашиглалтад оруулах спорт цогцолбор, заалны тоо | 6 | | Улсын хэмжээнд 2019 нийт 11 спорт цогцолбор, талбай шинээр ашиглалтад орсон байна. 2019 оны эцсээр барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 20 спорт заал байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | техник, технологийн ололтыг нэвтрүүлэх | Шинээр нэвтрүүлэх техник, технологи | 3-аас доошгүй | | 2019 онд 3 техник, технологийг 7 соёл, урлагийн байгууллагад шинээр нэвтрүүлсэн байна. Үүнд, Монголын үндэсний музей, Дүрслэх урлагийн музей, Богд хааны ордон музей, Эрдэнэзуу музей, Хэнтий аймгийн музей, Баянхонгор аймгийн музейд VR технологийг нэвтрүүлж виртуал үзмэрийг баяжуулан олон нийтэд хүргэн, Үндэсний номын санд хадгалагдаж байгаа 14,000 номыг электрон каталогт бүртгэх, 10500 боть ном судар, гар бичмэлийг дижиталчлах, цахим орчинд ашиглах технологийг шинээр нэвтрүүлэв. Мөн Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр дэлхийн сонгодог уран бүтээл болох П.И.Чайковскийн "Хунт нуур" хүүхэлдэйн жүжгийг дэвшилтэт технологи болох холограм, 3D технологийг ашиглан бүтээж, үзэгчдийн хүртээл болгосон. | |
| | | | Шинээр байгуулах судалгааны төв, лаборатори | 10-аас доошгүй | | 2019 онд "Инженер, технологийн дээд боловсрол" төслөөр Шинжлэх ухаан, технологийн их сургуульд "Барилгын материалын судалгаа, шинжилгээ, туршилт хийх итгэмжлэгдсэн 1 лаборатори", Эрдэм шинжилгээ, инновацын төв байранд 12 судалгааны лаборатори, "Монгол-Хятадын Эрдэс баялгийн ашиглалт, туршилтын хамтарсан лаборатори байгуулах" ажлын хүрээнд Баяжуулалтын 1 лаборатори буюу нийт 14 лабораторийг ашиглалтад оруулж үйл ажиллагаа явуулж байна. | |
| 12.2 | ЗГҮАХ-ийн 3.2.56 дахь заалт | Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн спортоор хичээллэсэн иргэний үйлчилгээний төлбөрт эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | - | Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/178, А/144 тоот хамтарсан тушаалаар "Спортын клубийн магадлан итгэмжлэх журам, магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт, магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох журам"-ыг баталж, Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/178 тоот тушаалаар "Спортын клубийг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчийг сонгон шалгаруулах журам"-ыг, 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/603 дугаар тушаалаар Спортын клубийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг ханган ажиллах орон тооны бус зөвлөлийн ажиллах журмыг тус тус батлан, Биеийн тамир, спортын хараат бус шинжээчдийн дүгнэлтийг орон тооны бус зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлж буй 13 клубийг магадлан итгэмжилсэн. Эрүүл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан "Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал олгох журам"-ын дагуу дээрх 13 клубээр үйлчлүүлсэн даатгуулагчид олгох урамшууллыг гүйцэтгэлээр олгохыг Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/149 дугаар тушаалаар баталлаа. | |
| 12.3 | ЗГҮАХ-ийн 3.2.58 дахь заалт | Соёл, урлаг, шинжлэх ухааны салбарын ажиллагсдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлнэ. | Төрийн үйлчилгээний бусад албан хаагчдын жишигт хүргэх | 20-50 хувиар нэмэх | | Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ болон доод жишгийг Засгийн газрын 2019 оны 24, 472 дугаар тогтоолоор тус тус 8 хувиар нэмэгдүүлснээр 2020 оны 1 дүгээр сараас соёл, урлагийн ажилтны цалин 32-52 хувиар нэмэгдээд байна. | 100 |
| 12.4 | МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1 | 2020 онд Герман болон Европын бусад орнуудад Чингис хааны өмнөх болон дараах үеийн түүх археологийн үзэсгэлэн гаргах бэлтгэл ажиллагааг хангах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Монгол-Германы соёл, боловсролын зөвлөлдөх уулзалт 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан. Тус уулзалтаар хоёр улсын хамтарсан экспедицийн Орхоны хөндийгөөс олсон олдворуудаар 2020 онд Герман болон Европын бусад орнуудад Чингис хааны өмнөх болон дараах үеийн түүх, археологийн үзэсгэлэн гаргах бэлтгэл ажиллагааг хангах талаар хэлэлцэж, үзэсгэлэнг Монгол Улс, Холбооны бүгд найрамдах Герман Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд 2024 онд зохион байгуулахаар тогтож, протоколд тусгасан. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 131 тоот захирамжаар "Чингис хаан" музейн сан хөмрөгийг бүрдүүлэх, үзмэр, эд өлгийн зүйл цуглуулах, үзүүлэг дэглэлтийн ажлыг удирдан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан Герман болон Европын бусад орнуудад хадгалагдаж буй Чингис хаантай холбоотой мэдээллийг эх орондоо авчрах, эх хуулбар хэлбэрээр эзэмшигчийн зөвшөөрлийн дагуу сан хөмрөг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж "Эрмитаж"-д "Чингис хааны угсааныхны эрдэнэс" үзэсгэлэнг 2020 оны хавар зохион байгуулахаар тогтон бэлтгэл ажил хангагдаад байна. | 70 |
| Зорилт 13.Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухаан, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13.1 | ЗГҮАХ-ийн 3.2.35, ТШУТТББ-ын 4.4.1, 4.4.5 дахь заалт | Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх | Сургалтад хамрагдах, мэргэжил дээшлүүлэх судлаачийн тоо | 200 | 0.18 Улсын төсөв | "Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулан Засгийн газрын 2019 оны 162 дугаар тогтоолоор, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/826 дугаар тушаалаар тус тус батлуулан 2019 онд нийт 1220 эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдыг сургалтад хамруулаад байна. Үүнд, 600 судлаачдыг "Оюуны өмчийн эрх зүй, менежментийн үндсэн ойлголт, менежментийг сайжруулах" сэдэвт сургалтад, 90 судлаачдыг Харвардын их сургуулийн профессор Хирока Такэучигийн "Мэдлэгийн менежмент" лекцэд, 200 судлаачдыг "Эрдэм шинжилгээний өгүүлэл болон нийтлэлийн чанарыг сайжруулах" сэдэвт сургалтад, 235 судлаачдыг "Шинжлэх ухааны мэдлэгийг олон нийтэд сурталчлан таниулах арга зүй" сэдэвт сургалтад, 95 судлаачдыг "Монгол Улсад Шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог бэхжүүлэх, орчин үеийн судалгааны арга зүй эзэмшүүлэх, чадавхжуулах" сургалтад тус тус хамруулав. | 100 |
| 13.2 | МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.93 дахь заалт | Хөдөө орон нутгийн интернетийн үйлчилгээ хүрээгүй сумд, стратегийн болон аялал жуулчлалын бүс нутаг, хүн ам ихээр төвлөрдөг газарт утасгүй интернетийн үйлчилгээг хүргэх | Интернетийн үйлчилгээ хүргэх цэгийн, тоо | 20 | 0.3 Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан | Засгийн газрын 2009 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам"-ын 1.2 дахь хэсэгт "Мэдээлэл, харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого, бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх судалгааг үндэслэн тухайн жилд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, зардлын төсвийг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын санал болгосноор Ерөнхий сайд батална." гэж заасны дагуу 2019 оны төлөвлөгөөг 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд баталсан.<br>Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хүрээнд 18 аймгийн 87 суманд интернэтийн үйлчилгээг хүргэхээр шийдвэрлэж 2019 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны системээр нээлттэй тендер зарлан 2019 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулсан. Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх" төслийн хүрээнд 18 аймгийн 87 сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвд 2Mbps-20Mbps хүртэлх хурдаар интернэтийн үйлчилгээ хүргэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13.3 | ЗГҮАХ-ийн 5.1.18 дахь заалт | Харилцаа холбооны үндсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбох | Шилэн кабельд холбогдох сумын тоо | 2 | 1.5 Улсын төсөв | Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын "II.1.1.1"-д Алслагдсан Баянхонгор аймгийн Баянговь, Баянлиг сум, Говь-Алтай аймгийн Тонхил сум, Дундговь аймгийн Дэлгэрхангай, Өлзийт, Өвөрхангай аймгийн Богд сум, Увс аймгийн Тэс сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбохоор тусгагдсан. Энэ хүрээнд төслийн шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 7 багц тендерийг 2019 оны 4-6 сард зохион байгуулж, 5 аймгийн 7 сумыг шилэн кабелийн сүлжээнд холбож ашиглалтад оруулснаас Дундговь аймгийн Дэлгэрхангай, Өлзийт сумд 2019 оны 12 дугаар сарын 1-ний өдөр шилэн кабелийн сүлжээнд холбогдсон. | 100 |
| 13.4 | ЗГҮАХ-ийн 3.2.33 дахь заалт | Шинжлэх ухаан технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох | Үндэсний номын сангийн барилгыг дуусгаж, ашиглалтад оруулах ажлын явц, хувиар | 100 | 6.1 Улсын төсөв | 2019 оны жилийн эцсийн байдлаар Үндэсний номын сангийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Тус барилгын нийт төсөвт өртөг 18.9 тэрбум бөгөөд 2019 онд улсын төсвөөс 6.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлж, 2020 оны төсвийн тухай хуульд 7.6 тэрбум төгрөгийг тусгаад байна. | 70 |
| Зорилт 14.Төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангаж бүтээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 14.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 7, ЗГҮАХ-ийн 5.1.17 дахь заалт, "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын 3.9.3 дахь | Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | Цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний нэр төрөл | 60 | 4.5 Улсын төсөв | Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>- Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газраас 9, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 30 үйлчилгээг сонгож цахим хэлбэрт шилжүүлэх тооцоо судалгааг хийж, Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Ухаалаг засаг төслийн хүрээнд санхүүжүүлэх хүсэлтийг 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн бөгөөд хариу хүлээж байна.<br>- Төрийн цахим мэдээлэл солилцох Хур системд 2019 оны байдлаар Улсын бүртгэлийн газрын төрсний бүртгэл, гэрлэлтийн бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгийн зэрэг 22 лавлагаа, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | заалт | | | | | Авто тээврийн үндэсний төв (ТӨҮГ)-ийн Авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа, Оношилгоо, техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл, Гаалийн ерөнхий газрын Гаалийн байгууллагад өртэй эсэх лавлагаа, Татварын ерөнхий газрын Авто тээврийн хэрэгслийн татвар, Авто тээврийн агаарын бохирдлын төлбөр, Авто тээврийн зам ашигласны төлбөр, тендерийн тодорхойлолт, Хөрөнгийн татвар төлөх үйлчилгээ зэрэг 10 лавлагаа, Цагдаагийн ерөнхий газрын Жолооны үнэмлэхийн лавлагаа, Галт зэвсэг эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа зэрэг 6 лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Өр төлбөргүй эсэх лавлагаа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа зэрэг 4 лавлагаа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Эрүүл мэндийн даатгалын нэгдсэн лавлагаа, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн тодорхойлолт, Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох тодорхойлолт зэрэг 5 лавлагаа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бүрэн дунд боловсролын гэрчилгээний лавлагаа, Суурь боловсролын гэрчилгээний лавлагаа, Дээд боловсролын гэрчилгээний лавлагаа зэрэг нийт 10 байгууллагын 55 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээс 32 үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж ашиглахад бэлэн болсон бол 23 үйлчилгээнд туршилт тохируулга хийгдэж байна. Ингэснээр Төрийн мэдээлэл солилцооны системд 120 сервис нэмж оруулан нийт 195 төрлийн серверийг төрийн 37, хувийн хэвшлийн 67, нийт 104 байгууллага холбогдон ажиллаж байгаа бөгөөд 58.8 сая үйлчилгээг дамжуулан хүргэжээ. | |
| 14.2 | ЗГҮАХ-ийн 5.2.8, 5.1.17 дахь заалт | Цахим албан хэрэг хөтлөлтийн болон цахим шуудангийн системийн үйл ажиллагааг эхлүүлэх, тоон гарын үсгийн хэрэглээг | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 2 дугаар тушаалаар "Дижитал шилжилтийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.<br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газарт 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэвтрүүлж Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн удирдлагын систем хөгжүүлэлтийн ажлыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжих | | | | гүйцэтгэсэн.<br>Мөн Нийгмийн даатгалын цахим тайлангийн систем, нэгдсэн танилт нэвтрэлтийн ДАН систем, татварын цахим тайлангийн систем, төрийн цахим үйлчилгээний портал системд тоон гарын үсгийг ашиглах боломжийг бүрдүүлж, тоон гарын үсгийн үндэсний дундын мэдээллийн санг 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэ онд тоон гарын үсэг ашигладаг 57 байгууллагын 940 албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээг шинээр олгосноор тоон гарын үсэг ашигладаг албан хаагчдын тоо 2,077-д хүрээд байна.<br>Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээнд тоон гарын үсэг ашиглах боломжийг бүрдүүлж буй Дан системд 2019 онд төрийн болон хувийн хэвшлийн 20 байгууллагын 20 систем холбогдож, 37,928 хэрэглэгч бүртгүүлээд байна. | |
| 14.3 | ЗГҮАХ-ийн 5.2.8 дахь заалт | Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, шинээр байгуулагдсан хуулийн этгээд, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх үйлчилгээг онлайн горимд шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Онлайн горимд шилжих үйлчилгээ, хувиар | 50.0 | 0.13 Улсын төсөв | Хуулийн этгээдийн оноосон нэр олголтыг онлайнаар захиалж, баталгаажуулах системийг 2018 оны 04 дүгээр сараас нэвтрүүлж, 2019 онд нийт 25181 иргэн, хуулийн этгээд нэр баталгаажуулах хүсэлтээ цахимаар ирүүлснийг шалгаж, 6313 хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулах боломжтой талаарх хариуг тухай бүр хүргүүлж ажиллалаа.<br>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 4 төрлийн үйлчилгээг цахимаар хүргэх боломжтойгоос 3 үйлчилгээ буюу 75.0 хувийг цахим хэлбэрт шилжүүлээд байна. | 100 |
| 14.4 | ЗГҮАХ-ийн 5.2.9 дэхь заалт | Иргэний болон хуулийн этгээдийн архивын цаасан баримтыг цахимжуулах ажлыг | Цахимжуулах ажлын явц, хувиар | 100 | 0.138 Улсын төсөв | Хуулийн этгээдийн бүртгэлийн архив дахь 139703 хуулийн этгээдийн 6581023 хуудас, иргэний баримтын архив дахь 2215571 хувийн хэргийн 13873492 хуудас баримтыг цахим санд тус тус оруулан цахимжуулах ажлыг дуусгав.<br>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахимд 3 үйлчилгээг оруулаа.Үүнд:<br>1. Хуулийн этгээдийн оноосон нэр баталгаажуулах,<br>2. Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дуусгаж, бүртгэлийн дотоод хэрэглээ болон онлайн орчинд ашиглах боломжийг бүрдүүлэх | | | | 3. Хуулийн этгээдийн бүртгэлтэй тухай лавлагаа. Хуулийн этгээдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахимд оруулахаар бэлтгэж байна. | |
| | | | Онлайн орчинд ашиглах боломжийг нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 20.0 | 0.166 Улсын төсөв | Онлайн лавлагаа, үйлчилгээний системийг 2018 оны 11 сараас нэвтрүүлж, 26 төрлийн лавлагаа, 2 бүртгэлийн үйлчилгээ, нийт 28 төрлийн үйлчилгээг онлайнаар хүргэж байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 259 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан 21 төрлийн лавлагаа, 30 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх боломжтойгоос 23 лавлагаа, 1 үйлчилгээ буюу 66 хувийг цахим хэлбэрт шилжүүлсэн. | |
| 14.5 | МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.80. 2.81 дэх заалт | Газрын төлөвлөлт, бүртгэл, бирж, үнэлгээ, мониторингийн нэгдсэн тогтолцоог бий болгох | Газрын нэгдсэн цахим систем бий болгох ажлын явц, хувиар | 80.0 | 6.0 Улсын төсөв | Энэ ажлын хүрээнд "Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах", "Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх", "Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох", "Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар хангаж, эдийн засгийг эрчимжүүлэх" ажлуудыг зохион байгуулж ажлын даалгаврыг батлуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг гүйцэтгүүлсэн. Эцсийн шатны тайланг акт үйлдэн, 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авсан.<br>2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан газрын төлбөр, татварын асуудлаар Татварын ерөнхий газар болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар хооронд дундын мэдээллийн сан байгуулан мэдээллээ харилцан солилцох боломжийг бүрдүүлээд байна. Ингэснээр байрлалд суурилсан төлбөр, татварын тогтолцоог байгуулж, нэг талаас иргэд, олон нийтэд хүрч буй үйлчилгээ шуурхай явагдах, нөгөө талаас улсын төсвийн орлогын биелэлтийг хангахад чухал ач холбогдолтой ажил боллоо. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Барилга хот байгуулалтын яам болон Газар дэлхий ХХК-ийн байгуулсан "Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах" гэрээт ажлын хүрээнд Газар дэлхий ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын эхний үе шатны тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар шалгаж, хүлээн авсан акт, дүгнэлтийг 2019 оны 04 сарын 18-ны өдрийн Н/15 тоот албан бичгээр ирүүлсэн. Гүйцэтгэгчээс ирүүлсэн дунд шатны тайланг мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас шалгаж, хүлээн авсан акт, дүгнэлтийг 2019 оны 07 сарын 04-ний өдөр ирүүлээд байна. Гэрээт ажлын эцсийн үе шатны тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар шалгаж, дүгнэлт гарган албан бичгээр тус яаманд ирүүлсэн. Гэрээт ажлын хүрээнд сервер 2 ширхэг, хадгалах төхөөрөмж 2 ширхэг, суурин компьютер 41 ширхгийг хүлээн авсан.<br>2019 онд хийгдсэн газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим мэдээллийн сан, газрын үнэлгээний систем, газрын бирж, кадастрын нэгдсэн мэдээллийн сан, газрын мониторингийн сүлжээг нэгтгэн газрын удирдлагын системийг ирэх онд 21 аймагт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| | | | Шинээр байгуулах мониторингийн сүлжээний цэгийн тоо | 5000-аас багагүй | | "Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндсэний мониторингийн сүлжээг байгуулах" гэрээт ажлыг гүйцэтгэсэн.<br>Дунд шатны тайланг 2019 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр холбогдох байгууллагад хүргүүлсэн.<br>21 аймаг, нийслэлийн 2000-2004, 2008-2010, 2016 оны бэлчээрийн, 2005, 2011-2012, 2016, 2017-2018 оны тариалангийн, 2004, 2012-2016, 2016, 2018 оны хот, суурин газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тоон мэдээллийг нэгтгэж мэдээллийн сан үүсгэх ажлыг хийсэн. Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндсэний мониторингийн сүлжээг байгуулах гэрээт ажлыг гүйцэтгүүлж, 400 орчим захиалгат хянан баталгааны ажлын тоон мэдээллийг авч нэгтгэн 5000 орчим мониторингийн сүлжээний цэг байгуулсан. Ажлын эцсийн шатны тайланг хүлээн авч 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14.6 | МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ТЭМТББ-ын 2.4.4, 2.4.6, ЗГҮАХ-ийн 3.1.9, 3.1.16, 3.1.17 дахь заалт | Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд цахим систем нэвтрүүлэх | Цахим систем нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 100 | - | 2019 оны эхний 06 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд нийт 5 цахим систем нэвтрүүлэн ажиллаж байна. Үүнд: "Элэг бүтэн Монгол", "Цахим жор", "Урьдчилан сэргийлэх үзлэг", "Дархлаажуулалт", "Эрүүл хүүхэд-Эрүүл шүд" хөтөлбөр болно. Цахим системүүдийг үндэсний ХУР системтэй холбож, иргэний ерөнхий мэдээллийг хурууны хээгээр баталгаажуулж, түргэн, шуурхай, цаг алдалгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байна.<br>Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, иргэдэд эрүүл мэндийн даатгалд даатгуулсан цаг мөчөөс эхлэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг үүсгэн эдлүүлэх зорилгоор "Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн түр тодорхойлолт", "Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн түр тодорхойлолт олгох, ашиглах, хяналт тавих журам"-ыг ЭМДЕГ-ын даргын 2019 оны А/47 дугаар тушаалаар батлан, журмыг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.<br>Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд цахим системээр үйлчлүүлсэн иргэдийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 2,298.9 мянган хүн байна. Мөн Эрүүл мэндийн даатгалын байгууллага, гэрээт эрүүл мэндийн байгууллага, ЭМЯ-тай гурвалсан гэрээ байгуулж, хурууны хээний программ нэвтрүүлэн хэвтэн эмчлүүлэгч иргэдийн хурууны хээг хэвтэх болон эмнэлгээс гарахад нь уншуулж эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулах санхүүжилтийн хяналтыг сайжруулав. Түүнчлэн цахим системийн HICS программыг 2019 оны 08 дугаар сараас төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хурууны хээ баталгаажуулах системийг 2019 оны 10 дугаар сараас хувийн хэвшлийн 173 эмнэлэг, 43 рашаан, сувилалд тус тус нэвтрүүлсэн. | 100 |
| 14.7 | ГБҮБ-ын 6.27.5 дахь дэд заалт, ЗГҮАХ-ийн 5.3.12, 5.6.6, 5.6.9 дэх заалт | | Шинээр цахимжуулах үйлчилгээний нэр төрөл | 14 | - | Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд 2019 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br><u>Мэдээлэл, лавлагааны чиглэлээр:</u><br>- Дипломат төлөөлөгчийн газрууд гадаадад оршин суугаа иргэдийн иргэний бүртгэлийн бүх төрлийн буюу төрсний, иргэний үнэмлэхийн, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан эсэх, гадаад паспортын, гэрлэсний, гэрлэлт цуцалсны, төрөл садангийн, нас барсны, Монгол Улсын | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх | | | харьяатаас гарсны, Монгол Улсын харьяатаа сэргээсний, Үрчлэлтийн, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн, (зөвхөн итгэмжлэлд үндэслэн), Хуулийн этгээдийн бүртгэлийн зэрэг лавлагаа болон Гадаад харилцааны яамны Консулын газраас хилийн чанад дахь ДТГ-уудад гэрчлүүлэн илгээсэн итгэмжлэл, баталгаажуулалтын жагсаалтыг олон нийтэд хүртээмжтэй, цахимаар үзэх боломжийг бүрдүүлж, www.consul.mn цахим хуудаст "ИТГЭМЖЛЭЛ ИРСЭН ЭСЭХИЙГ ШАЛГАХ" цонх шинээр нээн хөтөлж эхэлсэнээр нийт 14 үйлчилгээг цахимжуулсан.<br>- Гадаадад оршин суугаа иргэдийн гэмт хэрэгт холбогдсон эсэх лавлагааг Цагдаагийн ерөнхий газраас, хилээр нэвтэрсэн тухай лавлагааг Хил хамгаалах ерөнхий газраас, жолооны үнэмлэхийн лавлагааг Бүртгэл, мэдээллийн төвөөс Гадаад харилцааны яамны Консулын газраар дамжуулан цахим шуудангаар ажлын 3 өдөрт, яаралтай тохиолдолд ажлын 6 цагт багтаан авч хэвшсэн.<br>- Төрийн мэдээллийн "ХУР" системээс иргэний бүртгэлийн үндсэн мэдээллийг авдаг болсон бөгөөд уг системээс авч болох мэдээлэл, лавлагааны нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллаж өрхийн бүртгэлийн санг суурилуулсан. Ингэснээр хилийн чанадад эрх ашиг нь хохирсон, гэмтсэн, нас барсан иргэдийн ар гэрт мэдээллийг шуурхай хүргэх боломж бүрдсэн.<br>- БНСУ-ын виз мэдүүлэх монгол иргэдийн бүрдүүлэх бичиг баримтын тоог цөөлөх, чирэгдлийг багасгахад анхаарч, Үндэсний Дата төв УТҮГ, Монгол Улс дахь БНСУ-ын ЭСЯ-тай хамтран Виз мэдүүлгийн төвүүдэд "ХУР" систем байршуулах асуудлыг шийдвэрлэж, 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр тохиролцсон. Энэ хүрээнд ГХЯ-ны Консулын газар, Үндэсний Дата төвийн удирдлага, Монгол Улс дахь БНСУ-ын ЭСЯ болон тус улсын Визийн 10 төвийн удирдлагыг 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.<br>- ДТГ-уудад баталгаажуулсан итгэмжлэлийн жагсаалтыг өдөр тутамд consul.mn цахим хуудсанд нийтэлж, иргэдэд учирч байгаа чирэгдлийг бууруулж байна.<br>- ГХЯ-ны Консулын газар болон ДТГ-уудад үзүүлж буй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1/ДТГ-ууд руу баримт бичиг илгээх хүсэлт, 2/Апостиль гэрчилгээ авах хүсэлт, 3/Консулын баталгаажуулалт хийлгэх хүсэлт, 4/Визийн зөвшөөрөл хүсэх (D, A, B, O ангилал) зэрэг үйлчилгээг цахимжуулах талаар Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран ажиллаж, mgov.mn төрийн цахим үйлчилгээний порталаар дамжуулан хүргэхээр бэлтгэлийг хангаж байна.<br>Гадаад паспортын захиалгын чиглэлээр:<br>- Гадаадад оршин суугаа иргэдийн гадаад паспорт захиалгын материал, иргэний бүртгэлийн мэдээллийг ДТГ-уудаас УБЕГ-т виртуал сүлжээгээр шуурхай хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br>- Дипломат шуудан тогтмол явдаггүй ДТГ-уудад гадаад паспортыг буухиа шуудан (DHL)-аар шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэв. Паспорт захиалгын хүлээх хугацааг багасгах чиглэлээр ГХЯ, УБЕГ, "Титан интернэйшнл" ХХК сар тутамд тооцоо нийлж, төлбөрийг шуурхай шилжүүлэх, паспорт хэвлэлтийг түргэвчлэх горимд шилжлээ.<br>Цахим виз олгох чиглэлээр:<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын цахим виз олгох системийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэргэд байгуулах шаардлагатай болсон бөгөөд 2019 онд багтаан туршилтын журмаар цахим виз олгох боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.<br>- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ахалсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэгтэй ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд уг хуулийн төсөлд цахим визийн асуудлыг тусгуулсан. | |
| Зорилт 15.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15.1 | МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 2, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /цаашид ТЭМТББ гэх/-ын 2.4.2.2, ЗГҮАХ-ийн 3.1.8.дахь заалт | Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | Хүүхдийн мэс засал, мэдрэлийн болон нярайн нэгжийг амбулатори болон хэвтэн эмчлүүлэх хэсэгт шинээр байгуулсан нэгдсэн эмнэлэг, хувиар | 35.0 | 0.567 Улсын төсөв<br><br>0.473 Гадаад эх үүсвэр | Улсын хэмжээнд нийт 25 нэгдсэн эмнэлэг байгаагаас Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Орхон, Өмнөговь, Хэнтий, Дорнод, Ховд зэрэг 9 аймагт хүүхдийн мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлж, Дорноговь аймаг, нийслэлийн Багануур дүүрэг хүүхдийн мэс заслын эмчтэй болоод байна. Мөн Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өмнөговь, Хөвсгөл, Өвөрхангай, Ховд, Сэлэнгэ зэрэг 11 аймгийн нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар хотын Багануур, Налайх, Баянгол зэрэг 3 дүүргийн Эрүүл мэндийн төв, Амгалан амаржих газарт нярайн тасаг болон нэгжийг шинээр байгуулсан. Хэнтий, Увс, Дархан-Уул, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дорноговь зэрэг 7 аймаг, нийслэлийн Баянгол дүүрэгт тус бүр 1 нярайн эмчтэй болоод байна. | 100 |
| | | | 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин, промиль | 25-аас ихгүй | | Улсын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар эхийн эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 23.0 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3 тохиолдлоор буурсан байна.<br>Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/518 дугаар тушаалаар "Кесар мэс заслаар төрүүлэх эмнэлзүйн заавар", А/614 дугаар тушаалаар Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Эхээс хүүхдэд ХДХВ, гепатитийн В вирус болон тэмбүүгийн халдвар дамжихыг зогсоох журам" А/385 тушаалаар "Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр лавлагаа төвөөс эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө өгөх журам", А/386 тушаалаар "Эмнэлзүйн сургалтын танхим ажиллуулах журам", "Эмнэлзүйн сургалтын менежерийн албан тушаалын тодорхойлолтын загвар"-ыг тус тус батлуулан хэрэгжүүлж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан эмэгтэйчүүдийн үзлэгийн 4 орыг нийслэлийн 3 амаржих газар, ЭХЭМҮТ-д суурилуулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар сайжирч, эрх тэгш тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүллээ. Түүнчлэн, эхийн ноцтой хүндрэл болон эхийн эндэгдэлд нөлөөлж буй гол хавсарсан эмгэгүүдийн талаар "Жирэмсэн ба эрхтэн тогтолцооны эмгэгүүд", "Жирэмслэлт ба зүрх судасны өвчин", "Жирэмслэлт ба хоол боловсруулах замын өвчин", "Жирэмслэлт ба шээс бөөрний замын өвчин", "Жирэмслэлт ба амьсгалын замын өвчлөл, сүрьеэ өвчин", "Жирэмслэлт ба мэдрэлийн эмгэг, артерийн даралт ихдэлт, цус харвалт" зэрэг 5 өвчний оношилгоо, эмчилгээ сэдвээр цахим сургалтыг 21 аймаг, нийслэл АШУҮИС-ийн ЭБЭСТ, хүүхэд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судлалын тэнхим, дотрын өвчин судлалын тэнхим, Хордлогын төв, ЭМХТ зэрэг байгууллагуудтай 2019 оны 4-11 сар хүртэлх хугацаанд 5 удаа зохион байгуулж нийт 987 эмч, мэргэжилтнийг хамруулсан. | |
| | | | 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, промиль | 13.2-оос ихгүй | | Улсын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар нялхсын эндэгдлийн 1,040 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 13.3 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 тохиолдлоор нэмэгдсэн хэдий ч 1000 амьд төрөлтөд харьцуулахад 0.1-оор буурсан үзүүлэлттэй байна.<br>"Хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр гарсан тушаал, шийдвэрүүдийг танилцуулах сургалтыг 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвийн 100 эмч, сувилагч нарыг хамруулав.<br>Шинээр мэндэлсэн нярайд удамшлын болон төрөлхийн эмгэгийг эрт илрүүлэх скрининг шинжилгээг хийж, нярайн түнхний үений скрининг шинжилгээг ЭХЭМҮТ, нийслэлийн 3 амаржих газар, Налайх, Багануур дүүргийн нэгдсэн эмнэлэг, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд, Замын-Үүд, Мандалын 2 сум дундын эмнэлэгт хэрэгжүүлж байна. Мөн 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр "Нярайн скринингийн үндэсний анхдугаар конгресс"-ийг ЭМЯ, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран амжилттай зохион байгуулж дотоод, гадаадын эмч, мэргэжилтэн, эцэг, эхийн ба олон улсын байгууллагын төлөөлөл, хамтын ажиллагаатай улс орны зочид зэрэг нийт 400 гаруй төлөөлөгчид оролцон цаашид хөгжүүлэх талаар санал солилцон зөвлөмж гаргасан. Нярайн сурфактант эмчилгээг 21 аймагт нийт 59 нярайд хийж, 32 тохиолдол үр дүнтэй болсон байна. Мөн нярайн эндэгдэл өндөртэй Улаанбаатар хот, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Баян-Өлгий, Төв, Архангай аймгуудад сурфактант эмчилгээ хийх арга зүй, дадлагажуулах сургалтыг зохион байгуулсан. Мөн 2019 онд 29 эрүүл мэндийн байгууллагуудад 65 удаа цахим холболт хийж, 124 эмч, мэргэжилтэн телемедицинээр мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн байна. | |
| | | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, | 16.0-гаас ихгүй | | Улсын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1,262 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 16.1 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлтөд 0.8-оор буурсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | промиль | | | Зайлшгүй хэрэгцээт эмийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар агаарын бохирдол бүхий нөхцөлд шаардлагагүй эмнэлэгт хэвтэлтийг бууруулах зорилгоор олон нийтэд түшиглэсэн Хүүхдийн өвчний цогц менежментийг нийслэлийн Баянзүрх дүүрэгт туршин хэрэгжүүлж, үр нөлөөний үнэлгээ хийв. Эрүүл мэндийн дэд сайдаар батлуулсан удирдамжийн дагуу ажлын хэсэг 5 хүртэлх насны хүүхдийн болон нялхас, нярайн эндэгдэл, гэрийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх журмын төслийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 20, 28-ны өдрүүдэд өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгийн үеэр гарсан санал, зөвлөмжийг тусгасан.<br>Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед нийслэлийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн хүүхдийн тасгуудад нэмэлтээр дэлгэх 850 нөөц орыг (насанд хүрэгсдийн 496, нэмэлт зөөврийн ор 354) бэлтгэсэн. Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэгт хүүхдийн 100 ортой эмнэлэг, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг 60 ортой хүүхдийн тасгийг шинээр байгуулсан. Нийслэлийн өрх болон хүүхдийн эмнэлгүүдэд резидент эмч 22, АШУҮИС-ийн төгсөх ангийн 394 оюутанг нэмэлтээр ажиллуулж байна. Чингэлтэй дүүргийн 1-10 дугаар хорооны хүүхдийн тусламж, үйлчилгээг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт, Баянзүрх дүүргийн 8, 9, 13, 16, 17 дугаар хорооны насанд хүрэгсдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг Цэргийн төв эмнэлэгт тус тус шилжүүлж зохицуулалт хийсэн. Сонгинохайрхан дүүргийн 10 хорооны (1, 3, 5, 7, 8, 19, 22, 23, 24, 27 дугаар хороо) насанд хүрэгсдийн дотор ба мэдрэлийн өвчний үеийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг "Ачтан" эмнэлэгт шилжүүлж, тус дүүргийн эрүүл мэндийн төв дээр 70 ортой хүүхдийн тасаг нээн ажиллав. Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт үзүүлж байсан насанд хүрэгсдийн тусламж, үйлчилгээг тус дүүргийн эрүүл мэндийн төвд шилжүүлж, 180 орыг дангаараа хүүхдийн тусламж, үйлчилгээнд шилжүүлсэн. Томуугийн эсрэг дархлаажуулалтад 2019 онд Улаанбаатар хотод эрсдэлт бүлгийн хүн ам болох 2-5 хүртэлх насны 152,982 хүүхэд буюу 47.7 хувийг нь дархлаажуулсан. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Хүүхдийн их эмч бэлтгэх сургалтын хөтөлбөр нээх бэлтгэл ажлыг хангах" А/531/А392 дугаар тушаал гарч, 2019-2020 оны хичээлийн жилээс | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | АШУҮИС-д хүүхдийн эмч бэлтгэдэг болсон. | |
| 15.2 | МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ТЭМТББ-ын 2.4.1-2.4.2 дахь заалт ЗГҮАХ-ийн 3.1.3, 3.1.4, 3.1.10 дахь заалт | Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эмчилгээ, оношилгооны чанарыг сайжруулах | Эрүүл мэндийн чиглэлээр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хийгдсэн сургалт, сурталчилгааны тоо | 72 | 0.04 Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>3.925 Эрүүл мэндийн даатгалын сан | Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2019 онд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийт 71 сургалт, сурталчилгаа хийлээ. Үүнд, эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн багц, хамрагдалт, түүний ач холбогдлын талаар 12 төрлийн инфографик 1 шторк түгээж, 596,867 хүнд хүрч ажиллав. Мөн халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг Цагаан сарын өдрүүдийг тохиолдуулан гаргаж 14,398 хүнд хүргэн ажилласан.<br>Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, 21 видео шторк ЭМЯ-наас хийж, нийт 4 ТВ-ээр цацагдсан. Идэвхтэй хөдөлгөөний чиглэлээр 5 төрлийн инфографик 2 шторк түгээн 436,852 хүнд хүрч, архи, тамхины хор хөнөөлөөс сэргийлэх чиглэлээр 14 төрлийн инфографик 2 шторк түгээн 425 хүнд хүрсэн байна. Скайтел үүрэн холбоогоор элэг, ходоод, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн мессеж илгээж, 20,000 гаруй мянган хүнд хүргэв. Мөн хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх чиглэлээр дасгал хөдөлгөөнийг дадал болгоё, эрүүл амьдрал таны гарт, дасгал хөдөлгөөний ногоон жор зэрэг сэдвүүдээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 12 удаагийн ярилцлага, нэвтрүүлэг, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав. | 70 |
| | | | Эрт илрүүлэх үзлэгийг нэмэгдүүлэх, хувиар | 10.0 | | Улсын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 153,335 хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсанаас Улаанбаатар хотод 49,667 хүн, хөдөө орон нутагт 103,668 хүн байна. Мөн артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 613,467 хүн хамрагдсан нь зорилтот бүлгийн 77.4 хувийг хамруулсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 579,562 хүн хамрагдсан нь зорилтот бүлгийн 73.1 хувийг, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн шинжилгээнд 88,016 эмэгтэй буюу зорилтот бүлгийн 38.6 хувийг хамруулсан байна. Хөхний хорт хавдрын боломжит эрт илрүүлэг үзлэгт 411,989 эмэгтэй хамрагдсан бол элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 228,638 хүн хамрагдсанаар зорилтот бүлгийн 28.4 хувийг хамруулсан байна. | |
| | | | Харвалт, шигдээсийн нэгж | 2 | | 2019 оны 07 дугаар сарын 3-ны өдөр Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийг нээж Харвалт, шигдээсийн нэгжийн олон улсын стандартын дагуу байгуулж, үйлчлүүлэгчдэд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулах эмнэлгийн тоо | | | тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Мөн бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдэд харвалт, шигдээсийн багийн менежментийн цогц сургалтын хөтөлбөрийг боловсруулан Орхон, Дорнод аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төв, Цэргийн төв эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулж, нэгжийн зохион байгуулалтад орсон. | |
| 15.3 | МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 4, ТЭМТББ-ын 2.4.1, 2.4.5 дахь заалт ЗГҮАХ-ийн 3.1.12 дахь заалт | Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт, сэргийлэлтийг сайжруулж, өвчний тохиолдлыг бууруулах | Пневмококкийн эсрэг дархлаажуулалтыг нэвтрүүлэх эрүүл мэндийн байгууллагын тоо | 9 дүүрэг, 21 аймаг | 0.98 Улсын төсөв<br><br>15.078 Эрүүл мэндийн даатгалын сан | Эрүүл мэндийн сайдын 2019 оны 119 дүгээр тушаалаар Пневмококкийн шалтгаант уушгины хатгалгаа өвчнөөс сэргийлэх пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт бүрэн нэвтрүүлсэн. Тус вакциныг аймаг, нийслэлийн ӨЭМТ-ийн дархлаажуулалтын нэгжээр хүн амд хүргэж, 2019 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 140,244 хүүхдийг пневмококкийн эсрэг вакцинд хамруулж, хамралт 95.1 хувьтай байна. | 70 |
| | | | Вируст хепатит В, С вирусийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээнд хамрагдах 15-65 насны хүн ам, хувиар | 90.0 | | 2019 оны жилийн эцсийн байдлаар Вируст гепатит В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд 1,000,647 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 67.4 хувь байна. В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд 98,747 хүн, С вирусийн эмчилгээнд 21,150 хүн, В вирусийн эмчилгээнд 14,615 хүн тус тус хамрагдсан байна. | |
| 15.4 | МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1 ТЭМТББ-ын 2.4.4, 2.4.6 дахь заалт ЗГҮАХ-ийн 3.1.9, 3.1.16, 3.1.17 дахь заалт | Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх | ЭМДС-гаас санхүүжих хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хувь | 70 хүртэл | 37.325 Эрүүл мэндийн даатгалын сан | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 2019 онд төв, орон нутгийн 2,122 эрүүл мэндийн байгууллагатай "Эрүүл мэндийн даатгалын гэрээ" байгуулан ажиллаж байна. Үүнээс хувийн хэвшлийн эрүүл мэндийн 1,462 байгууллага байгаа нь нийт хувийн хэвшлийг эрүүл мэндийн байгууллагын 98 хувийг эзэлж байна.<br>Төрийн өмчийн 98, хувийн хэвшлийн 181 эмнэлэг, сувилал 56, эмийн сан 1,026, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв 411, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж байгаа төрийн болон хувийн хэвшлийн 154 эмнэлэг, гепатит В, С вирусийн идэвхжил тодорхойлох лаборатори 28, гемодиализийн тусламж, үйлчилгээ үзүүлэх 11 эмнэлэг, "Эрүүл шүд-Эрүүл-хүүхэд" үндэсний хөтөлбөрийн хүрээнд 6-12 насны хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх 153 эмнэлэг хамрагдаж иргэд-даатгуулагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусламж, үйлчилгээний зардлаа авч байна. | |
| 15.5 | ТЭМТББ-ын 2.4.5, ЗГҮАХ-ийн 3.1.22 дахь заалт | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж үйлчилгээнээс үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх | Шинээр ашиглалтад орох сумын эрүүл мэндийн төвийн тоо | 8 | 36.475 Улсын төсөв<br><br>24.277 Гадаад эх үүсвэр | 2019 онд, Говь-Алтай аймгийн Дарви сум, Цогт сум, Цээл сум, Сүхбаатар аймгийн Дарьганга сум, Наран сум, Ховд аймгийн Чандмань сум, Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сум, Дундговь аймгийн Эрдэнэдалай сум, Дэлгэрхангай сум, Өвөрхангай аймгийн Баянгол сум, Баянхонгор аймгийн Баянцагаан сум, Төв аймгийн Заамар сум, нийт 12 эрүүл мэндийн төв бүрэн ашиглалтад орж, Архангай аймгийн Цахир сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил 90 хувь, Завхан аймгийн Сонгино сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. | 70 |
| | | | Шинээр ашиглалтад орох Хоёрдугаар шатлалын эмнэлгийн тоо | 5 нэгдсэн эмнэлэг, 2 өргөтгөл | | 2019 онд Булган аймгийн Булган сумын, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Халдварт, Сүрьеэгийн эмнэлгийн барилга, Ховд аймгийн Булган сумын 50 ортой нэгдсэн эмнэлгийн барилга, Дархан-Уул аймгийн Дархан сумын Геронтологийн төвийн барилга, Дархан-Уул аймгийн Дархан сумын Төрөх эмнэлгийн барилгын өргөтгөлийн барилга ашиглалтад орсон байна. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд баригдаж буй Сэргээн засах төвийн барилгын ажил 26 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| | | | Шинээр ашиглалтад орох Гуравдугаар шатлалын эмнэлгийн тоо | 4 | | 2019 онд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Говийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Үндэсний оношилгоо, эмчилгээний төв ашиглалтад орсон бол Геронтологийн төвийн барилга 45 хувийн, 300 ортой төрөх эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэл 85 хувьтай байна. | |
| | | | Чанарын хяналтын баталгаажуул алтад хамрагдах тоног төхөөрөмж, хувиар | 100 | | 2019 онд нийт 4,741 тоног төхөөрөмжийг шалгалт тохируулгад хамруулахаар төлөвлөсөн бөгөөд 2019 жилийн эцсийн байдлаар 227 байгууллагын 3,858 эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт, тохируулга хийж, 81.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд, ЭМЯ-ны харьяа 2 байгууллагын 218, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа 21 байгууллагын 1,415, Аймгийн Эрүүл мэндийн газрын харьяа 116 байгууллагын 1,936, Өрхийн эрүүл мэндийн төвийн 88 байгууллагын 289 эмнэлгийн тоног төхөөрөмжийг шалгалт, тохируулгад хамрууллаа. | |
| | | | Нэг удаагийн хэрэгслийн нийт хангамж, хувиар | 50.0 | | Нэг удаагийн эмнэлгийн хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд 2019 онд 2 нэрийн эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг эхлүүлээд нийт 2.6 тэрбум төгрөгийн 12.6 сая хос үзлэгийн бээлий, 2.8 сая ширхэг дуслын системийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдан авалтын гэрээ байгуулж, шаардлагатай нэг удаагийн хэрэгслээр 100 хувь хангав. | |
| | | | Эрүүл мэндийн байгууллагууд ын тоног төхөөрөмжийн хангалт, их засварын ажил | - | | Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан 17 төсөл арга, хэмжээний 5.5 тэрбум төгрөгийн их засварыг нийт 47 эрүүл мэндийн байгууллагуудын барилга, сантехникийн засварыг хийж гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн хангалтад төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад тусгагдсан 15 төсөл, арга хэмжээний 10.2 тэрбум төгрөгийн тендер зарлагдаж 9.8 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдан нийт 50 гаруй нэр төрлийн 460 гаруй эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашинаар эрүүл мэндийн байгууллагуудыг 100 хувь хангасан. Мөн Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд 21 аймаг нийслэлийн 9 дүүрэг, УНТЭ, УГТЭ, ХСҮТ, ХӨСҮТөвд тус бүр нэг ширхэг нийт 34 ширхэг өндөр хүчин чадлын ЭХО аппарат, УНТЭ-т хагалгааны зориулалттай C-Arm аппарат, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 10 ширхэг үргийн зүрхний цахилгаан бичлэгийн аппаратыг эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлсэн. Түүнчлэн, Бельги Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Ховд аймаг дахь БОЭТ-д 54 нэр төрлийн 116 ширхэг эмнэлгийн зориулалттай автомашин тоног төхөөрөмж, нийлүүлэгдсэн бол Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн шугамаар сүрьеэгийн 9 нэр төрлийн 48 ширхэг тоног төхөөрөмжийг ХӨСҮТ, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн ЭМТ нийлүүлсэн. Мөн бэлгийн замаар дамжих халдварын лабораторийн тоног төхөөрөмжийг ХӨСҮТ, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэгт нийлүүлсэн. | |
| | | | Дэмжлэг үзүүлэх өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоо | - | | Өрхийн эрүүл мэндийг дэмжих хүрээнд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 13, 14 дүгээр хороо, Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, Хайлаастын 17 дугаар гудамжны өрхийн эмнэлэг, Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар баг, Түвшин холбоо эмнэлгийн барилгын ажилд нийт 6.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн гүйцэтгэж байна. Мөн Улаанбаатар хотын Багануур дүүргийн 1 дүгээр хороо, Сүхбаатар дүүргийн 7, 8, 9, 10 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдэд их засварын ажил хийж, Баянзүрх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүүргийн 4, 5, 6, 14, 15, 18, 25, 26 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдэд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллав. | |
| 15.6 | ЗГҮАХ-ийн 3.1.6 дахь заалт | Халдварт /сүрьеэ/ өвчнийг илрүүлэх, оношлох, эмчлэх | Эрт илрүүлэх үзлэгийг нэмэгдүүлэх, оношилж эмчлэх, хувиар | 50 | 1.8 Гадаад эх үүсвэр | Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд зорилтот бүлгийн хүн амын 52.0 хувь буюу 28,247 иргэнийг хамруулж, 212 шинэ тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулав. Сүрьеэ өвчний оношилгоонд орчин үеийн дэвшилтэт технологи Жене-Эксперт тоног төхөөрөмж, молекул биологийн арга нэвтрүүлэн 13,000 хүнд шинжилгээ хийн, 2,900 сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлж эмчилсэн. Ингэснээр 2 сарын хугацаанд оношилдог байсан эмд тэсвэртэй сүрьеэг 2 цагийн дотор оношилдог болоод байна. | 100 |
| 15.7 | ЗГҮАХ-ийн 3.1.6 дахь заалт | Сүрьеэгийн эмнэлгийн барилга шинээр барих /360 ортой/ | Шинээр байгуулах, эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар | 50 | - | 2019 оны улсын төсөвт сүрьеэгийн эмнэлгийн барилгад 10.0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд хэсэгчлэн тендер шалгаруулалтыг хуулийн хүрээнд 2019 оны 12 дугаар сард зохион байгуулж, 2020 оны 01 дүгээр сард багтаан гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулахаар ажиллаж байна. | 0 |
| Зорилт 16.Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 16.1 | МҮТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд зохион байгуулалттай болон хувь хүний ур чадварт түшиглэсэн ажлын байр бий болгох | Бий болох ажлын байрны тоо, мянга | 45.0-аас доошгүй | 30.5 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан<br><br>9.3 Гадаад эх үүсвэр | 1.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дараах 6 хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүллээ. Үүнд:<br>-Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр,<br>-Ажлын байрыг дэмжих хөтөлбөр,<br>-Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр,<br>-Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр,<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр,<br>-Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр болно.<br>Эдгээр хөтөлбөрүүдийг 2019 онд 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт хэрэгжүүлэхэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 35,646.8 сая төгрөгийг зарцуулж, 57902 иргэнийг хамруулахаар төлөвлөсөн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын байдлаар 74761 орчим иргэнийг хамруулж, 30,467.4 сая төгрөгийг зарцуулж, 13816 байнгын, 18167 түр ажлын байр бий болсон байна.<br>2.Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн | 70 |
| | | | Төсөл, хөтөлбөрт хамрагдах хүний тоо, мянга | 60.0 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ассоциаци хооронд байгуулсан санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 2 дугаар тогтоолоор баталсан бөгөөд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулан хэрэгжүүлэв. Уг хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэхэд Дэлхийн банкны санхүүжилтээр 13.7 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын байдлаар 9.3 тэрбум төгрөгийг зарцуулж, дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>-Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг нийслэлийн 6 дүүрэгт Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар зохион байгуулах бөгөөд сургалтын байгууллагуудыг сонгон шалгаруулах ажлыг 2 удаа зохион байгууллаа.<br>Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлийн эх үүсвэрийг 2019 онд 8.0 тэрбум төгрөг байхаар төсөвлөсөн бөгөөд жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банкийг 2019 оны 9 дүгээр сард сонгон шалгаруулж, Хаан банк болон Төрийн банканд 8.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг байршуулсан бөгөөд холбогдох хөтөлбөр, удирдамжид заасны дагуу 2019 оны 12 дугаар сараас иргэдэд олгов.<br>Орон нутгийн санаачилгын төслийг шалгаруулах удирдамж, ажлын хэсгийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар батлуулан 3 удаа шалгаруулалтыг зохион байгуулж, нийт 11 аймаг, дүүрэгт хэрэгжүүллээ. | |
| 16.2 | ЗГҮАХ-ийн 3.3.3 дахь заалт | “Гэрээт малчин” төсөл хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийг ажилтай, орлоготой болгох | Төсөлд хамрагдах гэрээт малчин өрхийн тоо | 1000 орчим | 5.5 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Цөөн толгой малтай залуу малчин өрхийг малжуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, тогтвортой мал маллахыг дэмжих зорилгоор “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүллээ.<br>“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд цөөн малтай болон гэрээт малчин өрхийг малжуулах арга хэмжээнд 1102 өрхийг хамруулан 5.5 тэрбум төгрөг, хөтөлбөрт хамрагдсан 1487 иргэнийг мал аж ахуй эрхлэх сургалт, туршлага солилцох уулзалтад хамруулан 436.0 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тус тус зарцуулсан байна. | 100 |
| 16.3 | ЗГҮАХ-ийн 3.3.6 дахь заалт | Монгол залуусаа сургаж | Гадаад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад | 20.0 | - | Бүтээн байгуулалтын ажил, төсөл, хөтөлбөр гүйцэтгүүлэхээр аж ахуйн нэгж байгууллагын гадаад улсаас ажиллах хүч оруулах захиалгын тоог 2020 онд 2016 оноос | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадын ажиллагсдын тоог бууруулах | олгох урьдчилсан зөвшөөрлийн тоог бууруулах, хувиар | | | 50 хувиар бууруулах зорилттой бөгөөд тэдний оронд Монгол иргэдээ дадлагажуулан ажлын байраар хангах арга хэмжээг хэрэгжүүлж байна.<br>Уг арга хэмжээний хүрээнд гадаадын мэргэжилтэй ажиллах хүчний хэрэгцээг дотоодын бүртгэлтэй ажилгүй иргэдээс хангах захиалгыг байгууллагуудаас гаргуулан, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж ажиллав.<br>Ингэснээр 2019 оны байдлаар гадаадаас авч ажиллуулж буй ажиллах хүч, мэргэжилтний тоо 2016 онтой харьцуулахад 48 орчим хувиар буураад байна. | 100 |
| 16.4 | ЗГҮАХ-ийн 3.4.9 дэх заалт | МСҮТ, Политехник коллежид элсэн суралцагчдын тоог нэмэгдүүлж, төгсөгчдөд мэргэжил, ур чадварыг эзэмшүүлэх, МСҮТ-ийн оюутнуудад 70000 төгрөг олгох | Мэргэжил, ур чадварыг эзэмшүүлэх төгсөгчдийн тоо, мянга | 20.0 | 18.5 тэрбум төгрөг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Мэргэжлийн болон техникийн боловсролын 84 сургалтын байгууллагад 2018-2019 оны хичээлийн жилд статистик мэдээгээр 38.526 суралцагч 16 салбарын 231 мэргэжлээр суралцаж, 22.086 суралцагч төгсөж, өмнөх оны төгсөгчдөөс 7.5 хувиар өссөн байна. Төгсөгчдөөс 2901 буюу 3.1 хувь нь техникийн боловсрол, 16043 буюу 72.7 хувь нь мэргэжлийн боловсрол, 3142 буюу 14.2 хувь нь мэргэжлийн сургалтад суралцаж мэргэжил, ур чадвар эзэмшсэн байна.<br>Засгийн Газрын 2007 оны 294 дүгээр тогтоолоор Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдад олгох тэтгэлгийн хэмжээг 23.0 мянган төгрөг, 2008 оны 30 дугаар тогтоолоор 45.0 мянган төгрөг, 2013 оны 329 дүгээр тогтоолоор 70.0 мянган төгрөгийн тэтгэлгийг 2016 оны 07 дугаар сар хүртэл олгож байсан. Тэтгэлгийг дахин олгохоор Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор тэтгэлгийн хэмжээг 100.0 мянган төгрөг болгон "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам"-ыг шинэчлэн баталсан.<br>2018-2019 оны хичээлийн жилд 84 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 38.5 мянган суралцагч суралцаж байгаагаас мэргэжлийн болон техникийн боловсролын түвшний өдрийн ангийн 35.4 мянган суралцагч, 2019-2020 оны хичээлийн жилд 80 мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад нийтдээ 37.5 мянган суралцагч суралцаж байгаагаас 36.6 мянган суралцагч мэргэжлийн болон техникийн боловсролын түвшний өдрийн ангид суралцаж байна. | 100 |
| 16.5 | МУТХҮБ-2030-ын 2.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь | Төрийн албан хаагчдын ажлын ачаалал, ур | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 24 дүгээр тогтоолоор 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | заалт | дүн, хариуцлага, ур чадварыг дээшлүүлж, инфляцийн түвшинтэй уялдуулан цалинг нэмэгдүүлэх | | | | төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг 2018 онд 8.0 хувиар нэмэгдүүлсэн албан тушаалын зэрэглэлийн сүлжээг 8.0 хувиар, нэмэгдүүлээгүй албан тушаалын сүлжээ, хэмжээг 16.6 хувиар тус тус нэмэгдүүлэн шинэчлэн тогтоов.<br>Эрүүл мэнд, боловсролын салбарт гүйцэтгэсэн ажлын ачаалал, хариуцлага, мэргэшлийн ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл зэрэг хүчин зүйлүүдийг харгалзсан ажлын байрны үнэлгээг үндэслэн Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн "Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 25 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"-ийг тус тус шинэчлэн тогтоосноор эдгээр салбаруудын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс 16.6-36.2 хувиар тус тус нэмэгдэв.<br>Тухайлбал, эмч нарын цалин хөлс 16.6-36.2 хувиар, сувилагч нарын цалин хөлс 20.0-30.0 хувиар, цэцэрлэгийн багш нарын цалин хөлс 26.3 хувиар, ЕБС-ийн багш нарын цалин хөлс 20.0 хувиар, мэргэжлийн боловсрол олгох сургалтын багш нарын цалин хөлс 21.0-28.3 хувиар, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын цалин хөлс 22.0 хувиар тус тус нэмэгдэв.<br>Цалин нэмэгдүүлэх энэ удаагийн арга хэмжээгээр төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлснээр төрийн албан хаагчдын сарын дундаж цалин хөлс 916.0 мянган төгрөг хүрч, 2018 оны түвшнээс 14.0 хувиар нэмэгдсэн байна.<br>УИХ-ын 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" 21 дүгээр тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид олгох зэрэг дэвийн нэмэгдлийн хувийг 2.0-13.0 хувиар нэмэгдүүлэн тогтоосны дагуу цалин хөлсийг нэмэгдүүлэв.<br>"Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн нэмэгдэл, нэмэгдэл хөлсний талаар 1995-2013 оны хооронд Засгийн газрын 13 удаагийн тогтоолоор баталсан нийт 16 журмыг Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн шинэчлэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулж, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар баталсан журмуудын дагуу 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс төрийн албан хаагчдад нэмэгдэл тогтоон олгож байна.<br>Төрийн албаны тогтвортой, мэргэшсэн байх зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл олгогдох боломжтой болсон.<br>2019 оны 6 дугаар сард төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл болон цалингийн хэмжээ, итгэлцүүрийг шинэчлэн тогтоох УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэн тус тус батлууллаа. | |
| 16.6 | ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жил тутамд нэмэгдүүлэх замаар иргэдийн орлогын түвшинг дээшлүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 11.0 Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 05 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөгдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс цагт 1904 төгрөг 76 мөнгө буюу 320000 төгрөг, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс цагт 2500 төгрөг 00 мөнгө буюу 420000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоолоо.<br>Цалин хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоогдож байгаа 80000-100000 ажиллагчдын цалин хөлс 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс 33.3 хувиар нэмэгдлээ. | 100 |
| 16.7 | МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт | Ядуу, эмзэг бүлэгт олгох нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 17.8 Улсын төсөв | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 27 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2018 оны хүн амын амьжиргааны түвшний хамгийн доод хэмжээ буюу 174.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Энэ нь нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэжээгч нь нас барсан хагас, бүтэн өнчин хүүхдүүд, 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхэд зэрэг нийгмийн халамж шаардлагатай иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд томоохон дэмжлэг болсон. | 100 |
| 16.8 | МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 1, | Ядуу хүн амын эрэлт хэрэгцээнд тохирсон халамжийн | Ядуурлаас гарах өрхийн тоо, мянган өрх | 16.0-гаас доошгүй | 57.0 Улсын төсөв | Ядуурлыг бууруулах хүрээнд:<br>Ядуу хүн амын эрэлт хэрэгцээнд тохирсон халамжийн хөтөлбөр, арга хэмжээг нэмэгдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэв.<br>-Зорилтот өрхийн нийгмийн халамжийн зардлыг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээг бүлэг тус бүрт ялгавартайгаар хүргэх | | | | бууруулахгүй байх үүднээс хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдүүдийн 85 хувь буюу 1 сая хүүхдэд 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгохоор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Үүний үр дүнд 35.0 орчим өрх хүүхдийн мөнгөн тэтгэмжид шинээр хамрагдах боломжтой болсон.<br>-Ядуу, эмзэг бүлэгт хүрдэг хүнсний эрхийн бичгийн хамрах хүрээг 2019 онд 2 дахин, мөнгөн дүнг 20 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Ингэснээр тус үйлчилгээнд 2016 оны байдлаар 26.0 мянга орчим өрх хамрагдаж байсан бол 2019 оны байдлаар 48.0 мянган өрх хамрагдаж байна. Үйлчилгээний хамрах хүрээ, мөнгөн дүнг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор холбогдох журамд өөрчлөлт оруулж, өрхийн зарим гишүүнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөл шалгуур тавьж, биелүүлсэн тохиолдолд хүнсний эрхийн бичгийг үргэлжлүүлэн олгохоор зохицуулсан. Үүний үр дүнд хүнсний дэмжлэгт хамрагддаг 48.0 мянган өрхийн хөдөлмөрийн насны гишүүд дараах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан байна. Тухайлбал: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөөнд 31.0 мянга, нийтийг хамарсан ажилд 13.0 мянга, мэргэжил олгох сургалтад 3.7 мянган иргэн, 10.0 мянган иргэн ажлын байранд зуучлагдсан зэрэг үр дүн гарсан байна.<br>-Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 11.0 мянга орчим хүүхэд байна. Эдгээр өрхийн хувьд эх, эцгийн аль нэг нь хүүхдээ асарч, хөдөлмөр эрхлэх боломжгүй нөгөө талаас эмчилгээ сувилгааны зардал их байдгийн улмаас өрхийн орлого буурч, ядууралд өртөх эрсдэл бий болдог бөгөөд тэдгээр өрхүүдийн 42 хувь нь ядуурлын шугамаас доогуур, 44 хувь нь ядуурлын шугамтай ойролцоо амьжиргаатай байна гэсэн судалгаа байдаг. Иймд эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээг 60 хувиар нэмэгдүүлсэн. Тус тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлснээр байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхийн санхүүгийн ачааллыг хөнгөлөх, өдөр тутмын эм тариа, асаргааны материал авах зардлыг хангахад бодит дэмжлэг болох юм.<br><u>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд:</u><br>Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүндрэлтэй зэрэг иргэдэд зориулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байртай, орлоготой болгох зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг тэдний онцлог, хэрэгцээнд нь нийцүүлэн хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд 2019 онд нийт 52420 орчим иргэнийг хамруулж, 25,626.3 сая төгрөгийг зарцуулж, 33325 ажлын байр бий болсон бөгөөд үүнээс 11,433 байнгын, 13658 түр ажлын байр бий болсон үзүүлэлттэй байна. | |
| 16.9 | ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт | Үнэ ханшны өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 119.5 Улсын төсөв | Тэтгэвэр, тэтгэмжийг үе шаттай нэмэгдүүлэх зорилтыг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 26 дугаар тогтоолоор хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлж бүрэн тэтгэврийн доод хэмжээг 310.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 270.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоолоо. Энэ арга хэмжээнд 410.0 мянга орчим тэтгэвэр авагч хамрагдаж, жилд 119.5 тэрбум төгрөгийг нэмж зарцуулав.<br>Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд 2019 оны улсын төсөвт 21.2 тэрбум төгрөг тусган баталсан. Засгийн газрын 2019 оны 27 дугаар тогтоолоор 2 дугаар сарын 1-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшинд хүргэж, 174000 төгрөг, асаргааны тэтгэмжийн хэмжээг 76000 төгрөг хүргэлээ. | 100 |
| 16.10 | ЗГҮАХ-ийн 3.3.34 дэх заалт | Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Сайн дураар даатгуулсан эх дундаж цалингаас тэтгэмж авах хувь | 100 | | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг цалин хөлснийх нь 70 хувиар тооцож байсныг УИХ-ын чуулганы 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар эхийг даатгуулсан хэлбэрээс нь үл хамаарч 100 хувиар тооцож олгохоор шийдвэрлэсэн. Уг хуулийн өөрчлөлтийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлнэ.<br>Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар уг арга хэмжээнд 4.7 тэрбум төгрөг зарцуулахаар батлав. | Үнэлэх боломжгүй |
| 16.11 | ЗГҮАХ-ийн 3.3.35 дахь заалт | Төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Эхчүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр УИХ-аас баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажилласан 1 жилийг 1.5 жилээр тооцох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | | | | хуулиар дараах өөрчлөлт оруулсан. Үүнд:<br>Төрүүлсэн болон 3 хүртэлх настайд нь үрчлэн авч, 6 нас хүртэл хүүхдээ өсгөсөн эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил 6 сарыг нэмж тооцохоор болсон. Энэ арга хэмжээг 2020 оны 01 дүгээр сарны 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэхээр шийдвэрлэсэн бөгөөд Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар ээжүүдийн тэтгэвэрт 6.0 тэрбум төгрөг зарцуулахаар батлав. | |
| 16.12 | ЗГҮАХ-ийн 3.3.35 дахь заалт | 0-3 насны хүүхдээ асарч буй ээжүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тасрахгүй байх нөхцөл бүрдүүлэх | Хамрагдах эхчүүдийн тоо | 50.0 мянгаас доошгүй | | Эхчүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр УИХ-аас баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар дараах өөрчлөлт оруулсан. Үүнд:<br>-Сайн дураар даатгуулсан эхийн хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас, 50 хувийг өөрөө, нийгмийн даатгалд даатгуулдаггүй эх хүүхэд асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг төрөөс, 50 хувийг өөрөө тус тус хариуцан төлөх харилцааг тус тус зохицуулсан болно.<br>Дээрх арга хэмжээг 2020 оны 01 дүгээр сарны 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлнэ.<br>Дээрх ээжүүдийн шимтгэлд нийт 16.2 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсан. | Үнэлэх боломжгүй |
| 16.13 | ЗГҮАХ-ийн 3.4 дэх заалт, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.1-4.3.9 дэх зорилт | Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлд чиглэсэн боловсрол, хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх | Боловсруулах төлөвлөгөө, стандартын тоо | 2 | | Гэр бүлд чиглэсэн боловсрол, хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүнд:<br>Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн бүтэц, агуулгыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/122 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна.<br>Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах, тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, хэм хэмжээг тогтооход чиглэсэн "Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" стандартыг шинэчлэн боловсруулж, Стандарт, Хэмжил зүйн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын С/07 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна.<br>Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлд зөвлөгөө өгөх нийт 22 төв ажиллаж байгаа бөгөөд 2019 онд тус | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвүүдээр нийт 75713 иргэн үйлчлүүлсэн байна.<br>Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангийн төслийн хүрээнд МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн оролцоотойгоор нийгмийн ажилтан бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөрт жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн боловсролын агуулгыг тусгасан сургалтын модуль гарын авлагыг боловсруулан, тус модулийг МУИС-ын Сургалтын Хөтөлбөрийн Хороогоор 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр батлуулан хэрэгжүүлж байна. Одоо нийгмийн ажлын болон бусад тэнхимийн 30 гаруй оюутан 2019 оны сүүлийн хагас жилд тус хичээлийг сонгон суралцаж байна.<br>Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэх хүрээнд "Монгол гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт сэдэвт судалгаа" болон "Монгол гэр бүлийн тулгамдсан асуудал, хэрэгцээ, үйлчилгээний хувилбар" судалгааг 2018-2019 онд хийлээ. Энэ судалгааны үр дүнг үндэслэн Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Хөтөлбөр нь гэр бүлийг дэмжих үйлчилгээний нэр төрлийг шинээр бий болгож, үйлчилгээг зорилтот гэр бүлд хүргэх зорилготой бөгөөд хөтөлбөрийн хүрээнд гэр бүлд чиглэсэн 6 төрлийн арга зүй /Архидалттай гэр бүлтэй ажиллах үйлчилгээний арга зүй, Хүчирхийлэлтэй гэр бүлтэй ажиллах үйлчилгээний арга зүй, Донтолтын тухай гарын авлага, Хүүхдийн асран хамгаалагчийг тогтоох мэргэжилтний гарын авлага, Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний практик арга зүй, Олон хэв шинжийн гэр бүлтэй ажиллах арга зүй зэрэг/ боловсруулан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүд, Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн удирдлага, ажилтнуудад гарын авлага болгон түгээсэн. Хөтөлбөрт нийт 8100 өрхийг сонгон, 7573 өрх буюу 93.4 хувьд нөхцөл байдлын үнэлгээ хийж, гэр бүлийн хөгжлийн төлөвлөгөөг өрх бүрээр шинэчлэн гарган хэрэгжүүлэв.<br>Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулгын төсөлд гэр бүлийг төрөөс дэмжих зорилгыг нэмж оруулсантай холбоотойгоор Гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр боловсруулах асуудлыг тусгасан. Хуулийн төслийг 2019 оны 04 дүгээр сарын 08-нд УИХ-д өргөн мэдүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16.14 | ЗГҮАХ-ийн 3.4.5 дахь заалт | Хүүхэд, өсвөр үеийнхэнд үндэсний өв соёлыг уламжлуулах, тэдний хүмүүжил, төлөвшилд чиглэсэн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх | Хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо | 5.0 мянгаас доошгүй | 0.403 Улсын төсөв | Хүүхэд, өсвөр үеийнхэнд үндэсний өв соёлыг уламжлуулах, бие даан амьдрах ур чадварт сургах, хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөрийг боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/150 дугаар тушаалаар батлуулав.<br>Тус хөтөлбөрийг хүүхдийн ордон, зуслангаар дамжуулан хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/57 дугаар тушаалаар хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалт зохион байгуулах ажлын удирдамжийг батлуулж, хүүхдийн зуслангийн захирлууд, арга зүйч, бүлгийн удирдагч, хүүхдийн хөгжлийн ордны арга зүйч, нийт 125 хүнд 24 цагийн арга зүйн сургалт зохион байгуулав.<br>Хөгжлийн хөтөлбөрийг 37 зусланд хэрэгжүүлж, 70 мянга гаруй хүүхэд хамрагдсан. Хөгжлийн хөтөлбөрийг ордон, зуслангаар дамжуулж хэрэгжүүлэхэд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өмнөговь, Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх хүүхдийн зусланд-127.6 сая төгрөг, Хэнтий аймгийн Монгол хүүхдийн гэр сургалт, зуслан, Баянгол дүүргийн Хүүхдийн төлөө амьдрах ухаан төвийн "Жаргалан" хүүхдийн зуслан сувилалд-24.6 сая төгрөг, Нийслэлийн ногоон бүсийн хүүхдийн зусланд-250.9 сая төгрөгийн санхүүжилтийг хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлсэн. | 100 |
| 16.15 | ЗГҮАХ-ийн 3.4.4 дэх заалт | Хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээ авч, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх | Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн явц, хувиар | 100 | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/116 дугаар тушаалаар гудамж талбайд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй эмзэг цэгүүдийг иргэд, олон нийтийн оролцоотой хяналтад авах зорилгоор "Хүүхэд хамгаалагч" туршилтын төслийг ЦЕГ, ХХҮЕГ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран хэрэгжүүлж байна. Тус төсөл нь Монгол Улсын Засгийн газраас зарласан "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн ажлын хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад ахмад настны оролцоо, хамтын ажиллагааг дэмжих зорилготой.<br>Иймд Ахмад настны тухай хуульд заасан "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-нд тулгуурлан Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн гүйцэтгэл, төлөвлөгөөг батлах тухай" 02 дугаар тогтоолоор төсвийг батлуулж, туршилтын байдлаар нийслэлийн 152 хороонд тус бүр 1 хүүхэд хамгаалагч, 21 аймагт тус бүр 2 хүүхэд хамгаалагч, нийт 1940 хүүхэд хамгаалагчийг ажиллуулахаар зардал, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэлээ.<br>Энэхүү "Хүүхэд хамгаалагч" туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 740.4 сая төгрөгийн зардал шаардлагатай бөгөөд Хүүхэд хамгаалагчдад олгох цалин хөлс урамшууллын зардал 456.3 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас, Хүүхэд хамгаалагч нарын сургалтын зардал, бичиг хэргийн зардал, олон нийтэд мэдээлэл хүргэх, гарын авлага, тараах материал, сурталчилгааны самбарын зардал 235.6 сая төгрөгийг Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн зардлаас, хүүхэд хамгаалагчдын нормын хувцасны зардал 48.5 сая төгрөгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн "Хүүхэд хамгаалагч туршилтын төслийг хэрэгжүүлэх тухай" А/116 дугаар тушаалд тусгалаа.<br>Энэхүү төслийг Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 1940 хүүхэд хамгаалагч хамтран хэрэгжүүлж байна.<br>Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг хүртээмжтэй чанартай хүргэх зорилгоор Архангай, Дархан-Уул, Дорнод, Дорноговь аймгийн Сайншанд, Сэлэнгэ аймгийн Мандал сум, нийслэлийн Баянзүрх дүүрэгт хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд батлагдсан төсвийн хуваарилалтад 113 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэв. Улсын хэмжээнд 18 түр хамгаалах байр, 11 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрны зардалд 284.3 сая төгрөгийн санхүүжилтийг зарцууллаа. | |
| 16.16 | ЗГҮАХ-ийн 3.4.11 дэх заалт | Залуучуудын хөгжлийн төвөөр | Хамрах хүрээний хүн ам, хувиар | 30.0 | | Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн дагуу аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн 32 төв нийт залуучуудын 28.3 хувь буюу 301292 залуучуудад хүрч ажиллалаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дамжуулан зорилтот бүлгийн өсвөр үе, залуучуудад амьдрах ухаан, эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол олгох сургалтад хамруулах | | | | Тухайлбал, "Эерэг хандлага-эрүүл оюутан" арга хэмжээнд 22780, "Ирээдүйн ээзд" арга хэмжээнд 26535, "Үлгэрч аав ээж" арга хэмжээнд 13900, амьдрах ухааны сургалт, эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол олгох сургалт, гэр бүлийн боловсрол олгох сургалтад 93205 залуучуудыг хамрууллаа.<br>Зорилтот бүлгийн залуучуудын хөгжил, хамгааллыг бэхжүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>-"Хорихоос суллагдсан өсвөр үе, залуучуудын нийгэмшүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулаа. Хөтөлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай Санамж бичиг байгуулан хамтран хэрэгжүүлэх бөгөөд орон нутаг дахь хэрэгжилт, зохион байгуулалтыг Залуучуудын хөгжлийн төвүүд хариуцах юм.<br>-Насанд хүрч, асрамж, халамжийн төвөөс гарч буй залуучуудын хөгжил, хамгааллыг дэмжих, нийгмийн амьдралд хөл нийлүүлэн амьдрах чадварыг сайжруулах зорилгоор "Асрамж халамжийн төвийн залуучуудын бие даан амьдрах чадварыг хөгжүүлэх жишиг хөтөлбөр"-ийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн удирдамжаар баталж туршилтаар хэрэгжүүлж эхлээд байна. Тус хөтөлбөрийн орон нутаг дахь хэрэгжилт, зохион байгуулалтыг Залуучуудын хөгжлийн төвүүд хариуцан хэрэгжүүлэх юм.<br>-Зорилтот бүлгийн 1587 залуучуудад сургалт, зөвлөгөө, холбон зуучлах үйлчилгээг үзүүлж, шүүхийн шийдвэрээр ял эдэлж байгаа 293, гэмт хэрэгт холбогдсон тэнсэн, харгалзах ял авсан 8, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 34 залуу, амьжиргааны түвшнээс доогуур 16 гэр бүлд амьдрах ухааны болон гэр бүлийн сургалтыг зохион байгуулав.<br>Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд заасан 5 чиглэлтэй уялдуулан 2022 он хүртэл хэрэгжүүлэх Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 171 дүгээр тогтоолоор батлууллаа.<br>"Нийгмийг өөрчлөх боловсрол" сарын аяны хүрээнд "Хүчээ нэгтгэе: Залуучуудын манлайлал" залуучуудын хөгжлийн үндэсний 5 дугаар чуулганыг 08 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгууллаа. Чуулганд залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, хот хөдөөгийн болон олон | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | улсын байгууллагын 600 гаруй зочид, төлөөлөгч оролцлоо.<br>Залуучуудын хөгжлийн төвийн 46 ажилтныг Peace Round хөтөлбөрийн хүрээнд сургалтад хамруулж 88 удаагийн сургалтаар ерөнхий боловсролын сургууль, оюутны байрны нийт 10676 өсвөр үе, залуучуудад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, сэтгэл зүйн сургалтыг зохион байгууллаа.<br>"Залуучуудын статистикийн нэгдсэн үзүүлэлт, түүнийг тооцох аргачлал"-ыг Үндэсний статистикийн хорооноос 2018 оны 12 дугаар сард баталсантай холбогдуулан залуучуудын мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх журмыг Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар хамтран батлан хэрэгжүүлж байна. Залуучуулын статистикийн нэгдсэн үзүүлэлт, түүнийг тооцох аргачлалд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг 8 бүлгийн нийт 129 үзүүлэлтийн арга зүйг тусгасан. Үүний дагуу залуучуудын мэдээллийн 16 үзүүлэлтийг маягтын дагуу бүх аймаг, дүүргээс 2018 оны тоон мэдээллийг авч нэгтгээд байна. Мөн маягтын дагуу судалгаа, мэдээллийг авах, боловсруулах, программд нэгтгэх чадавхыг бэхжүүлэх сургалтыг 2019 оны 11 дүгээр сард зохион байгуулж, бүх аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнууд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, түүний дэргэдэх Сургалт, судалгаа, мэдээллийн төвийн ажилтнуудыг хамруулллаа.<br>Оюутан, өсвөр үеийнхэнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх "Эерэг хандлага-эрүүл оюутан" аяныг улс даяар Залуучуудын хөгжлийн төвүүд 10 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Аяны хүрээнд 121 удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 22780 оюутан залуучуудыг хамруулсны 16.3 хувийг дотуур байранд амьдардаг оюутан, өсвөр үеийнхэн эзэлж байна. Аяны арга хэмжээг зохион байгуулснаар эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах залуучуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, эрүүл зан үйл, дадлыг төлөвшүүлснээс гадна үзлэг шинжилгээнд хамруулллаа.<br>Нийслэлийн Налайх дүүргийн Залуучуудын хөгжлийн жишиг төвийг 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр нээлээ. Тус төвийг байгуулах ажлыг 2019 оны 1 дүгээр улирал эхэлж, "Залуучуудын хөгжлийн төвийн үйл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа, орчин нөхцөлийн үнэлгээ" судалгааг 2 төрлийн 4 асуумжтайгаар боловсруулж, аймаг, нийслэл, дүүргийн Залуучуудын хөгжлийн 32 төвөөс авч нэгтгэв. Судалгааны дүгнэлтэд үндэслэн Залуучуудын хөгжлийн жишиг төвийн үйлчилгээний төрөл, хэлбэрийг тодорхойлох, орчин нөхцөлийг бүрдүүлэх, талуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх уулзалт, ярилцлага зэрэг ажлууд хийгдлээ. Үүний үр дүнд залуу гэр бүлийн хүндэтгэл, ёслолын өрөө, залуу хосод зөвлөгөө өгөх өрөө, амаржих эхэд зөвлөгөө өгөх өрөө, Энх төрөхүй өрөө, "Старт ап" залуучуудын гарааны бизнесийг дэмжих танхим, тогтвортой бизнес эрхлэгч залуучуудыг дэмжих танхим, уулзалтын 4 өрөө бүхий 100 м.кв талбайг эзлэх Залуучуудын хөгжлийн жишиг төвийг байгууллаа. | |
| 16.1 7 | ЗГҮАХ-ийн 3.3.22 дахь заалт | Төр, хувийн хэвшил, олон нийтийн дэмжлэгтэйгээр ахмад настны эрх, хөгжил, хамгааллыг сайжруулж, нийгмийн харилцаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар | 30.0 | | "Ахмад настны тухай хууль"-ийг хэрэгжүүлэх хүрээнд төр, хувийн хэвшил, олон нийтийн дэмжлэгтэйгээр ахмад настны эрх, хөгжил, хамгааллыг сайжруулж, нийгмийн харилцаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулан, Засгийн газрын 2019 оны 389 дүгээр тогтоолоор 2020 оноос хэрэгжүүлэхээр батлуулсан. | 40 |
| 16.1 8 | ЗГҮАХ-ийн 3.3.28 дахь заалт | Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох нөхцөлтэй орчныг бүрдүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар | 50.0 | 1.5 Улсын төсөв | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 8 зорилтын 116 арга хэмжээний хүрээнд улсын төсвөөс 1.5 тэрбум төсөвлөн бөгөөд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж чиг үүргийг хариуцан ажиллаж байна. Тус агентлагаас 2019 онд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 120 ажил арга хэмжээг зохион байгуулж гүйцэтгэсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах Ази, номхон далайн бүсийн 4 дүгээр Конгрессыг 2019 оны 7 дугаар сарын 02-03-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус конгресст гадаад, дотоодын 700 гаруй төлөөлөгч оролцсон. Үндсэн 3 сэдвээр 4 нэгдсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуралдаан, 13 салбар хуралдаан хийж, нийт 85 илтгэл хэлэлцэж, улс орнууд өөр өөрийн сайн туршлагаа хуваалцсан юм. Конгрессыг зохион байгуулах үндэсний болон олон улсын хороо хамтран конгрессоор хэлэлцсэн асуудлаар "Улаанбаатарыг тунхаглал" баримт бичгийг баталсан нь бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх чухал баримт бичиг болсон. Энэхүү бүсийн чуулганыг Монгол Улсад зохион байгуулснаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа бүс, дэлхий нийтийн хэмжээнд сурталчилсан томоохон арга хэмжээ болсон.<br>"Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг шалгаруулах журам"-ыг батлан хэрэгжүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ур чадварыг олон нийтэд сурталчлан таниулах "Career-expo 2019" арга хэмжээг зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох ээлтэй орчныг бүрдүүлэх үндэсний хөтөлбөр 2019 онд 70 хувьтай хэрэгжлээ. | |
| 16.1 9 | МУТХҮБ-2030-ын 2.2, ЗГҮАХ-ийн 3.3.27, 5.1.7 дахь заалт | Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, салбар дундын оролцоог дээшлүүлэх үүднээс Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 111 дүгээр "Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор Жендерийн үндэсний хорооны Ажлын албыг Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар шийдвэрлэсэн.<br>Ажлын байрыг жендерийн мэдрэмжтэй хөгжүүлэх бодлогын төслийг боловсруулж, батлан хэрэгжүүлэх ажлыг Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт 2019-2020 оны үндэсний хэлэлцээрт тусгалаа. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт болон холбогдох төр, төрийн бус байгууллагын төлөөлөл тус бодлогын төслийг дахин хэлэлцэж, батлан хэрэгжүүлэх талаар нэгдсэн зөвшилцөлд хүрлээ.<br>Үндэсний Статистикийн Хороотой хамтран жендерийн статистикийн үзүүлэлтийн хүрээ болон тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж ҮСХ-ны даргын 2019 оны А/173 тоот тушаалаар баталсан. Үзүүлэлтийн хүрээнд нийт 14 бүлгийн 241 үзүүлэлтийг хамруулав.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 60 дугаар захирамжаар "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвх оролцоо, тэднийг үнэлэх үнэлэмж, хандлага, гэр бүлийн хүрээнд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийх" ажлын хэсэг байгуулав. Ажлын хэсгийн гишүүд бодлогын түвшинд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, судалгаанд шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан бөгөөд судалгааг Дэлхийн банкны дэмжлэгээр Судалгаа шинжилгээний Эс Ай Си Эй (SICA) байгууллага хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн салбар яамд болон холбогдох төрийн бус байгууллагуудын төлөөллийг багтаасан дэд ажлын хэсгийг ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын даргаар ахлуулан байгуулж ажилласан. Үүний үр дүнд "Монгол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү, түүнд нөлөөлж буй хүчин зүйл" баримт бичгийн, чанарын судалгаа хийгдэж, судалгааны тайланг англи, монгол хэл дээр хэвлэн тараасан.<br>Жендерийн салбар зөвлөл, яам, агентлаг, харьяа байгууллагын түвшинд баримтлах жендерийн бодлого боловсруулах, батлуулах ажилд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж, 2019 онд 2 салбар жендерийн бодлогоо батлуулав. Тухайлбал, геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого болон батлан хамгаалах салбарын жендерийн талаар баримтлах бодлого батлагдав.<br>Жендерийн салбар хороо, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд баримтлах жендерийн дэд хөтөлбөр боловсруулах, батлуулах ажлын хүрээнд 2019 онд 4 аймгийн дэд хөтөлбөр батлагдаж, 3 аймаг дэд хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлээд байна.<br>Орон нутгийн түвшинд нийт 20 удаагийн сургалтаар 536 төрийн албан хаагчдад жендерийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт семинарыг зохион байгууллаа. | |
| 16.20 | ЗГҮАХ-ийн 3.3.11 дэх заалт | Багш, эмч нарын цалин, хөлсний менежментийг боловсронгуй болгох замаар үе шаттайгаар цалин, хөлсийг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Эрүүл мэнд, боловсролын салбарт гүйцэтгэсэн ажлын ачаалал, хариуцлага, мэргэшлийн ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл зэрэг хүчин зүйлүүдийг харгалзсан ажлын байрны үнэлгээг үндэслэн Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн "Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 25 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"-ийг тус тус шинэчлэн тогтоосноор эдгээр салбаруудын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс 16.6-36.2 хувиар тус тус нэмэгдэв. | |
| **ТАВ.ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО** | | | | | | | |
| Зорилт 17.Хууль тогтоомжийг боловсронгуй болгож, төрийн албаны тухай хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллана. | | | | | | | |
| 17.1 | Хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай үндсэн чиглэлийн 158, 161 дүгээр заалт | Шүүхийн шинжилгээний тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | Боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 2 | 0.058 Улсын төсөв | Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/17 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, тухайн хуулийн нэмэлт өөрчлөлт, үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулан, сайдад танилцуулав.<br><br>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан холбогдох яамдаас санал авсан. Хуулийн төслийг 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр "Хууль төрөхийн өмнө" олон нийтийн хэлэлцүүлгээр хэлэлцүүлж, хуулийн төсөлд холбогдох байгууллага, иргэдээс ирүүлсэн саналыг тусгаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлэн болгоод байна. | 40 |
| 17.2 | ЗГҮАХ-ийн 5.4.9 дэх заалт | Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 2.0 Улсын төсөв | 2019 оны төсвийн тухай хуульд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 4, 5, 14 дүгээр хороог 1.4 тэрбум, Баянгол дүүргийн 11, 15, 16, 17, 18, 19, 23 дугаар хороог 350.0 сая, Дархан-Уул аймгийн Дархан сум, 6, 7, 8, 9 дүгээр багийг 300.0 сая, нийт 2.05 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр гудамж, талбайг камержуулахаар заасан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/223 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны 2019 оны ерөнхий төлөвлөгөө"-ний дагуу дээрх байршилд камержуулалтын ажил хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг орон нутаг, дүүргийн Засаг дарга нарт шилжүүлсэн. Аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрууд түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулан, "Тотал технологи" ХХК-тай 289 сая, "Нью Терравокс" ХХК-тай 343.0 сая, "Инвестмент трейд энд финанс корпорэйшн" ХХК-тай 1.3 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу Дархан-Уул аймгийн 67 цэгт 125, Баянгол дүүргийн 43 цэгт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 104, Баянзүрх дүүргийн 112 цэгт 259 камер, хяналтын төвийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажил хийгдэх бөгөөд ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна. | |
| 17.3 | ЗГҮАХ-ийн 5.5.2 дахь заалт | Дотоодын цэргийн үйл ажиллагааг жигдрүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 2.5 Улсын төсөв | Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Дотоодын цэргийн 05 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын байр барихаар заасан. Ажлыг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлэн, санхүүжилтийг бүрэн хийж, 12 дугаар сарын 23-ны өдөр хүлээн авлаа. | 100 |
| 17.4 | ЗГҮАХ-ийн 5.4.14 дахь заалт | Хил хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техник хэрэгслийг нэвтрүүлэх | Буйр нуурын усан хил хамгаалалтад нийлүүлэх хөнгөн хөлгийн тоо | 2 | 1.0 Улсын төсөв | Маш нууц | 100 |
| | | | Орчин үеийн зэвсэг, галт хэрэглэлээр хангах үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 1.7 тэрбум төгрөг Улсын төсөв, хөрөнгө оруулалт | | |
| 17.5 | МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.1.10, 3.1.11 дэх заалт | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын материалаар хангах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 0.380 Улсын төсөв<br>0.180 Гадаад эх үүсвэр | Эрүүл мэндийг дэмжих төвийг тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, эмнэлгийн "А" блокын 5 давхарт 930 м.кв талбайд бүртгэл явуулах хэсэг, үзлэг, оношилгооны 7, хувцас солих 1, сэтгэл зүйн болон хоол шим тэжээлийн зөвлөгөө өгөх, сонсголын тус бүр 1 өрөөтэйгөөр байгуулан, үйл ажиллагааг явуулсан. Шаардлагатай тоног төхөөрөмж болох биохимийн, шээсний, электролит хэмжих бүрэн автомат анализатор, цээжний флюр зураг, ясны нягтрал тодорхойлох болон сонсголын аппаратаар хангаж, 3 эмч, 4 сувилагчийг орон тоогоор ажиллуулсан. 2019 онд нийт 4,126 үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийсэн байна. Тус эмнэлэг нь 2019 оны 7 дугаар сараас эхлэн өндөр өртөг бүхий 17 нэр төрлийн 168 мэс ажилбарын тусламж үйлчилгээг хийсэн. | 100 |
| 17.6 | ЗГҮАХ-ийн | Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе | Нэг иргэн-нэг | 20.0 | 0.104 | Улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон 30 суманд 56.3 сая орчим төгрөгийн үнэ бүхий иж бүрэн ширээний компьютер худалдан авч, бүртгэлийн үйлчилгээнд ашиглаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 5.2.10 дахь заалт | шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээний цогцолбор төв байгуулах | бүртгэл хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | | Гадаад эх үүсвэр<br>0.429<br>Улсын төсөв | Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн цахим сангийн хадгалалт, хамгаалалт, нөөцлөлтийг нэмэгдүүлэх болон цахилгаан тэжээлийн эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Делл И Эм Си Dell EMC төхөөрөмж, үйлчилгээний I байранд байрлах серверийн өрөөний цахилгаан тэжээлийг нөөц цахилгаан үүсвэр /генератор/-тэй холбон ажиллагаанд оруулсан. 2019 оны 11 дүгээр сарын байдлаар улсын бүртгэлийн нэгдсэн дотоод сүлжээнд 152 хороо, 242 сум суурин холбогдоод байна. Мөн 2019 ондоо багтаагаад техникийн нөхцөл хангасан 3 аймаг болох Баянхонгор аймгийн 13, Дорноговь аймгийн 8, Говьсүмбэр аймгийн 1 нийт 22 сумыг сүлжээнд холбохоор ажиллаж байна. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн 4,752,862 бичлэгээс 4,594,776 бичлэг шалгагдаж, засварлагдан хувиар шилжүүлэхэд 96.7 хувьтай байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 8,760 бичлэгээс 8,760 бичлэг шалгагдаж, засварлагдан хувиар шилжүүлэхэд 100 хувь, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2,312,080 бичлэгээс 2,312,080 бичлэг шалгагдаж. засварлагдан хувиар шилжүүлэхэд 100 хувьтай байна. | |
| 17.7 | ЗГҮАХ-ийн 5.3.7 дахь заалт | Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх | Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 30.0 | 0.1<br>Гадаад эх үүсвэр<br>0.04<br>Улсын төсөв | “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд иргэд хүссэн цагтаа, хүссэн газраасаа шаардлагатай мэдээлэл авах, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө мэдээллийн баталгаатай эх сурвалж болох эрх зүйн цахим мэдээллийн сан “e-khutuch.mn” портал цахим хуудсыг бүтээж, ашиглалтад оруулсан.<br>Тус цахим хуудасны агуулгыг баяжуулах ажлыг тогтмол тусгайлсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж 330 сумаас 300-аад сумын мэдээллийг оруулаад байна. Мөн Хөтөлбөрийн хүрээнд хийсэн богино хэмжээний 9 кино, үндсэн 15, 45 шторкийг интернет орчинд /youtbe.com, twitter.com, facebook.com/ 30 гаруй хуудсанд түгээгдэж, 300 гаруй группт байршуулсан бөгөөд NTV, ON, Сүлд телевизүүдээр тогтмол гаргаж байна. “Эрх зүйн хөтөч-Хууль Зүйн Луужин” фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан нийт 21 сэдэв хуулийг инфографик, комик, видео, хэлбэрээр сурталчилсан зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. “Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 тусгай дугаар”-т хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл авахаар 3335 иргэн холбогдсон байна.<br>“Иргэдийг эрх зүйн мэдлэгээр хангах үүрэг бүхий эрх зүйн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөч "сургагч багш" бэлтгэх сургалтыг 2019 оны жилийн эцсийн байдлаар 15 удаа зохион байгуулж, нийт 719 иргэнийг эрх зүйн хөтчөөр бэлтгэсэн. Дээрх ажлуудыг гүйцэтгэснээр "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2018-2019 оны нийт биелэлт 30 хувьд хүрч, шалгуур үзүүлэлтийг хангаж байна. | |
| 17.8 | ЗГҮАХ-ийн 5.1.11 дэх заалт | Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | Улсын Их Хурлын 2019 оны 07 дугаар тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн бүтцийг 4 газартай байхаар, орон тоог 56 албан хаагчтай байхаар баталсан. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 18 дугаар тогтоолоор Ажлын албаны албан тушаалын жагсаалтыг батлан, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны төсвийг 45 орон тоотой байхаар тооцож тусгасан. Одоогоор Төрийн албаны зөвлөл нь 35 албан хаагчтай ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн бүтэц орон тоо нь 2018 оны мөн үеийнхээс 17 орон тоогоор нэмэгдэн ажиллаж байна. | 100.0 |
| 17.9 | ЗГҮАХ-ийн 5.4.12 дахь заалт | Хууль сахиулах их сургуулийн спорт цогцолбор, номын сангийн барилгыг барих | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 2.4 Улсын төсөв | Хууль сахиулах их сургуулийн захирлын 2018 оны А/105 дугаар тушаалаар Их сургуулийн эзэмшлийн газарт шинээр "Спорт цогцолбор", "Төв номын сан"-гийн барилгын ажлын зураг төслийг мэргэжлийн "Зуун найм" ХХК байгууллагаар батлуулж, ажлын хэсэг 2019 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хуралдан сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалуудыг хянан үзэж үнэлсэн. Хууль сахиулах их сургуулийн "Спорт цогцолбор, номын сангийн барилга"-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Билгүүн монгол констракшн" ХХК-ийг сонгон шалгаруулж захиалагчид зөвлөмж хүргүүлснээр Хууль сахиулах их сургууль 2019/53 дугаартай гэрээг байгуулсан бөгөөд барилгын ажлын 2019 онд төлөвлөсөн ажил 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | 100 |
| Зорилт 18.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, стандарт хэмжил зүйн байгууллагын олон улсын итгэмжлэлийн үйл ажиллагааг сайжруулна. | | | | | | | |
| 18.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.1-2.1.3, 2.1.5, 2.1.7 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.7 дахь заалт | Ноос, ноолуур, арьс шир, оёмол бүтээгдэхүүн, аялал жуулчлал, хүнсний салбарын үндэсний стандартыг | Шинээр боловсруулж батлуулах стандарт | 5 | | Монгол Улсын үндэсний стандартыг шинээр боловсруулж, мөрдүүлэх хүрээнд 2019 онд дараах 8 стандартыг шинээр баталж, 1 техникийн зохицуулалтын төслийг боловсруулсан. Үүнд:<br>- "Ноос ноолуур, хялгас саваг хаяглах, тээвэрлэх. Техникийн шаардлага MNS 0215";<br>- MNS 6790:2019 Чанасан мах. Техникийн ерөнхий шаардлага;<br>- MNS 6294:2019 Зөгийн бал. Техникийн ерөнхий шаардлага; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинээр боловсруулж мөрдүүлэх | | | | - MNS 6741:2019. Ямааны ноолуур, тэмээний ноос, сарлагийн хөөврөн нэхмэл, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн. Техникийн шаардлага;<br>- MNS 0215:2019 Хонины ноосон даавуу. Техникийн шаардлага;<br>- MNS 5021-1:2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага стандарт;<br>- MNS 6777:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын нэр томьёо, тодорхойлолт;<br>- MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага стандарт зэрэг.<br>“Ноолуур” хөтөлбөрийг эрчимжүүлэх, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор боловсруулсан “Ноос ноолуурын худалдаанд тавих техникийн зохицуулалт”-ын төсөлд шүүлт хийж, Дэлхийн худалдааны байгууллагад 2019 оны 10 дугаар сард цахим санд мэдэгдэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх орон тооны бус Аялал жуулчлалын стандартчиллын техникийн хорооны 2019-2020 оны стандартчиллын ажлын төлөвлөгөөний дагуу Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019 стандартыг хянаж шинэчилсэн. | |
| 18.2 | МУТХҮБ-2030-ын 2.1.3, 2.1.5 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.8 дахь заалт, | Улсын эталоны нарийвчлалын түвшинг дээшлүүлж, баталгаажуулалтын болон эталон лабораторийг байгуулах | Шинээр байгуулах лаборатори | 2 | | Улсын эталоны нарийвчлалын түвшинг дээшлүүлж, баталгаажуулалтын болон эталон лабораторийг байгуулах хүрээнд дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Нягт, урт, цахилгаан, ээлэхүүний хэмжлийн эталон лабораторийг байгуулах 4 төслийг өмнө хийгдсэн суурь судалгаанд үндэслэн шинэчлэн боловсруулж, гадаад, дотоодын төсөлд хамруулахаар хүсэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн боловч дэмжигдээгүй.<br>Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэлээр нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 2, 3 дугаар бүсийн айл өрхийг угаарын хий /нүүрстөрөгчийн дутуу исэл, СО/ мэдрэгчээр хангах ажлын хүрээнд уг мэдрэгчийг хэмжлийн үнэн зөв, найдвартай ажиллагааг шалгаж турших ажлын эталоныг бий болгож, уг туршилтын ажлыг гүйцэтгэх лаборатори байгуулах төсөл боловсруулан шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад хүргүүлсэн. | 40 |
| 18.3 | МУТХҮБ-2030- | Олон улсын | Нэгдэн орох | 2 | | Засгийн газрын 2004 оны 253 дугаар тогтоолын дагуу Ази | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ын 2.1.3, 2.1.5 дахь заалт , ЗГҮАХ-ийн 2.8 дахь заалт | итгэмжлэлийн байгууллагын хэлэлцээрт нэгдэх | хэлэлцээр | | | номхон далайн лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (APLAC), Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (ILAC)-ын Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт 2012 оноос, Засгийн газрын 2013 оны 196 дугаар тогтоолын дагуу Олон улсын итгэмжлэлийн форум (IAF)-ын Олон талт хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт 2018 онд тус тус нэгдсэн.<br>Дээрх байгууллагуудаас Монгол Улсын итгэмжлэлийн тогтолцоо нь 2018 онд шинэчлэгдсэн "Тохирлын үнэлгээ-Тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжлэх итгэмжлэлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага ISO/IEC 17011" стандартын шаардлагад үргэлжлэн нийцэх эсэхэд 2020 оны 4 дүгээр сард ижил түвшний үнэлгээ хийх бөгөөд шинэчилсэн үнэлгээг хийлгэх, хэлэлцээрт нэгдсэн статус, гишүүнчлэлийн эрхээ хадгалах хүрээнд 2019 онд Чанарын гарын авлага, Нэгж дамжуулалтын бодлого, Ур чадварын сорилтын бодлого, Техникийн хорооны ажиллах журам, Үл тохирлыг хянах, залруулах ажиллагааны журам, Үнэлгээний мэргэжилтний мэргэшил, ур чадварын журам зэрэг 17 журмыг шинээр баталсан.<br>"Монголын худалдааг дэмжих төсөл"-ийн хүрээнд 2019 оны 6 дугаар сарын 3-6-ны өдрүүдэд "Үнэлгээний тэргүүлэх мэргэжилтэн бэлтгэх сургалт"-ыг зохион байгуулсан.<br>Стандарт, хэмжил зүйн газар нь дээрх байгууллагуудын хэлэлцээрт нэгдсэн статусаа хадгалах үүрэг хүлээдэг ба хэрэв хэлэлцээрт нэгдсэн статусаа алдсан тохиолдолд Монгол Улсаас гадаад улсад экспортолж байгаа бүтээгдэхүүнд худалдан авагч улс орон өөрийн зүгээс сорилт, шинжилгээ гүйцэтгэх, тохирлын үнэлгээг давтан хийх улмаар худалдаанд төрөл бүрийн техникийн саад тотгор үүсэх нөхцөлийг бий болгох сөрөг талтай юм. | |
| 18.4 | ЗГҮАХ-ийн 5.2.1 дэх заалт | Төрийн өмчийн талаархи бодлого боловсруулан хэрэгжүүлэх, удирдлага менежментийг сайжруулах, төрийн өмчит болон төрийн | Шинэчлэн найруулах хууль | 1 | | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/107 дугаар тушаалаар байгуулж, хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага, аргачлалын дагуу боловсруулан 2019 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн А-1/1252 албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах үйл ажиллагааг ил тод болгох, өрсөлдөх тэгш боломжоор хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох | | | | Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | |
| | | | Нэмэлт, өөрчлөлт оруулах журам | 1 | | - “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулав.<br>- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг боловсронгуй болгох төсөл боловсруулж 2019 оны 260 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Энэхүү журмын хүрээнд компанийн удирдлагын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, улсын төсөвт төвлөрүүлсэн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлалыг уг журмын хавсралтаар баталсныг мөрдүүлж байна. Шинэчлэгдсэн журмын дагуу 21 төрийн өмчит үйлдвэрийн газар, 24 төрийн өмчит компанийн захиралтай 2019 оны контрактыг байгуулсан.<br>- Засгийн газрын 2018 оны 388 болон 2019 оны 46 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 онд хэрэгжүүлэх 169 төсөл, арга хэмжээнээс 168 (99.4 хувь) төсөл, арга хэмжээний зураг, төсөл болон тендер зарлахад шаардлагатай бусад материалыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсний дагуу үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг эхлүүлснээс 152 (90.0 хувь) төсөл, арга хэмжээний тендерийг зарлаж, худалдан авах ажиллагааг 100.0 хувь цахим хэлбэрээр буюу төрийн худалдан авах ажиллагааны цахим систем Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зохион байгуулсан. Эдгээрээс 20 төсөл, арга хэмжээний тендерт оролцогч 39 аж ахуйн нэгжээс дотоодод үйлдвэрлэсэн, чанар, стандартын шаардлага хангасан 9.4 тэрбум төгрөгийн бараа, материал, бүтээгдэхүүнийг ажил гүйцэтгэхдээ ашиглахаар санал ирүүлсэнд дотоодын давуу эрхийн зөрүүг тооцож, тендерийн үнэлгээ хийсэн.<br>- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2019 онд 2,035 захиалагч байгууллагын хэрэгжүүлэх 27,017 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөө цахим системд бүртгэгдэж, нийт 17,371 тендер шалгаруулалтын үр дүн олон нийтэд мэдээлэгдсэн бол бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд 27,085 бараа, ажил, үйлчилгээ, 5,077 гэрээ тус цахим системд бүртгэгдсэн байна. Түүнчлэн тус системийн дэд систем болох "Цахим дэлгүүр"-ээр нийт 2,223 удаагийн захиалга хийгдэж, 31 нэр төрлийн 8.9 тэрбум төгрөгийн эм, борлуулагдаж, улсын төсөвт 464.9 сая төгрөгийн хэмнэлт гарчээ. | |
| Зорилт 19.Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэхийн зэрэгцээ хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлнэ. | | | | | | | |
| 19.1 | Гадаад бодлогын үзэл баримтлал /цаашид "ГБҮБ" гэх/ 3.21.6 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.6.5, 5.6.7 дахь заалт | Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх | Замын-Үүд-Эрээний чөлөөт бүс байгуулах ажлын явц, хувиар | 80.0 | 0.0083 Улсын төсөв | Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>- "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн Монголын талын төсөлд хятадын талаас 2019 оны 2 дугаар сарын 2-ны өдөр зарчмын хувьд дэмжиж, тодорхой санал ирүүлснийг ажлын хэсгээс судлан хариу төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар 2019 оны 3 дугаар сарын 6-ны өдөр хэлэлцүүлсэн. Улмаар хэлэлцээрийн төслийг боловсруулах хоёр талын ажлын хэсэг БНХАУ-ын Бээжин хотноо 2019 оны 3 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд хэлэлцээ хийн нэгдсэн байр сууринд хүрч, хэлэлцээрийн төслийг үзэглэсэн. "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, БНХАУ-ын Засгийн газрыг төлөөлөн Худалдааны сайд Жун Шань нар 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Бээжин хотноо гарын үсэг зурсан.<br>- Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг *(нэр томьёоны өөрчлөлт)* боловсруулж 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж гарсан шийдвэрийн дагуу ЗГХЭГ-ын 2019 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн ДГ-1/144 албан бичгээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх 30.0 сая ам.долларын төслийн ерөнхий хэлэлцээрт 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр талууд гарын үсэг зурсан. | |
| 19.2 | ЗГҮАХ-ийн 5.6.5, 5.6.8 дахь заалт | Монголын бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тарифын болон тарифын бус хязгаарлалтыг бууруулах | Яриа хэлэлцээр хийх орон | 2 | - | Монголын бараа, бүтээгдэхүүнийг таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тарифын болон тарифын бус хязгаарлалтыг бууруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:<br>- Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хэлэлцүүлж, Улсын Их Хурлаар 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр соёрхон баталсан.<br>- БНСУ-ын Ерөнхий сайд Ли Наг Ён-ы Монгол Улсад хийсэн айлчлалын тухай үеэр 2019 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломж, нөөц бололцоо байгааг талууд тэмдэглэж, хорио цээрийн стандартыг жигдрүүлэх, худалдааны тэнцвэргүй байдлыг арилгах асуудлыг цаашид Монгол, Солонгосын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрээр дамжуулан шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх чиглэлд хамтран ажиллахаар тохиролцсон. Үүний дагуу БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлэхэд монголын тал бэлэн байгаа талаарх А/18/238 тоот ноот бичгийг солонгосын талд 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр илгээж, Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яаманд чиглэл өгсөн. Түүнчлэн 2019 оны 6 дугаар сард зохион байгуулсан хоёр улсын Засгийн газар хоорондын комиссын хуралдааны үеэр монголын тал хэлэлцээг эхлэхэд бэлэн байгааг нотолсон.<br>- Монгол Улс, БНХАУ хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийн талаар хамтарсан судалгаа хийх хоёр талын хамтарсан судалгааны багийн хоёрдугаар уулзалтыг БНХАУ-ын Бээжин хотноо 2019 оны 2 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулж, хамтарсан судалгааны ерөнхий хүрээ, бүтцийг тохиролцсон. Түүнчлэн судалгааны төлөвлөгөөний дагуу хоёр талаас бэлтгэсэн мэдээллийн эхний төслийг харилцан солилцсон. Чөлөөт худалдааны хэлэлцээрийн эдийн засгийн үр өгөөжийн судалгааг олон улсын бие | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даасан шинжээчээр 2019 оны 5 дугаар сард, МУИС-ийн Бизнесийн сургуулийн багаар 2019 оны 12 дугаар сард гүйцэтгүүлж, судалгааны зардлыг Европын холбооны санхүүжилттэй "Монгол Улсын худалдааг дэмжих" төслөөс санхүүжүүлсэн. Захиалгат судалгааны дүнг цаашид хамтарсан судалгааны ажлын дүгнэлт, ЧХХ байгуулах эсэх талаар байр сууриа эцэслэн гаргахад харгалзана. | |
| 19.3 | ГБҮБ-ын 2.14.1 дэх заалт, ЗГҮАХ-ийн 5.6.2 дахь заалт | Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын "Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 0.12 Улсын төсөв | Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг 2019 онд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>- Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Гадаад харилцааны дэд сайд нарын түвшний ээлжит уулзалт 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Бээжин хотноо болж, Монгол Улсын Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг, ОХУ-ын Гадаад хэргийн орлогч сайд И.В.Моргулов, БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Жан Ханьхуй нар гурван талын төлөөлөгчдийг тэргүүлж оролцсон. Уулзалтаар манай талаас "Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг урагшлуулах талаар тодорхой саналууд дэвшүүлсэн.<br>- Гурван улсын Хөрөнгө оруулалтын судалгааны төвийг байгуулах үзэл баримтлалын болон төвийн дүрмийн монголын талын төслийг бэлтгэн, орос болон хятадын талд 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлэв.<br>- Гурван улсын "Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төв /ХОЗТХТ/"-ийг байгуулах үзэл баримтлалын монголын талын төслийг орос болон хятадын талд 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлсэн.<br>- Засгийн газрын 2017 оны 262 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны дэргэд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг 2019 оны 3 дугаар сараас эхлэн 5 орон тоотой явуулж байна. Өнгөрсөн хугацаанд экспертүүдийн уулзалтаар ярилцаж тохиролцсон төмөр замын төв коридорын монголын талд хамаарах хэсгийн төлөвлөгөөний төслийг ОХУ-ын "Мосгипротранс" зураг төслийн институтээр хийлгэх ажлыг "УБТЗ" ХНН-тэй хамтарч хэрэгжүүлэх, хятадын талтай харилцан тохиролцох, ОХУ-аас эхтэй байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан БНХАУ-д хүргэх талаар байгуулагдсан Засгийн газрын ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллах, Монгол | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр байгалийн хийн хоолойн салбарт хамтран ажиллах тухай (2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн) санамж бичгийг ОХУ-ын Газпром ХНН-ийн охин компани болох "Красноярскнефвтьгазпроект" ХХК-тай байгуулах, мөн БНХАУ-ын CNPC компанийн зураг төслийн компанитай холбоо тогтоож хамтран ажилласан.<br>- Түүнчлэн Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан Азийн авто замын АН3 маршрутаар хийх тээвэрлэлтийг нэмэгдүүлэх асуудлыг судлах үүрэг бүхий дотоодын эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн ажлын хэсгийг хөрөнгө оруулалтын судалгааны төвийн 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн Б/17 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн дэргэд байгуулж, ОХУ-ын Буриадын Тээврийн яамнаас байгуулсан ижил төрлийн ажлын хэсэгтэй холбоо тогтоон судалгааны хамтарсан ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Цаашид энэхүү төв нь гурван улсын "Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төв болон өргөжиж, "Эдийн засгийн коридор"-ын хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх, урьдчилсан ТЭЗҮ боловсруулах зэрэг хэлбэрээр олсон үйл ажиллагааны орлогоор санхүүжих юм. | |
| 19.4 | ГБҮБ-ын 6.27.5 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.3.12, 5.6.9, 5.6.12 дахь заалт | Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх | Шинээр нээж ажиллуулах Ерөнхий консулын газар | 2 | 0.44 Улсын төсөв | Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгох чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 16 дугаар тогтоолоор БНХАУ-ын Шанхай хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулахаар шийдвэрлэж, 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр үйл ажиллагааг эхлүүлсэн.<br>- БНХАУ-ын Манжуур хотод Консулын газар нээх асуудлыг 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар, 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн бөгөөд хятадын талд А/19-2242 тоот ноот бичгийг 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр илгээж, 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Манжуур дахь Консулын газрыг нээх зөвшөөрөл бүхий хариуг хятадын талаас ирүүлсэн.<br>- Монгол иргэд олноор оршин суугаа Австрали, Швед, Чех, Франц Улсад суугаа ЭСЯ-ны бүтцэд Консулын хэлтэс байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүрээнд яамдаас санал авч нэгтгэсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Түүнчлэн АНУ-ын Чикаго хотод Ерөнхий консулын газар нээх асуудлаар Монгол Улсаас тус улсад суух Элчин сайдын яамнаас АНУ-ын талтай санал солилцож ажилласан. Канад Улсын Ванкувер хотод Ерөнхий консулын газар нээх шаардлага үүсээгүй гэсэн шалтгаанаар уг асуудал түр хугацаагаар хойшилсон. | |
| | | | Нэмэлт, өөрчлөлт оруулах дүрэм | 1 | | Улсын Их Хурлын 2002 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын консулын дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал 2016 оноос хойш судалгааны шатанд байгаа бөгөөд энэ хүрээнд гадаадын улс орнуудын туршлага судлах судалгаа, мэдээллийг Дипломат төлөөлөгчийн газруудаас авч нэгтгэсэн. Дэлхийн консулын форумыг Улаанбаатар хотноо 2020 оны 6 дугаар сард зохион байгуулж, гадаадын 44 улс, Европын холбооны төлөөлөл консулын харилцаа, хамтын ажиллагаа, иргэдийн эрх ашгийг хамгаалах талаар дэлхийн чиг хандлага, сайн туршлагыг хэлэлцэхээр төлөвлөсөн бөгөөд үүнтэй холбогдуулан "Монгол Улсын консулын дүрэм"-д зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай зүйл, заалт, практикт учирч буй бодит хүндрэл зэргийг харгалзахын зэрэгцээ консулын хамгаалалтын талаарх олон улсын чиг хандлага, хилийн чанад дахь монгол иргэдэд чиглэсэн бодлого зэрэг асуудалтай уялдуулан цогцоор нь боловсруулж, шийдвэрлүүлэхээр төлөвлөж байна. | |
| Зорилт 20.Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлж, зэвсэгт хүчний барилгын засвар төслийг хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 20.1 | ЗГҮАХ-ийн 5.5.5 дахь заалт | Зэвсэгт хүчний энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 2.8 Улсын төсөв 9.7 Зэвсэгт хүчний хөгжлийн сан 9.6 Гадаадын зээл, тусламж | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 100 |
| 20.2 | ЗГҮАХ-ийн 5.5.6 дахь заалт | "Барилгын засвар" төслийг хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 1.9 Улсын төсөв | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэгтгэл, анги, салбаруудын барилга, байгууламжийн их засварын ажлыг зохион байгуулах | | | | | |
| 20.3 | ЗГҮАХ-ийн 5.5.5дахь заалт | НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд инженерийн ротыг бэлтгэж, оролцуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 4.1 Гадаад эх үүсвэр | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 70 |
| 20.4 | ЗГҮАХ-ийн 5.5.6 дахь заалт | Материал, хэрэгслийн нөөцийг зэвсэгт хүчний хэмжээнд оновчтой шилжүүлэн байршуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 70 |
| 20.5 | ЗГҮАХ-ийн 5.5.2, 5.5.10 дахь заалт | Зэвсэгт хүчний лабораторийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2030/-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 10.0 | - | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 100 |

-----oOo-----